



МОНГОЛ УЛСЫН
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН
ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙГ БҮРТГЭХ, ХАДГАЛАХ
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАНД ЗОРИУЛСАН

ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот
2025 он



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

**Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө,
орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий
албан тушаалтанд зориулсан**

ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот
2025 он

DDC
340'015
Э-81

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛАВ.

©2025

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд зориулсан ГАРЫН АВЛАГА

Эмхэтгэсэн:

Ц.БААСАНДЭЛГЭР	АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар
----------------	--

Хянасан:

Т.ЭНХБОЛД	АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар
-----------	---

Б.БАЯРСАЙХАН	АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн албаны дарга, ахлах комиссар
--------------	---

Манай хаяг:	210644 Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Сөүлийн гудамж - 41 Монгол Улсын Авлигатай тэмцэх газар Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс
--------------------	--

Харилцах утас:	70112489, 70110252
-----------------------	--------------------

Хэвлэсэн тоо: 3000 ширхэг
Хэвлэлийн хуудасны тоо: 12.5хх
Хэвлэсэн газар: “Урангар Пресс” ХХК
Эх бэлтгэсэн: Б.Тамир

ISBN 978-99973-832-2-8

Авлигын эсрэг НҮБ-ын конвенц

Удиртгал

Энэхүү конвенцод Оролцогч улсууд нь,

Авлига нь нийгмийн тогтвортой, аюулгүй байдалд бэрхшээл, аюул занал учруулж, улмаар ардчиллын тогтолцоо ба үнэт зүйлс, ёс зүйн үнэт зүйлс, шударга ёсыг доройтуулан сулруулж, тогтвортой хөгжил, хууль дээдлэх ёсонд хохирол учруулахуйц байгаа ноцтой байдалд *сэтгэл зовниж,*

Авлига нь бусад гэмт хэрэг, ялангуяа зохион байгуулалттай гэмт хэрэг ба эдийн засгийн гэмт хэрэг, үүний дотор мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой байдагт *мөн сэтгэл зовниж,*

Улс орнуудын нөөц баялгийн үлэмж хэсгийг бүрдүүлэхуйц их хэмжээний хөрөнгөтэй холбоотой бөгөөд улс орнуудын улс төрийн тогтвортой байдал, тогтвортой хөгжилд заналхийлж буй авлигын хэргүүд гарч буйд *цаашид сэтгэл зовниж,*

Авлига нь улсын дотоод асуудлаас нэгэнт хальж, бүх улс орнуудыг дамнан нийгэм, эдийн засагт нь сөргөөр нөлөөлөх үзэгдэл болсон тул түүнээс урьдчилан сэргийлж, хяналтдаа авахад олон улсын хамтын ажиллагаа зайлшгүй чухал гэдэгт *итгэл төгс байж,*

Авлигаас үр дүнтэй урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэхэд иж бүрэн, олон талт хандлага шаардлагатай гэдэгт *мөн адил итгэл төгс байж,*

Цаашилбал техникийн туслалцаа авах боломж нь авлигаас үр дүнтэй урьдчилан сэргийлж, тэмцэхийн тулд чадавхыг бэхжүүлэх, тогтолцоог бүрдүүлэх зэргээр улсуудын боломж, чадварыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж болно гэдэгт *итгэл төгс байж,*

Хууль бусаар хувьдаа эд баялаг олж авах нь ардчилсан тогтолцоо, үндэсний эдийн засаг, хууль дээдлэх ёсонд хохирол учруулж болно гэдэгт *итгэл төгс байж,*

Хууль бусаар олж авсан хөрөнгийг улс хооронд шилжүүлэхээс үр дүнтэй хэлбэрээр урьдчилан сэргийлж, илрүүлж, таслан зогсооход болон хөрөнгийг буцаах чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд *шийдвэр төгс байж,*

Хөрөнгийн эрхийг эцэслэн тогтооход эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон иргэний эсхүл захиргааны хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны тулгуур зарчмуудыг ашиглахыг *хүлээн зөвшөөрч,*

Авлигаас урьдчилан сэргийлж, түүнийг устгах нь бүх улс орны үүрэг хариуцлага мөн бөгөөд хэрэв иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагууд зэрэг хувь хүмүүс, тэдний нэгдэлд тулгуурласан нийтийн албанаас гадуурх байгууллагууд энэ чиглэлээр үр дүнтэй ажиллаж байгаа бол бүх улс тэдний дэмжлэг, оролцоотойгоор хоорондоо хамтран ажиллах ёстойг *санан,*

Төрийн бодлого, төрийн болон орон нутгийн өмчийг зохистойгоор удирдах, хуулийн өмнө шударга, хариуцлагатай, эрх тэгш байх зарчим, үнэнч шударга байх шаардлага, авлигыг үл зөвшөөрөх соёлыг хөгжүүлэх хэрэгцээг *мөн санан,*

Авлигаас урьдчилан сэргийлж, тэмцэх талаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн эрх зүйн комисс болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас хийсэн ажлыг *магтан сайшааж,*

Энэ салбарт олон улсын болон бүс нутгийн бусад байгууллагаас хийсэн ажил, түүний дотор Африкийн холбоо, Европын зөвлөл, Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл (Дэлхийн гаалийн байгууллага хэмээн өөрөөр нэрлэдэг), Европын холбоо, Арабын лиг, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Америкийн улсуудын байгууллагын үйл ажиллагааг *эргэн санаж,*

Авлигаас урьдчилан сэргийлж, тэмцэх талаарх олон талт баримт бичиг, түүний дотор, тухайлбал, Америкийн улсуудын байгууллагаас 1996 оны 3 дугаар сарын 29-ний өдөр баталсан Авлигын эсрэг Америкийн улсууд хоорондын конвенц, Европын Холбооны Зөвлөлөөс 1997 оны 5 дугаар сарын 26-ны өдөр баталсан Европын хамтын нийгэмлэгийн албан тушаалтан эсхүл Европын Холбооны гишүүн улсын албан тушаалтанд холбогдох авлигатай тэмцэх тухай конвенц, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас 1997 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр баталсан Олон улсын бизнесийн хэлцэлд гадаадын нийтийн албан тушаалтныг хахуульдахтай тэмцэх тухай конвенц, Европын Зөвлөлийн Сайд нарын хорооноос 1999 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр баталсан Авлигын талаарх эрүүгийн эрх зүйн тухай конвенц, Европын Зөвлөлийн Сайд нарын хорооноос 1999 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр баталсан Авлигын талаарх иргэний эрх зүйн тухай конвенц, мөн Африкийн Холбооны Төр, засгийн тэргүүнүүдийн 2003 оны 7 дугаар сарын 12-ны өдөр баталсан Авлигаас урьдчилан сэргийлж, тэмцэх тухай Африкийн Холбооны конвенцыг *сайшаан тэмдэглэж*,

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц 2003 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр хүчин төгөлдөр болсныг *нааштай хүлээн авч*,

Дараах зүйлийг тохиролцов. Үүнд:

I БҮЛЭГ

Ерөнхий заалт

1 дүгээр зүйл. Конвенцын зорилго

Энэхүү конвенцын зорилго нь:

(a) авлигаас илүү үр ашигтай бөгөөд үр дүнтэйгээр урьдчилан сэргийлж, тэмцэх арга хэмжээг хөхиүлэн дэмжиж, бэхжүүлэх;

(b) авлигаас урьдчилан сэргийлж, тэмцэх, түүний дотор хөрөнгө буцаах асуудлаар олон улсын хамтын ажиллагаа, техникийн туслалцааг идэвхжүүлэн бэхжүүлж, саадгүй хялбар явуулах, дэмжих;

(c) төрийн бодлого, төрийн болон орон нутгийн өмчийг үнэнч шударга, хариуцлагатай, зөв зохистойгоор удирдан зохицуулахад түлхэц үзүүлэхэд оршино.

2 дугаар зүйл. Нэр томъёог хэрэглэх

Энэхүү конвенцын зорилгоор:

(a) “Нийтийн албан тушаалтан” гэж: (i) Оролцогч улсын хууль тогтоох, гүйцэтгэх, төрийн захиргааны болон шүүхийн албан тушаалд томилогдон буюу сонгогдон, байнга эсхүл түр хугацаагаар, цалин хөлсөөр болон цалин хөлсгүй ажилладаг аливаа хүнийг албан тушаалын зэрэглэлээс нь үл хамааран; (ii) Оролцогч улсын үндэсний хууль тогтоомжид тодорхойлсны дагуу болон тухайн Оролцогч улсын холбогдох салбарт хэрэглэж байгаа эрх зүйн зохицуулалтын дагуу нийтийн албаны чиг үүрэг гүйцэтгэдэг нийтийн албаны байгууллага болон улсын үйлдвэрийн газарт нийтийн албаны чиг үүрэг, төрийн ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг аливаа бусад хүнийг; (iii) Оролцогч улсын үндэсний хууль тогтоомжид “нийтийн албан тушаалтан” гэж тодорхойлсон аливаа бусад хүнийг тус тус хэлнэ. Харин энэхүү конвенцын II бүлэгт заасан зарим тодорхой арга хэмжээний зорилгоор “нийтийн албан тушаалтан” гэж Оролцогч улсын үндэсний хууль тогтоомжид тодорхойлсны дагуу болон тухайн Оролцогч улсын холбогдох салбарт хэрэглэж байгаа эрх зүйн зохицуулалтын дагуу нийтийн албаны чиг үүрэг, төрийн ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг аливаа хүнийг хэлж болно;

(b) “Гадаад улсын төрийн албан тушаалтан” гэж гадаад улсын хууль тогтоох, гүйцэтгэх, төрийн захиргааны, шүүхийн албан тушаалд томилогдон буюу сонгогдон ажилладаг аливаа хүнийг; түүнчлэн гадаад улсад зориулж, түүний дотор төрийн байгууллага эсхүл улсын үйлдвэрийн газарт харьяалагдан нийтийн албаны чиг үүрэг хэрэгжүүлж буй аливаа хүнийг хэлнэ;

(c) “Олон улсын байгууллагын албан тушаалтан” гэж тухайн олон улсын байгууллага өөрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах эрхийг олгосон олон улсын нийтийн албан тушаалтан болон аливаа бусад хүнийг хэлнэ;

(d) “Хөрөнгө” гэж хөдлөх болон үл хөдлөх, биет болон биет бус бүх төрлийн эд хөрөнгө эсхүл эдийн бус хөрөнгө болон тэдгээрийг өмчлөх эрх болон тухайн хөрөнгөөс хувь эзэмших эрхийг нотолсон эрх зүйн болон бусад баримт бичгийг хэлнэ;

(e) “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж гэмт хэрэг үйлдсэнээр шууд эсхүл шууд бусаар бий болсон эсхүл олж авсан аливаа хөрөнгийг хэлнэ;

(f) “Битүүмжлэх” болон “хөрөнгө царцаах” гэж шүүх болон эрх бүхий бусад байгууллагаас гаргасан шийдвэрийн үндсэн дээр хөрөнгийг шилжүүлэх, хувиргах, захиран зарцуулах, хөдөлгөхийг түр хугацаагаар хориглох эсхүл түр хугацаагаар эзэмшил буюу хяналтад авахыг хэлнэ;

(g) “Хураах” гэж шүүх эсхүл эрх бүхий бусад байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу хөрөнгийг бүрмөсөн хураан авах, шаардлагатай зарим тохиолдолд гэмт хэргээс олсон хөрөнгө, орлогыг албадан гаргуулахыг хэлнэ;

(h) “Хууль бус ашиг, орлого бий болгосон гэмт хэрэг” гэж энэхүү конвенцын 23 дугаар зүйлд тодорхойлсон гэмт хэргийн шинжтэй, хууль бус ашиг, орлогыг бий болгосон аливаа гэмт үйлдлийг хэлнэ;

(i) “Хяналтын дор хүргүүлэх” гэж гэмт хэргийг мөрдөн шалгах болон гэмт хэрэг үйлдэхэд оролцсон этгээдийг таньж тогтоох зорилгоор хууль бус буюу сэжигтэй ачаа барааг нэг эсхүл хэд хэдэн улсын нутаг дэвсгэрээс эсхүл түүгээр дамжуулан эсхүл тэр нутаг дэвсгэр рүү тэдгээр улсын эрх бүхий байгууллагын мэдэл, хяналтын доор нэвтрүүлэхийг зөвшөөрч буй аргыг хэлнэ.

3 дугаар зүйл. Хамрах хүрээ

1. Энэхүү конвенцыг тус конвенцод заасан нөхцөлийн дагуу авлигаас урьдчилан сэргийлэх, түүнийг мөрдөн шалгах, яллах, түүнчлэн энэхүү конвенцын дагуу гэмт хэрэг үйлдэж олсон хэмээн тогтоогдсон хөрөнгө, орлогыг битүүмжлэх, царцаах, хураах болон буцаахад хэрэглэнэ.

2. Энэхүү конвенцод өөрөөр заагаагүй бол конвенцыг хэрэгжүүлэх зорилгоор конвенцод заасан гэмт хэрэг нь төрийн болон орон нутгийн өмчид хохирол, хор уршиг учруулсан байхыг заавал шаардахгүй.

4 дүгээр зүйл. Бүрэн эрхт байдлыг хамгаалах

1. Оролцогч улсууд энэхүү конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэхдээ бусад улсын бүрэн эрх, тэгш байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх, дотоод хэрэгт нь үл оролцох зарчмуудыг баримтална.

2. Энэхүү конвенцын аль ч заалт нь бусад улс орны үндэсний хууль тогтоомжоороо зохицуулан эрх бүхий байгууллагадаа олгосон бүрэн эрхэд харьяалуулсан чиг үүргийг тухайн нутаг дэвсгэр дээр хэрэгжүүлэх эрхийг аливаа оролцогч аль ч улс оронд олгохгүй.

II БҮЛЭГ

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

5 дугаар зүйл. Авлигаас урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаа

1. Оролцогч улс бүр нийгмийн оролцоог хөхиүлэн дэмжсэн, хууль дээдлэх ёс, төрийн бодлого, төрийн болон орон нутгийн өмчийг зохистойгоор удирдах, үнэнч шударга, ил тод байх, хариуцан тайлагнах зарчмыг тусгасан авлигын эсрэг үр дүнтэй, уялдаа холбоо бүхий бодлогыг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлнэ.

2. Оролцогч улс бүр авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үр дүнтэй практик үйл ажиллагааг тогтоож, хөхиүлэн дэмжихийг чармайна.

3. Оролцогч улс бүр холбогдох эрх зүйн баримт бичиг болон захиргааны арга хэмжээгээ авлигаас урьдчилан сэргийлж, түүнтэй тэмцэхэд хангалттай байгаа эсэхийг нь тодорхойлох зорилгоор тогтмол үнэлж дүгнэж байхыг чармайна.

4. Оролцогч улсууд энэ зүйлд заасан арга хэмжээг хөхиүлэн дэмжиж, хөгжүүлэх чиглэлээр өөр хоорондоо болон холбогдох олон улсын ба бус нутгийн байгууллагатай эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн аль тохирох байдлаар хамтран ажиллана. Ийм хамтын ажиллагаанд авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн олон улсын хөтөлбөр, төсөлд оролцох ажил багтаж болно.

6 дугаар зүйл. Авлигаас урьдчилан сэргийлэх байгууллага

1. Оролцогч улс бүр авлигаас дор дурдсан арга хэлбэрээр урьдчилан сэргийлэх тодорхой тооны байгууллагыг ажиллуулахаар эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн зохицуулна. Үүнд:

(a) энэхүү конвенцын 5 дугаар зүйлд заасан бодлогыг хэрэгжүүлэх, зохих тохиолдолд уг бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, уялдуулан зохицуулах;

(b) авлигаас урьдчилан сэргийлэх талаар мэдлэгийг нэмэгдүүлж, түгээх;

2. Оролцогч улс бүр энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан байгууллага нь чиг үүргээ үр дүнтэйгээр, аливаа зүй бус нөлөөллөөс ангид байдлаар хараат бусаар хэрэгжүүлэх нөхцөлийг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн шаардлагатай байдлаар зохицуулж хангана. Түүнчлэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай материаллаг нөөц, мэргэшсэн ажилтнаар хангахаас гадна ажилтнуудыг чиг үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдаж болох бэлтгэл, сургалтаар хангана.

3. Оролцогч улс бүр авлигаас урьдчилан сэргийлэх тодорхой арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэхэд нь бусад Оролцогч улсад тусалж болох эрх бүхий байгууллага болон байгууллагуудын нэр, хаягийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдээлнэ.

7 дугаар зүйл. Нийтийн алба

1. Оролцогч улс бүр нийтийн албан тушаалтан, шаардлагатай бол сонгон шалгаруулж томилдоггүй нийтийн бусад албан тушаалтныг төрийн албанд элсүүлэх, ажилд авах, ажиллуулах, албан тушаал дэвшүүлэх, тэтгэвэрт гаргахтай холбоотой дор дурдсан тогтолцоог зохимжтой байдлаар, эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн үүсгэн хэрэгжүүлж, улмаар бэхжүүлэхийг чармайна. Үүнд:

(a) үр ашигтай, ил тод байх болон мэдлэг чадвар, тэгш шударга байдал, авьяас зэрэг бодит шалгууртай байх зарчмуудад үндэслэсэн;

(b) ялангуяа авлигад өртөх эрсдэлтэй гэж тооцогдох нийтийн албан тушаалд хувь хүнийг сонгон авах, сургах, мөн зохих тохиолдолд тэдгээр албан тушаалын эрх мэдлийг нэг хүнд төвлөрүүлэхгүй тодорхой хугацаанд шилжүүлж байх асуудлуудыг хангалттай хэмжээнд зохицуулсан дүрэм, журамтай;

(c) Оролцогч улсын эдийн засгийн хөгжлийн түвшинд харгалзахуйц хангалттай хэмжээний, тэгш шударга тогтолцоотой цалин хөлс олгохыг хөхиүлэн дэмжсэн;

(d) нийтийн албан хаагчид чиг үүргээ үнэн зөв, нэр төртэй, зохих ёсоор биелүүлэх шаардлагыг хангахуйц боловсролын болон сургалтын хөтөлбөрийг хөхиүлэн дэмжсэн, түүнчлэн чиг үүргээ биелүүлэхэд нь учирч болох авлигын эрсдэлийн талаарх мэдлэгийг нь дээшлүүлэх тусгайлан бэлтгэсэн зохих сургалтад хамруулдаг байх бөгөөд энэ хэсэгт дурдсан сургалтын хөтөлбөрт холбогдох салбарын ёс зүйн дүрэм, стандартыг эш татан оруулсан байж болно.

2. Оролцогч улс бүр нийтийн албан тушаалд нэр дэвшүүлэх, сонгох шалгаруулах шалгуурыг тогтоох зорилгоор хууль тогтоомж батлах болон захиргааны зохих арга хэмжээг энэхүү конвенцын зорилт болон үндэсний хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авч хэрэгжүүлэхийг эрмэлзэнэ.

3. Оролцогч улс бүр сонгогддог нийтийн албан тушаалд нэр дэвшүүлэх үйл ажиллагааны санхүүжилт болон холбогдох тохиолдолд улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг дээшлүүлэх зорилгоор хууль тогтоомж батлах болон захиргааны зохих арга хэмжээг энэхүү конвенцын зорилт болон үндэсний хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

4. Оролцогч улс бүр ил тод байдлыг хөхиүлэн дэмжих болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, бэхжүүлэхийг үндэсний хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн чармайна.

8 дугаар зүйл. Нийтийн албан тушаалтны ёс зүйн дүрэм

1. Авлигатай тэмцэхийн тулд нийтийн албан тушаалтнууд шударга, үнэнч, хариуцлагатай байх болон холбогдох бусад зарчмыг дэмжсэн зохицуулалтыг Оролцогч улс бүр эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн батална.

2. Ялангуяа, нийтийн албаны чиг үүргийг зөв шударга, нэр төртэй, зохих ёсоор биелүүлэх ёс зүйн дүрэм буюу стандартыг Оролцогч улс бүр төрийн болон эрх зүйн тогтолцооныхоо хүрээнд батлан хэрэглэхийг чармайна.

3. Энэ зүйлд заасан зохицуулалтуудыг хэрэгжүүлэхдээ Оролцогч улс бүр Ерөнхий Ассамблейн 1996 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 51/59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Нийтийн албан тушаалтны ёс зүйн олон улсын дүрэм” зэрэг бүс нутгийн, бүс нутаг хоорондын болон олон талт байгууллагын холбогдох санаачилгыг зохих хэмжээнд эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн хэрэгжүүлэхэд анхаарал хандуулна.

4. Оролцогч улс бүр нийтийн албан тушаалтан нь чиг үүргээ биелүүлэх явцдаа өөрт нь мэдэгдсэн авлигын үйлдлийн талаар эрх бүхий зохих байгууллагад мэдээлэх явдлыг хөнгөвчлөн дэмжих арга хэмжээ, тогтолцоог үндэсний хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн үүсгэн хэрэгжүүлэхийг эрмэлзэнэ.

5. Оролцогч улс бүр нийтийн албан тушаалтан чиг үүргээ гүйцэтгэх явцдаа ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох байдлаар оролцсон албан үүргээс гадуурх үйл ажиллагаа, бусдаас авсан ажил, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, хөрөнгө, том хэмжээний бэлэг болон ашиг орлого зэргийнхээ талаар зохих эрх бүхий байгууллагад мэдүүлж байх арга хэмжээ, тогтолцоог зохих байдлаар, үндэсний хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн үүсгэн хэрэгжүүлэхийг чармайна.

6. Оролцогч улс бүр энэ зүйлд заасан нийтийн албан хаагчийн ёс зүйн дүрэм буюу стандартыг зөрчсөн албан тушаалтанд сахилгын болон бусад арга хэмжээг үндэсний хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авахад анхаарна.

9 дүгээр зүйл. Нийтийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, нийтийн санхүүг удирдах

1. Оролцогч улс бүр ил тод байх, өрсөлдөөний зарчим, шийдвэр гаргах бодит шалгуурт үндэслэсэн бөгөөд авлигаас урьдчилан сэргийлэх зэрэгт үр дүнтэй үйлчлэхүйц нийтийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах зохих тогтолцоог байгуулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн авч хэрэгжүүлнэ. Ийм тогтолцоог хэрэгжүүлэхдээ тодорхой босго үзүүлэлтийг харгалзаж болох бөгөөд уг тогтолцоонд дор дурдсан болон бусад асуудлыг харгалзан үзнэ. Үүнд:

(а) тендерт оролцох этгээдэд тендерээ бэлтгэж, ирүүлэхэд хангалттай хугацаа олгох зорилгоор бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам болон гэрээнд хамаарах мэдээллийг, түүний дотор тендерийн урилга болон гэрээ байгуулах эрх олгох талаарх холбогдох болон зохих мэдээллийг олон нийтэд тараах;

(b) тендерт оролцох нөхцөл, түүний дотор сонгон шалгаруулах ба эрх олгох шалгуур, тендер шалгаруулалтын дүрмийг урьдчилан тогтоож, тэдгээрийг нийтлэх;

(c) дүрэм буюу журмыг зөв хэрэглэсэн эсэхийг дараа нь нягтлан шалгахыг хөнгөвчлөн дэмжих зорилгоор, нийтийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шийдвэрийг гаргахад бодит бөгөөд урьдчилан тогтоосон шалгуурыг хэрэглэх;

(d) энэхүү хэсэгт заасны дагуу тогтоосон дүрэм буюу журам хэрэгжээгүй тохиолдолд тухайн үйлдэлд гомдол гаргах зэргээр эрх ашгаа хамгаалуулах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх үр дүнтэй хяналтын үндэсний тогтолцоо;

(e) бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хариуцсан ажилтантай холбоотой нийтийн өмчийн хөрөнгөөр тодорхой бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд ашиг сонирхол байгаа эсэхээ мэдүүлэх, үзлэг шалгалтын журам батлах, бэлтгэл сургалт явуулах шаардлагыг тодорхойлох зэрэг арга хэмжээ авах.

2. Оролцогч улс бүр нийтийн санхүүгийн удирдлагад ил тод байх, хариуцан тайлагнах явдлыг хөхиүлэн дэмжих талаар зохих арга хэмжээг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн авна. Ийм арга хэмжээ нь дараах зүйлийг бусад зүйлийн хамт хамарна. Үүнд:

(a) үндэсний төсөв батлах журам;

(b) орлого, зарлагыг цаг тухайд нь тайлагнах;

(c) нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандарт, холбогдох хяналтын тогтолцоо;

(d) эрсдэлийн удирдлага, дотоодын хяналтын үр дүнтэй бөгөөд үр ашигтай тогтолцоо;

(e) зохих тохиолдолд, энэ хэсэгт тогтоосон шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд засаж залруулах арга хэмжээ.

3. Оролцогч улс бүр улсын орлого, зарлагад хамаарах нягтлан бодох бүртгэл, тэмдэглэл, санхүүгийн мэдээлэл, бусад баримт бичгийн үнэн зөв байдлыг хангах, тийм баримт бичгийг хуурамчаар үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай байж болох иргэний эрх зүйн болон захиргааны арга хэмжээг үндэсний хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авна.

10 дугаар зүйл. Олон нийтэд тайлагнах

Авлигатай тэмцэх хэрэгцээг харгалзан үзэж Оролцогч улс бүр нийтийн захиргаандаа, түүний дотор зохион байгуулалт, чиг үүргээ хэрэгжүүлэх болон шийдвэр гаргах явцдаа ил тод байдлыг сайжруулахад шаардлагатай байж болох арга хэмжээг үндэсний хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн, зохих тохиолдолд авна. Эдгээр арга хэмжээнд бусад зүйлийн хамт дараах зүйл багтана. Үүнд:

(a) нийтийн захиргааныхаа зохион байгуулалт, чиг үүрэг хэрэгжүүлэх болон шийдвэр гаргах явц, түүнчлэн хувийн амьдрал, хувийн мэдээ баримтыг хамгаалахыг зохих ёсоор

харгалзахын сацуу иргэдийн ашиг сонирхлыг хөндсөн шийдвэр, эрх зүйн актын талаарх мэдээллийг зохих тохиолдолд олж авах боломжийг иргэдэд олгосон дүрэм буюу журам батлах;

(b) шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад олон нийт нэвтрэх боломжийг хөнгөвчлөн дэмжихийн тулд захиргааны журмыг зохих тохиолдолд хялбарчлах;

(c) нийтийн захиргаанд нь авлига гарах эрсдэлийн талаарх тогтмол илтгэлийг багтааж болох мэдээллийг хэвлэн нийтлэх.

11 дүгээр зүйл. Шүүх, прокурорын байгууллагад хамаарах арга хэмжээ

1. Оролцогч улс бүр шүүхийн хараат бус байдал, авлигын эсрэг тэмцэлд шүүхийн шийдвэрлэх үүрэгтэйг харгалзан шүүгч, шүүхийн байгууллагад ажиллагсдын үнэнч шударга байдлыг бэхжүүлэх, тэдгээрийн дунд авлигад автагдах боломж бий болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн, шүүхийн хараат бус байдалд хохирол учруулахгүйгээр авна. Эдгээр арга хэмжээнд шүүгч, шүүхийн байгууллагад ажиллагсдын ёс зүйн дүрэм багтаж болно.

2. Энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн дагуу авсантай адил үр нөлөөтэй арга хэмжээг шүүхийн тогтолцоонд хамрагддаггүй атлаа шүүхийн байгууллагатай адил хараат бус эрх зүйн байдалтай прокурорын байгууллага бүхий тэрхүү Оролцогч улсын хувьд прокурорын байгууллагад нэвтрүүлэн хэрэглэж болно.

12 дугаар зүйл. Хувийн хэвшил

1. Оролцогч улс бүр хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх, хувийн хэвшлийн нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандартыг сайжруулах, түүнчлэн ийм арга хэмжээг биелүүлээгүй тохиолдолд үр нөлөөтэй, тухайн үйлдэлд тохирох, тухайн үйлдлийг гаргуулахгүй байх нөлөө үзүүлэхүйц иргэний эрх зүйн, захиргааны болон эрүүгийн зохих хариуцлагыг оногдуулах арга хэмжээг үндэсний хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн хэрэгжүүлнэ.

2. Эдгээр зорилгод хүрэх үүднээс дараах арга хэмжээг бусад арга хэмжээний хамт авч болно. Үүнд:

(a) хууль сахиулах байгууллага болон холбогдох хувийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих;

(b) хувийн холбогдох байгууллагуудын үнэнч шударга байдлыг хамгаалахад чиглэсэн стандарт, журам, түүний дотор бизнесийн болон холбогдох бусад мэргэжлийн төлөөлөгчдийн үйл ажиллагааг зөв, нэр төртэй, зохистойгоор явуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнчлэн аж ахуйн нэгж хоорондын болон тэдгээрийн гэрээний журмаар төртэй харилцах бизнесийн сайн дадлыг хэвшүүлэн хэрэглэхийг дэмжихэд чиглэсэн ёс зүйн дүрэм боловсруулахыг хөхиүлэн дэмжих;

(c) хувийн байгууллагуудын дунд ил тод байдлыг хөхиүлэн дэмжих, түүний дотор зохих тохиолдолд компани, аж ахуйн нэгж байгуулж, удирдахтай холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг ялгаж тогтоох арга хэмжээ;

(d) хувийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах журам, түүний дотор аж ахуйн үйл ажиллагаа явуулахад нийтийн эрх бүхий байгууллагаас олгох татаас, тусгай зөвшөөрлийн талаарх журмыг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх;

(e) нийтийн албан тушаалд ажиллаж байсан этгээд нийтийн албанаас чөлөөлөгдсөн эсхүл тэтгэвэрт гарсны дараа урьд ажиллаж байхдаа хийж байсан буюу удирдаж байсан чиг үүрэгтэй шууд хамааралтай мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эсхүл хувийн хэвшилд ийм ажил, үйлчилгээг эрхлэхэд тодорхой хугацааны хязгаарлалтыг зохих байдлаар тогтоох замаар ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх;

(f) хувийн хэвшлийн байгууллагууд бүтэц, хэмжээндээ тохирсон байдлаар авлигаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх дотоод аудитын хангалттай хяналттай байх, байгууллагын данс, шаардлагатай санхүүгийн тайланг аудит, магадлан итгэмжлэлд хамруулах.

3. Авлигаас урьдчилан сэргийлэх үүднээс Оролцогч улс бүр энэхүү конвенцод заасан аливаа гэмт хэргийг үйлдэх зорилгоор явуулсан дараах үйлдлийг хориглоход нягтлан бодох бүртгэл, тооцоо хөтлөх, санхүүгийн тайланг ил тод болгох, нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандартын талаарх үндэсний хууль тогтоомжийнхоо дагуу шаардлагатай байж болох арга хэмжээг авна. Үүнд:

(a) бүртгэлээс гадуур данс нээх;

(b) бүртгэлээс гадуур буюу буруу тодорхойлсон гүйлгээ хийх;

(c) гараагүй зардлыг бүртгэх;

(d) объектыг нь буруу тодорхойлсон өглөг үүсгэх;

(e) хуурамч баримт бичиг ашиглах;

(f) нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг хуульд заасан хугацаанаас өмнө санаатайгаар устгах.

4. Оролцогч улс бүр энэхүү конвенцын 15 болон 16 дугаар зүйлийн дагуу тогтоосон гэмт хэргийн бүрэлдэхүүн хэсэг болох хахуульд өгсөн зардал болон зохих тохиолдолд авлигын үйлдлийг дэмжсэн бусад зардлыг татвар ногдох зардлаас хасаж тооцохыг үл зөвшөөрнө.

13 дугаар зүйл. Нийгмийн оролцоо

1. Оролцогч улс бүр авлигаас урьдчилан сэргийлж, тэмцэхэд хувь хүн болон иргэний нийгэм, төрийн бус байгууллага, иргэдийн нэгдэл хөдөлгөөнд тулгуурласан байгууллага зэрэг нийтийн албанаас гаднах бүлгийн идэвхтэй оролцоог хөхиүлэн дэмжих бөгөөд бодитоор оршиж буй авлига, түүний шалтгаан, ноцтой байдал, аюул заналын талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн зохих арга хэмжээг үндэсний хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн өөрийн бололцооны хүрээнд авна. Энэхүү оролцоог дараах арга хэмжээгээр бэхжүүлнэ. Үүнд:

(a) шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдлыг сайжруулах, түүн дэх олон нийтийн оролцоо, хувь нэмрийг дэмжих;

(b) олон нийт мэдээлэл авах боломжтой байх явдлыг хангах;

(c) авлигыг үл тэвчих уур амьсгал бий болгоход хувь нэмэр оруулах мэдээллийг олон нийтэд түгээх, түүнчлэн олон нийтийн боловсролын хөтөлбөр, түүний дотор дунд болон их, дээд сургуулийн хөтөлбөр хэрэгжүүлэх;

(d) авлигатай холбоотой мэдээлэл хайх, авах, хэвлэн нийтлэх, түгээх эрх чөлөөг хүндэтгэх, хөхиүлэн дэмжих, хамгаалах. Тэрхүү эрх чөлөөнд тодорхой хязгаарлалт тавьж болох боловч хязгаарлалт нь зөвхөн хуульд заасан байх бөгөөд дараах үндэслэлээр шаардлагатай байвал зохино. Үүнд:

(i) бусдын эрх, нэр хүндийг хүндэтгэх;

(ii) үндэсний аюулгүй байдал, олон нийтийн дэг журам, олон нийтийн эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах.

2. Оролцогч улс бүр энэхүү конвенцод заасан авлигатай тэмцэх холбогдох байгууллагын талаар олон нийт мэдэж байх явдлыг хангах талаар зохих арга хэмжээ авч, энэхүү конвенцын дагуу тогтоосон гэмт хэргийг үүсгэж байна гэж үзэж болох аливаа тохиолдлын талаар мэдээлэхээр эдгээр байгууллагад зохих тохиолдолд хандах боломж (үүнд нэрээ мэдүүлэхгүйгээр хандах боломж багтана)-оор хангана.

14 дүгээр зүйл. Мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ

(а) мөнгө угаах бүх хэлбэрийг таслан зогсоох болон илрүүлэхийн тулд банк болон банк бус санхүүгийн байгууллага, түүний дотор мөнгө болон бусад үнэт зүйлийн шилжүүлгийн албан эсхүл албан бус үйлчилгээ үзүүлдэг хувь хүн, хуулийн этгээд, түүнчлэн ялангуяа мөнгө угаахад өртөх эрсдэлтэй бусад байгууллагад зохих тохиолдолд зохицуулалт, хяналтын дотоодын иж бүрэн дэглэмийг эрх хэмжээнийхээ хүрээнд тогтоох бөгөөд ийм дэглэм нь харилцагч болон зохих тохиолдолд жинхэнэ өмчлөгчийн хэн болохыг тогтоох, тэмдэглэл хөтлөх, сэжигтэй гүйлгээг мэдээлэхэд тавих шаардлагыг онцлон тогтооно;

(б) энэхүү конвенцын 46 дугаар зүйлд заасныг үл хөндөн, захиргаа, зохицуулалт, хууль сахиулах болон мөнгө угаахтай тэмцэх үйл ажиллагаа явуулдаг эрх бүхий бусад байгууллага (үндэсний хууль тогтоомжид заасан бол зохих тохиолдолд шүүх) нь дотоодын хуульд заасан нөхцөлийн хүрээнд үндэсний болон олон улсын хэмжээнд хамтран ажиллах, мэдээлэл солилцох боломжтой байх явдлыг хангах бөгөөд үүний тулд мөнгө угааж байж болзошгүй гэсэн мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, түгээх зорилго бүхий үндэсний төв болох санхүүгийн мэдээллийн нэгж байгуулах асуудалд анхаарна.

2. Оролцогч улсууд хилээр нь дамжих бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах санхүүгийн зохих хэрэгслийн хөдөлгөөнийг илрүүлж, хянах талаар боломжит арга хэмжээ авахад анхаарал хандуулах бөгөөд чингэхдээ мэдээллийг зохистойгоор ашиглах баталгаа гарган хууль ёсны хөрөнгийн хөдөлгөөнд саад болохгүй ажиллана. Эдгээр арга хэмжээнд хувь хүн болон аж ахуйн нэгжийн их хэмжээний бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах санхүүгийн зохих хэрэгслийг хил дамжуулан шилжүүлсэн талаар мэдээлж байх шаардлага багтаж болно.

3. Оролцогч улсууд санхүүгийн байгууллага, үүний дотор мөнгө гуйвуулдаг байгууллагад дараах шаардлага тавих талаар боломжит зохих арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

(а) мөнгөний цахим шилжүүлгийн маягт болон холбогдох мэдээнд шилжүүлэгчийн талаар үнэн зөв бөгөөд чухал мэдээллийг тусгах;

(б) ийм мэдээллийг төлбөр хийх явцын бүх шатанд хадгалах;

(с) шилжүүлэгчийн талаар бүрэн мэдээлэл байхгүй мөнгөн шилжүүлгийн талаар нарийвчилсан шалгалт явуулах.

4. Энэхүү зүйлийн нөхцөлийн дагуу зохицуулалт, хяналтын дотоодын дэглэм тогтоохдоо, бүс нутгийн, бүс нутаг хоорондын болон олон талт байгууллагаас мөнгө угаахын эсрэг гаргасан холбогдох санаачилгыг удирдлага болгохыг Оролцогч улсуудад энэхүү конвенцын аливаа бусад зүйлийг зөрчихгүйгээр уриалж байна.

5. Оролцогч улсууд мөнгө угаахтай тэмцэхийн тулд шүүх, хууль сахиулах болон санхүүгийн зохицуулалтын эрх бүхий байгууллага хоорондын хамтын ажиллагааг дэлхийн, бүс нутгийн, дэд бүсийн болон хоёр талын хэмжээнд хөгжүүлж, хөхиүлэн дэмжихийг чармайна.

III БҮЛЭГ

Гэмт хэрэгт тооцох, хууль сахиулах

15 дугаар зүйл. Үндэсний нийтийн албан тушаалтныг хахуульдах

1. Оролцогч улс бүр санаатайгаар үйлдсэн дараах үйлдлийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоомж батлах болон бусад арга хэмжээг авна. Үүнд:

(а) нийтийн албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэх явцад аливаа үйлдэл эсхүл эс үйлдлийг хийлгэх зорилгоор түүнд өөрт нь эсхүл өөр хувь хүн, хуулийн этгээдэд зүй бус давуу байдал олгохыг шууд болон шууд бусаар тухайн албан тушаалтанд амлах, санал болгох эсхүл ийм давуу байдлыг олгох;

(б) нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцдаа аливаа үйлдэл эсхүл эс үйлдэл хийх зорилгоор өөртөө эсхүл өөр хувь хүн, хуулийн этгээдэд зориулж зүй бус давуу байдал олгохыг шууд болон шууд бусаар шаардах эсхүл ийм давуу байдлыг хүлээж авах.

16 дугаар зүйл. Гадаад улсын төрийн албан тушаалтан болон олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах

1. Оролцогч улс бүр гадаад улсын төрийн албан тушаалтан эсхүл олон улсын байгууллагын албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэх явцад нь олон улсын үйл ажиллагаа явуулахад чиглэсэн бизнесийн болон зүй бус бусад давуу байдал олж авах, тийм давуу байдлаа хадгалах зорилгоор ямарваа үйлдэл эсхүл эс үйлдэл хийлгэх зорилгоор түүнд өөрт нь эсхүл өөр хувь хүн, хуулийн этгээдэд зүй бус давуу байдал олгохыг шууд болон шууд бусаар тухайн албан тушаалтанд амлах, санал болгох эсхүл ийм давуу байдлыг олгох үйлдлийг санаатай үйлдсэнийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль, тогтоомж батлах болон бусад арга хэмжээг авна.

2. Оролцогч улс бүр гадаад улсын төрийн албан тушаалтан эсхүл олон улсын байгууллагын албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцдаа ямарваа үйлдэл эсхүл эс үйлдэл хийх зорилгоор өөртөө эсхүл өөр хувь хүн, хуулийн этгээдэд зориулж зүй бус давуу байдал олгохыг шууд болон шууд бусаар шаардах эсхүл ийм давуу байдлыг хүлээж авах үйлдлийг санаатайгаар үйлдсэнийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль, тогтоомж батлах болон бусад арга хэмжээг авах асуудлыг анхаарна.

17 дугаар зүйл. Нийтийн албан тушаалтан хөрөнгөө завших, ашиглан шамшигдуулах болон бусад аргаар зориулалтын бусаар зарцуулах

Оролцогч улс бүр нийтийн албан тушаалтан албан тушаалынх нь дагуу өөрт нь итгэж хариуцуулсан аливаа эд хөрөнгө, нийтийн болон хувийн мөнгөн хөрөнгө эсхүл үнэт цаас, аливаа бусад үнэ бүхий зүйлийг өөрийн эсхүл өөр этгээд, байгууллагын ашгийн төлөө завших, ашиглан шамшигдуулах, бусад аргаар зориулалтын бусаар зарцуулах үйлдлийг санаатайгаар үйлдсэнийг гэмт хэрэгт тооцох хууль тогтоомжийг шаардлагатай байдлаар батлах болон бусад арга хэмжээг авна.

18 дугаар зүйл. Эрх нөлөөгөө урвуулан ашиглах

Оролцогч улс бүр санаатайгаар үйлдсэн дараах үйлдлийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоомж батлах болон бусад арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

(а) ийм үйлдлийг анхлан санаачлагч болон аливаа бусад этгээдэд зориулж Оролцогч улсын захиргааны болон нийтийн эрх бүхий байгууллагаас зүй бус давуу байдал олж авах үүднээс нийтийн албан тушаалтан болон аливаа бусад этгээдийг бодитоор байгаа гэж ойлгогдох эрх нөлөөг нь урвуулан ашиглуулахын тулд тухайн албан тушаалтанд өөрт нь эсхүл өөр этгээдэд шууд болон шууд бусаар зүй бус давуу тал олгохыг амлах, санал болгох эсхүл олгох;

(б) нийтийн албан тушаалтан болон аливаа бусад этгээд Оролцогч улсын захиргааны болон нийтийн эрх бүхий байгууллагаас зүй бус давуу тал олж авах үүднээс бодитоор байгаа гэж ойлгогдох эрх нөлөөгөө урвуулан ашиглахын тулд тухайн нийтийн албан тушаалтан болон аливаа бусад этгээд өөртөө эсхүл өөр этгээдэд зориулж шууд болон шууд бусаар зүй бус давуу тал өөртөө олгохыг шаардах эсхүл авах.

19 дүгээр зүйл. Чиг үүргээ урвуулан ашиглах

Оролцогч улс бүр нийтийн албан тушаалтан өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх явцад өөртөө эсхүл өөр этгээд эсхүл байгууллагад шууд болон шууд бусаар зүй бус давуу тал олж авах зорилгоор чиг үүрэг болон албан тушаалаа урвуулан ашиглах, өөрөөр хэлбэл, аливаа үйлдлийг хууль тогтоомж зөрчин гүйцэтгэх эсхүл гүйцэтгэхгүй байх үйлдлийг санаатайгаар үйлдсэнийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль, тогтоомж батлах болон бусад арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

20 дугаар зүйл. Хууль бусаар хөрөнгөжих

Оролцогч улс бүр хууль бусаар хөрөнгөжих санаатай үйлдлийг, өөрөөр хэлбэл, нийтийн албан тушаалтан хөрөнгө нь их хэмжээгээр нэмэгдсэнийг өөрийнхөө хууль ёсны орлоготой холбогдуулан үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй байгаа бол ийнхүү хөрөнгө нь нэмэгдсэнийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоомж батлах болон бусад арга хэмжээг авах асуудлыг үндсэн хууль болон эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн хэрэгжүүлнэ.

21 дүгээр зүйл. Хувийн хэвшил дэх хахууль

Оролцогч улс бүр эдийн засаг, санхүүгийн болон арилжааны үйл ажиллагааны явцад санаатайгаар үйлдсэн дараах үйлдлийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоомж батлах болон бусад арга хэмжээг авна. Үүнд:

(а) хувийн хэвшлийн байгууллагад удирдах болон гүйцэтгэх аливаа албан тушаал эрхэлдэг аливаа этгээдийг албан үүргээ зөрчин аливаа үйлдэл эсхүл эс үйлдэл хийлгэх зорилгоор түүнд өөрт нь эсхүл өөр этгээдэд зүй бус давуу байдал олгохыг шууд болон шууд бусаар тухайн этгээдэд амлах, санал болгох эсхүл ийм давуу байдлыг олгох;

(б) хувийн хэвшлийн байгууллагад удирдах болон гүйцэтгэх аливаа албан тушаал эрхэлдэг аливаа этгээд албан үүргээ зөрчин аливаа үйлдэл эсхүл эс үйлдэл хийх зорилгоор өөртөө эсхүл өөр этгээдэд зориулж зүй бус давуу байдал олгохыг шууд болон шууд бусаар шаардах эсхүл ийм давуу байдлыг хүлээж авах.

22 дугаар зүйл. Хувийн хэвшлийн хөрөнгийг завших

Оролцогч улс бүр хувийн хэвшлийн байгууллагад удирдах болон гүйцэтгэх аливаа албан тушаал эрхэлдэг аливаа этгээд албан тушаалынх нь дагуу өөрт нь итгэж хариуцуулсан аливаа хөрөнгө, хувийн мөнгөн хөрөнгө, үнэт цаас, аливаа бусад үнэ бүхий зүйлийг завших үйлдлийг эдийн засаг, санхүүгийн болон арилжааны үйл ажиллагааны

явцад санаатайгаар үйлдсэнийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоомж батлах болон бусад арга хэмжээг авна.

23 дугаар зүйл. Гэмт хэргээс олсон орлогыг угаах

1. Оролцогч улс бүр үндэсний хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн санаатайгаар үйлдсэн дараах үйлдлийг гэмт хэрэгт тооцох зорилгоор хууль, тогтоомж батлах болон шаардлагатай байж болох бусад арга хэмжээг авна. Үүнд:

(a) (i) тухайн хөрөнгө нь гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого болохыг мэдсээр байж түүний хууль бус гарал үүслийг нуун дарагдуулах, өөрчлөн хувиргах эсхүл хууль бус ашиг, орлого бий болгосон гэмт хэрэг үйлдсэн аливаа этгээдэд үйлдсэн хэргийнхээ хууль зүйн үр дагавраас зайлсхийхэд нь туслах зорилгоор уг хөрөнгийг хувиргах болон шилжүүлэх;

(ii) тухайн хөрөнгө нь гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүний жинхэнэ төрөл шинж, эх үүсвэр, байршил, захиран зарцуулалт, хөдөлгөөн, өмчлөл эсхүл түүнтэй холбоотой эрхийг нуун дарагдуулах болон өөрчлөн хувиргах;

(b) өөрийн эрх зүйн тогтолцооны үндсэн зарчмаас хамааран:

(i) тухайн хөрөнгийг гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого болохыг түүнийг хүлээн авч байх үед мэдсээр байж түүнийг худалдан авах, эзэмших, ашиглах;

(ii) энэ зүйлийн дагуу тогтоосон аливаа гэмт хэрэгт хамтран оролцох, холбогдох, түүнийг үйлдэхэд хуйвалдах, үйлдэхийг завдах, мөн ийм гэмт хэрэг үйлдэхэд туслах, хатгах, дэмжих болон зааж зөвлөх.

2. Энэхүү зүйлийн 1 дэх хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор:

(a) Оролцогч улс бүр энэ зүйлийн 1 дэх хэсгийг хууль бус ашиг, орлого бий болгосон гэмт хэргийн аль болох өргөн хүрээнд хэрэглэхийг эрмэлзэнэ;

(b) Оролцогч улс бүр хууль бус ашиг, орлого бий болгосон гэмт хэрэгт наад зах нь энэхүү конвенцод заасан бүх эрүүгийн хэргийг хамааруулна;

(c) дээрх (b) хэсэгт заасан зорилгоор хууль бус ашиг, орлого бий болгосон гэмт хэрэгт тухайн Оролцогч улсын харьяалан шийдвэрлэх хүрээнд болон уг харьяаллаас гадуур үйлдсэн гэмт хэргийг хамааруулна. Гэхдээ Оролцогч улсын харьяаллаас гадуур үйлдсэн гэмт хэрэг нь зөвхөн тухайн гэмт хэрэг гарсан улсын үндэсний хуулиар эрүүгийн хэрэгт тооцогдож буй тохиолдолд, харин уг гэмт хэрэг тухайн улсад гарсан бол энэ зүйлийг хэрэгжүүлж, хэрэглэж буй Оролцогч улсын үндэсний хуулиар эрүүгийн хэрэгт тооцогдох тохиолдолд хууль бус ашиг, орлого бий болгосон гэмт хэрэг гэж үзнэ;

(d) Оролцогч улс бүр энэ зүйлийг хэрэгжүүлэх өөрийн хууль тогтоомж, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг эсхүл тэдгээрийн талаарх танилцуулгыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлнэ;

(e) энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргүүд нь хууль бус ашиг, орлого бий болгосон гэмт хэргийг үйлдсэн этгээдэд хамаарахгүй гэж Оролцогч улсын үндэсний хууль тогтоомжийн тулгуур зарчмуудаар шаардаж байгаа бол уг шаардлагыг мөрдөж болно.

24 дүгээр зүйл. Нуун дарагдуулах

Энэхүү конвенцын 23 дугаар зүйлийн заалтыг хөндөхгүйгээр Оролцогч улс бүр аливаа этгээд энэхүү конвенцод заасан аливаа гэмт хэрэгт оролцоогүй боловч тухайн гэмт хэрэг үйлдэгдсэний дараа тухайн хөрөнгө нь энэхүү конвенцод заасан аливаа гэмт хэргийн үр дүн гэдгийг мэдсээр байж түүнийг санаатайгаар нуун дарагдуулсан, үргэлжлүүлэн эзэмшсэнийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоомж батлах болон бусад арга хэмжээг авна.

25 дугаар зүйл. Шүүн таслах ажиллагаанд саад учруулах

Оролцогч улс бүр санаатайгаар үйлдсэн дараах үйлдлийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоомж батлах болон бусад арга хэмжээг авна. Үүнд:

(а) энэхүү конвенцод заасан гэмт хэрэг үйлдсэнтэй холбогдуулан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд худал мэдүүлэг өгөхийг ятгах эсхүл мэдүүлэг өгөх, нотолгоо гаргахад хөндлөнгөөс нөлөөлөх зорилгоор хүч хэрэглэх, заналхийлэх, айлган сүрдүүлэх эсхүл зүй бус давуу байдал амлах, санал болгох эсхүл олгох;

(б) энэхүү конвенцод заасан гэмт хэрэг үйлдсэнтэй холбогдуулан шүүн таслах, хууль сахиулах албан тушаалтны албан үүргээ хэрэгжүүлэхэд нь хөндлөнгөөс нөлөөлөх зорилгоор хүч хэрэглэх, заналхийлэх болон айлган сүрдүүлэх. Энэ дэд хэсгийн аль ч заалт бусад ангиллын нийтийн албан тушаалтныг хамгаалах хууль тогтоомжтой байх Оролцогч улсуудын эрхийг хязгаарлахгүй.

26 дугаар зүйл. Хуулийн этгээдийн хариуцлага

1. Оролцогч улс бүр энэхүү конвенцод заасан гэмт хэрэгт хамтран оролцсон хуулийн этгээдэд хариуцлага тогтооход шаардлагатай байж болох арга хэмжээг эрх зүйн зарчимдаа нийцүүлэн авна.

2. Оролцогч улсын эрх зүйн зарчмуудаас хамааран хуулийн этгээдэд эрүүгийн, иргэний болон захиргааны хариуцлага оногдуулж болно.

3. Хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэсэн нь гэмт хэрэг үйлдсэн хувь хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

4. Оролцогч улс бүр ялангуяа энэхүү зүйлийн дагуу хариуцлага хүлээх хуулийн этгээдэд үр нөлөөтэй, тухайн үйлдэлд тохирсон, тухайн үйлдлийг гаргуулахгүй байх үр дүнд хүрэхүйц ял болон бусад төрлийн хариуцлага, түүний дотор торгууль оногдуулна.

27 дугаар зүйл. Хамтран оролцох ба завдах

1. Оролцогч улс бүр энэхүү конвенцод заасан гэмт хэрэгт хамтран гүйцэтгэгч, хамжигч, хатгагч зэрэг аливаа хэлбэрээр хамтран оролцсоныг гэмт хэрэг гэж үндэсний хууль тогтоомждоо нийцүүлэн тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоомж батлах болон бусад арга хэмжээг авна.

2. Оролцогч улс бүр энэхүү конвенцод заасан гэмт хэргийг үйлдэхийг завдсаныг гэмт хэрэг гэж үндэсний хууль тогтоомждоо нийцүүлэн тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоомж батлах болон бусад арга хэмжээг авч болно.

3. Оролцогч улс бүр энэхүү конвенцод заасан гэмт хэргийг үйлдэхэд бэлтгэснийг гэмт хэрэг гэж үндэсний хууль тогтоомждоо нийцүүлэн тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоомж батлах болон бусад арга хэмжээг авч болно.

28 дугаар зүйл. Ухамсар, санаа, зорилго гэмт хэргийн бүрэлдэхүүн хэсэг болох нь

Энэхүү конвенцод заасан гэмт хэргийн зайлшгүй бүрэлдэхүүн болох ухамсар, санаа, зорилгыг бодит үйл баримтын нөхцөл байдлаас дүгнэн гаргаж болно.

29 дүгээр зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа

Оролцогч улс бүр энэхүү конвенцод заасан аливаа гэмт хэрэгт хэрэг үүсгэх хөөн хэлэлцэх хугацааг уртаар тогтоож, сэжигтэн этгээд шүүн таслах ажиллагаанаас зайлсхийсэн бол хөөн хэлэлцэх хугацааг илүү уртаар тогтоох, хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоохоор үндэсний хууль тогтоомжийнхоо дагуу зохих тохиолдолд заана.

30 дугаар зүйл. Яллах, шүүхийн шийдвэр гаргах, шийтгэл оногдуулах

1. Оролцогч улс бүр энэхүү конвенцод заасан гэмт хэрэгт тухайн гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан шийтгэл оногдуулна.

2. Оролцогч улс бүр өөрийн нийтийн албан тушаалтанд чиг үүргээ гүйцэтгэхэд нь олгосон аливаа дархан эрх болон харьяалан шийдвэрлэх давуу эрх болон энэхүү конвенцод заасан гэмт хэргийг шаардлагатай тохиолдолд үр дүнтэйгээр мөрдөн шалгах, яллах, ийм хэрэгт шүүхийн шийдвэр гаргах боломжийн хооронд зохих тэнцвэрийг эрх зүйн тогтолцоо болон үндсэн хуулийн зарчимдаа нийцүүлэн тогтоох болон хэвээр хадгалахад шаардлагатай байж болох бүх арга хэмжээг авна.

3. Энэхүү конвенцод заасан гэмт хэрэгт аливаа этгээдийг яллахад хамаарах үндэсний хууль тогтоомжийн дагуу олгосон өөрийн үзэмжээр шийдвэрлэх хууль зүйн аливаа эрх мэдлийг хэрэгжүүлэхэд хууль сахиулах арга хэмжээний үр дүнг тэдгээр гэмт хэргийн хувьд аль болох дээшлүүлэхүйц бөгөөд ийм гэмт хэрэг үйлдэхийг таслан зогсоох хэрэгцээг зохих ёсоор харгалзах явдлыг хангахыг Оролцогч улс бүр чармайна.

4. Энэхүү конвенцод заасан гэмт хэргийн тохиолдолд, Оролцогч улс бүр анхан болон давж заалдах шатны шүүх ажиллагаанаас өмнө түр суллах тухай шийдвэртэй холбогдуулан нөхцөл тавихдаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх дараагийн ажиллагаанд хариуцагчийг байлгах хэрэгцээг харгалзан үзсэн байхыг эрэлхийлэх талаар зохих арга хэмжээг үндэсний хууль тогтоомждоо нийцүүлэн, өөрийгөө хамгаалах эрхийг зохих ёсоор харгалзан авна.

5. Оролцогч улсууд гэмт хэрэгт шийтгэгдсэн этгээдийг хугацаанаас нь өмнө суллах эсхүл тэнсэн суллах бол тухайн гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан үзнэ.

6. Оролцогч улс бүр энэхүү конвенцод заасан гэмт хэргийг үйлдсэн гэж яллагдаж буй нийтийн албан тушаалтныг эрх бүхий байгууллагын шийдвэрээр шаардлагатай тохиолдолд албан тушаалаас нь чөлөөлөх, түдгэлзүүлэх эсхүл шилжүүлэн томилох журмыг тогтоох асуудлыг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн хэрэгжүүлэхийн зэрэгцээ шүүхийн шийтгэх тогтоол гартал хэнийг ч гэм буруугүйд тооцох зарчмыг хүндлэн үзнэ.

7. Гэмт хэргийн ноцтой байдлаас үндэслэлтэй байгаа тохиолдолд Оролцогч улс бүр энэхүү конвенцод заасан гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдийн дараах үйл ажиллагаа явуулах эрхийг үндэсний хууль тогтоомжоор тогтоосон хугацаанд шүүхийн шийдвэр эсхүл зохих аливаа бусад баримт бичиг батлан хасах журмыг тогтоох асуудлыг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн хэрэгжүүлэхэд анхаарна. Үүнд:

(a) нийтийн алба хаших;

(b) нийтийн өмчит болон нийтийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид алба хаших.

8. Энэхүү зүйлийн 1 дэх хэсэг эрх бүхий байгууллага нийтийн албан тушаалтанд сахилгын арга хэмжээ авах эрх мэдлээ хэрэгжүүлэхийг хөндөхгүй.

9. Энэхүү конвенцод заасан гэмт хэргийг болон эрх зүйн холбогдох хамгаалалт болон тухайн үйлдлийн хууль ёсны байдлыг тогтоодог эрх зүйн бусад зарчмыг зөвхөн Оролцогч улсын үндэсний хуулиар тодорхойлох, түүнчлэн эдгээр гэмт хэргийг тэрхүү хуулийн дагуу яллаж, шийтгэх зарчмыг энэхүү конвенцын аль ч заалт хөндөхгүй.

10. Оролцогч улс бүр энэхүү конвенцод заасан н гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдийг буцаан нийгэмшүүлэхийг хөхиүлэн дэмжих арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг чармайна.

31 дүгээр зүйл. Битүүмжлэх, хөрөнгө царцаах, хураах

1. Оролцогч улс бүр дараах хөрөнгийг хураах боломжийг бий болгоход шаардлагатай байж болох арга хэмжээг дотоодын эрх зүйн тогтолцооныхоо хүрээнд аль болох өргөн хэмжээнд авна. Үүнд:

(а) энэхүү конвенцод заасан гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого болон үнийн дүнтэй нь тохирох үнэ бүхий хөрөнгө;

(б) энэхүү конвенцод заасан гэмт хэргийг үйлдэхэд ашигласан эсхүл ашиглахаа төлөвлөсөн хөрөнгө, тоног төхөөрөмж, бусад хэрэгсэл.

2. Оролцогч улс бүр энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан аливаа зүйлийг эцэст нь хураах зорилгоор илрүүлэх, мөрдөх, битүүмжлэх болон хөрөнгө царцаах боломжийг бий болгоход шаардлагатай байж болох арга хэмжээг авна.

3. Оролцогч улс бүр үндэсний хууль тогтоомждоо нийцүүлэн энэхүү зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт заасан битүүмжилсэн, царцаасан болон хураасан хөрөнгийг эрх бүхий байгууллагаас захиран зохицуулахад шаардлагатай хууль тогтоомж батлах болон бусад арга хэмжээг авна.

4. Хэрэв гэмт хэрэг үйлдэж олсон ашиг, орлогыг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн өөр хөрөнгө болгон өөрчилсөн, хувиргасан бол өөрчилсөн, хувиргасан хөрөнгөнд нь энэ зүйлд заасан арга хэмжээг авна.

5. Хэрэв гэмт хэрэг үйлдэж олсон ашиг, орлогыг хууль ёсны эх үүсвэрээс олж авсан хөрөнгөтэй хольж нийлүүлсэн бол тухайн хөрөнгөөс битүүмжлэх, царцаахад хамаарах аливаа бүрэн эрхийг хязгаарлахгүй байдлаар, ийнхүү холилдсон ашиг, орлогын үнийн дүнгийн хэмжээгээр хурааж авна.

6. Гэмт хэрэг үйлдэж олсон ашиг, орлогоос үүссэн болон гэмт хэрэг үйлдэж олсон ашиг, орлогыг өөрчилж, хувиргаж бий болгосон хөрөнгөөс үүссэн эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон ашиг, орлого холилдсон хөрөнгөөс үүссэн ашиг орлого болон бусад ашигт энэ зүйлд заасан арга хэмжээг гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой адил хэлбэр, хэмжээгээр мөн авна.

7. Энэхүү зүйл болон энэхүү конвенцын 55 дугаар зүйлд заасан зорилгоор Оролцогч улс бүр банк, санхүү буюу арилжааны баримт бичгийг гаргуулах буюу царцаах шийдвэр гаргах эрхийг өөрийн шүүх буюу эрх бүхий бусад байгууллагад олгоно. Оролцогч улс нь банкны нууцлал гэсэн үндэслэлээр энэ хэсгийн заалтын дагуу арга хэмжээ авахаас татгалзаж болохгүй.

8. Оролцогч улсууд гэмт хэрэг үйлдэж олсон гэж үзэж байгаа ашиг, орлого болон хураах хөрөнгийг хууль ёсны гарал үүсэлтэй гэдгийг нотлохыг гэмт хэрэгтнээс шаардах зохицуулалтыг үндэсний хууль тогтоомжийн тулгуур зарчмууд болон шүүхийн болон хэрэг маргаан шийдвэрлэх бусад ажиллагааны эрх зүйн зохицуулалтдаа нийцүүлэн баталж болно.

9. Энэхүү зүйлийн заалтыг хөрөнгийг эрхээ шударгаар хэрэгжүүлэгч гуравдагч талын эрхийг хөндөхөөр тайлбарлаж болохгүй.

10. Энэхүү зүйлийн аль ч заалт энэ зүйлд заасан арга хэмжээг Оролцогч улсын үндэсний хууль тогтоомжийн заалтын дагуу, түүнд нийцүүлэн тодорхойлж, хэрэгжүүлэх зарчимд сөргөөр нөлөөлөх ёсгүй.

32 дугаар зүйл. Гэрч, шинжээч, хохирогчийг хамгаалах

1. Оролцогч улс бүр энэхүү конвенцод заасан гэмт хэргийн талаар мэдүүлэг өгч буй гэрч, шинжээч, мөн зохих тохиолдолд тэдний хамаатан садан болон бусад ойрын хүнийг өс хонзон авах, айлган сүрдүүлэхээс үр дүнтэйгээр хамгаалах арга хэмжээг дотоодын эрх зүйн тогтолцоондоо нийцүүлэн боломжит байдлаар хэрэгжүүлнэ.

2. Энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээнд хариуцагчийн эрх, түүний дотор хэргээ зохих ёсоор шийдвэрлүүлэх эрхийг үл хөндөн дараах арга хэмжээ бусад арга хэмжээний хамт багтаж болно. Үүнд:

(а) эдгээр этгээдийг шаардлага, бололцооны хэрээр нүүлгэн шилжүүлж, зохих тохиолдолд тэдний хэн болох ба байгаа газрын талаарх мэдээллийг задруулахгүй

байх болон задруулахад хязгаарлалт тогтоохыг зөвшөөрөх зэргээр эдгээр этгээдийг хамгаалалтад авах журам тогтоох;

(b) мэдүүлгийг видео болон бусад тохиромжтой хэрэгсэл зэрэг харилцаа холбооны технологи ашиглах замаар өгөхийг зөвшөөрөх зэргээр гэрч, шинжээчийн аюулгүй байдлыг хангах хэлбэрээр мэдүүлэг өгөхийг тэдэнд зөвшөөрөх баримт нотолгооны журам боловсруулан гаргах.

3. Оролцогч улсууд энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээдийг нүүлгэн шилжүүлэх талаар бусад улстай гэрээ, хэлцэл эсхүл тохиролцоо хийх асуудлыг шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

4. Хохирогч нь гэрчээр оролцож байгаа тохиолдолд энэ зүйлийн зохицуулалтыг мөн адил хэрэглэнэ.

5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аливаа үе шатанд гэмт хэрэгтний эсрэг үзэл бодол, зовнилоо аюулгүй байдлаа хангасан байдлаар танилцуулж, хэлэлцүүлэх бололцоог хохирогчид олгох асуудлыг Оролцогч улс бүр өөрийн үндэсний хууль тогтоомжид тусган хэрэгжүүлнэ.

33 дугаар зүйл. Мэдээлэгч этгээдийг хамгаалах

Оролцогч улс бүр энэхүү конвенцод заасан гэмт хэргийн талаарх аливаа баримт нотолгоог үнэнч шударгаар, үндэслэлтэйгээр эрх бүхий байгууллагад мэдээлж буй аливаа этгээдийг шударга бус хандлагаас хамгаалах зохих арга хэмжээг дотоодын эрх зүйн тогтолцоондоо нэвтрүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

34 дүгээр зүйл. Авлигын үйлдлийн үр дагавар

Оролцогч улс бүр гуравдагч талын үнэнч шударгаар олж авсан эрхийг зохих ёсоор харгалзан үзэж авлигын үр дагаврыг шийдвэрлэх арга хэмжээг үндэсний хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн батална. Үүнтэй холбогдуулан Оролцогч улсууд авлигыг эрх зүйн үр дагавартай хүчин зүйл гэж үзэн авлигатай холбоотой гэрээг цуцлах, хүчингүй болгох, концесс болон бусад адилтгах баримт бичгийг хэрэгжүүлэхээс татгалзах эсхүл эрх зүйн хамгаалалтын аливаа бусад арга хэмжээг авч хэрэгжүүлж болно.

35 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлөх

Авлигын үйлдлийн улмаас хохирсон хуулийн этгээд, хувь хүн хохирлоо нөхөн төлүүлэхийн тулд уг хохирлыг хариуцах этгээдийн эсрэг хэрэг, маргаан үүсгүүлэх эрхийг нь хангахад шаардлагатай байж болох зохицуулалтыг Оролцогч улс бүр үндэсний хууль тогтоомжийнхоо зарчимд нийцүүлэн батална.

36 дугаар зүйл. Эрх бүхий тусгай байгууллага

Оролцогч улс бүр эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн хууль сахиулах замаар авлигатай тэмцэх чиг үүрэгтэй нэг эсхүл тодорхой тооны тусгай байгууллага, этгээдийг байгуулан ажиллуулна. Ийм байгууллага эсхүл этгээдийг чиг үүргээ үр дүнтэйгээр, аливаа зүй бус нөлөөллөөс ангид биелүүлэхэд шаардлагатай хараат бус байдлыг Оролцогч улс нь эрх зүйн тогтолцооны тулгуур зарчимдаа нийцүүлэн баталгаажуулна. Үүний зэрэгцээ тухайн байгууллага, этгээдийн ажилтнуудыг үүргээ биелүүлэхэд нь шаардлагатай зохих сургалтад хамруулж, шаардлагатай хөрөнгө, нөөцөөр хангана.

37 дугаар зүйл. Хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах

1. Энэхүү конвенцод заасан гэмт хэргийг үйлдэхэд оролцож буй болон оролцсон хүмүүс тухай хэргийг мөрдөн шалгах, баримт нотолгоо цуглуулахад хэрэг болох мэдээллийг эрх бүхий байгууллагад өгөх болон гэмт хэргээс олох орлогыг таслан зогсоох, буцаахад дөхөм болох бодит, тодорхой тусламжийг эрх бүхий байгууллагад үзүүлэхийг хөхиүлэн дэмжих зохих арга хэмжээг Оролцогч улс бүр авч хэрэгжүүлнэ.

2. Оролцогч улс бүр энэхүү конвенцод заасан гэмт хэргийг мөрдөн шалгах, яллахад идэвхтэй хамтран ажиллаж буй яллагдагчийн ялыг зохих тохиолдолд хөнгөрүүлэх боломж олгоход анхаарна.

3. Оролцогч улс бүр энэхүү конвенцод заасан н гэмт хэргийг мөрдөн шалгах, яллахад идэвхтэй хамтран ажиллаж буй этгээдийг ялаас чөлөөлөх зохицуулалтыг үндэсний хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн батлахад анхаарал хандуулна.

4. Хамтран ажиллах этгээдийг энэхүү конвенцын 32 дугаар зүйлд заасны дагуу хамгаалах бөгөөд чингэхдээ шаардлагатай ялгааг харгалзан үзнэ.

5. Нэг Оролцогч улсад оршиж буй энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээд нөгөө Оролцогч улсын эрх бүхий байгууллагатай идэвхтэй хамтран ажиллах боломжтой тохиолдолд тусламж авч байгаа улсаас энэ зүйлийн 2 болон 3 дахь хэсэгт заасан ял хөнгөрүүлэх, чөлөөлөх боломж олгох асуудлыг Оролцогч улсууд үндэсний хууль тогтоомжийн хүрээнд гэрээ, хэлэлцээр, байгуулах, тохиролцоо хийх байдлаар шийдвэрлэж болно.

38 дугаар зүйл. Үндэсний эрх бүхий байгууллага хоорондын хамтын ажиллагаа

Оролцогч улс бүр нэг талаас нийтийн эрх бүхий байгууллага ба нийтийн албан тушаалтан, нөгөө талаас эрүүгийн хэргийг мөрдөн шалгах, яллах эрх бүхий байгууллага хоорондын хамтын ажиллагааг үндэсний хуулийнхаа дагуу хөхиүлэн дэмжихэд шаардлагатай байж болох арга хэмжээг авна. Ийм хамтын ажиллагаанд дараах зүйл багтаж болно. Үүнд:

(а) энэхүү Конвенцын 15, 21, 23 дугаар зүйлийн дагуу тогтоосон аливаа гэмт хэргийг үйлдсэн гэж үзэх үндэслэл байгаа нөхцөлд мөрдөн шалгах, яллах эрх бүхий байгууллагад энэ талаар өөрийн санаачилгаар мэдээлэх; эсхүл

(b) мөрдөн шалгах, яллах эрх бүхий байгууллагад хүсэлтийнх нь дагуу шаардлагатай бүх мэдээллийг өгөх.

39 дүгээр зүйл. Үндэсний эрх бүхий байгууллага, хувийн хэвшил хоорондын хамтын ажиллагаа

1. Оролцогч улс бүр энэхүү конвенцод заасан гэмт хэргийг үйлдэхтэй холбоотой асуудлаар үндэсний мөрдөн шалгах, яллах эрх бүхий байгууллага болон хувийн хэвшлийн байгууллага, ялангуяа, санхүүгийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг үндэсний хуулийнхаа дагуу хөхиүлэн дэмжихэд шаардлагатай байж болох арга хэмжээг авна.

2. Оролцогч улс бүр энэхүү конвенцод заасан гэмт хэрэг үйлдэгдсэн талаар өөрийн нь харьяат болон нутаг дэвсгэрт нь байнга оршин суугч бусад этгээд үндэсний мөрдөн шалгах, яллах эрх бүхий байгууллагад мэдээлж байхыг урамшуулан дэмжинэ.

40 дүгээр зүйл. Банкны нууцлал

Оролцогч улс бүр энэхүү конвенцод заасан гэмт хэрэгт эрүүгийн мөрдөн шалгах ажиллагааг дотооддоо явуулах тохиолдолд банкны нууцлалын тухай хуулийг хэрэглэхтэй холбогдон гарч болох саад бэрхшээлийг даван туулах зохих механизм дотоодын эрх зүйн тогтолцоонд нь байх явдлыг хангасан байна.

41 дүгээр зүйл. Ял шийтгүүлж байсан эсэх талаарх бүртгэл

Оролцогч улс бүр энэхүү конвенцод заасан гэмт хэрэгтэй холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах зорилгоор сэжигтэн этгээдийн өөр улсад урьд нь ял шийтгүүлж байсан талаарх мэдээллийг өөрийн зохистой гэж үзсэн нөхцөл, зорилгоор харгалзан үзэхэд шаардлагатай байж болох хууль тогтоомж батлах болон бусад арга хэмжээг авч болно.

42 дугаар зүйл. Харьяалал тогтоох

1. Оролцогч улс бүр энэхүү конвенцод заасан гэмт хэргийг дор дурдсан байдлаар үйлдсэн тохиолдолд харьяаллыг нь тогтоох зохицуулалт батална. Үүнд:

(a) гэмт хэргийг тухайн Оролцогч улсын нутаг дэвсгэрт үйлдсэн; эсхүл

(b) тухайн улсын далбааг мандуулсан хөлөг онгоц дээр эсхүл хуулийн дагуу тухайн улсад бүртгэгдсэн агаарын хөлөг онгоц дээр гэмт хэргийг үйлдсэн.

2. Энэхүү конвенцын 4 дүгээр зүйлд заасныг харгалзан аливаа гэмт хэргийг дор дурдсан байдлаар үйлдсэн бол Оролцогч улс харьяаллыг мөн тогтоох зохицуулалт батална. Үүнд:

(a) тухайн Оролцогч улсын харьяат иргэний эсрэг үйлдсэн; эсхүл

(b) тус улсын иргэн эсхүл тус улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг харьяалалгүй этгээд үйлдсэн;

(c) тухайн гэмт хэрэг нь энэхүү конвенцын 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (b)(ii)-т заасан гэмт хэргүүдийн нэг нь бөгөөд түүнийг энэхүү конвенцын 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (a)(i) эсхүл (ii) эсхүл (b)(i)-д заасан гэмт хэргийг тус улсын нутаг дэвсгэр дотор үйлдэх зорилготой байсан боловч тус улсын нутаг дэвсгэрийн гадна үйлдсэн; эсхүл

(d) тухайн Оролцогч улсын эсрэг үйлдсэн.

3. Энэхүү конвенцын 44 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхдээ энэхүү конвенцод заасан гэмт хэргийн сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа бөгөөд тухайн улс өөрийн нь харьяат гэсэн ганц үндэслэлээр уг этгээдийг бусад улсад шилжүүлэн өгөхгүй байх тохиолдолд Оролцогч улс бүр шаардлагатай байдлаар ийм хэрэгт харьяалал тогтоох арга хэмжээг авна.

4. Сэжигтэн этгээд нутаг дэвсгэрт нь байгаа бөгөөд тухайн улс уг этгээдийг шилжүүлэн өгөхгүй тохиолдолд энэхүү конвенцод заасан гэмт хэрэгт харьяалал тогтоох зохицуулалтыг Оролцогч улс бүр батална.

5. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан харьяаллын дагуу аливаа Оролцогч улс тодорхой хэргийг хянан шийдвэрлэх явцдаа тухайн гэмт үйлдлийг өөр Оролцогч улсад мөрдөн шалгаж, яллаж эсхүл шүүн таслах ажиллагаа явуулж байгааг тухай мэдээлэл авсан эсхүл бусад байдлаар олж мэдсэн бол хэрэг хянан шийдвэрлэж байгаа улсуудын эрх бүхий байгууллагууд үйл ажиллагаагаа уялдуулан хэрэгжүүлэхээр харилцан зөвшилцөнө.

6. Энэхүү конвенц нь олон улсын эрх зүйн нийтлэг хэм хэмжээг хөндөхгүй бөгөөд аливаа Оролцогч улс нь үндэсний хууль тогтоомждоо зааснаар эрүүгийн хэргийн харьяаллыг тогтоон шийдвэрлэхэд саад болохгүй.

IV БҮЛЭГ

Олон улсын хамтын ажиллагаа

43 дугаар зүйл. Олон улсын хамтын ажиллагаа

1. Оролцогч улсууд эрүүгийн асуудлаар энэхүү конвенцын 44-50 дугаар зүйлийн дагуу хамтран ажиллана. Зохих тохиолдолд, дотоодын эрх зүйн тогтолцоотой нь нийцэж байвал Оролцогч улсууд авлигатай холбогдсон мөрдөн шалгах ажиллагаа, иргэний ба захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие биедээ туслалцаа үзүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

2. Тухайн үйлдлийг хоёр улсын аль аль нь гэмт хэрэг гэж хуульчилсан байх зарчмыг олон улсын хамтын ажиллагааны явцад шаардаж буй тохиолдолд, хэрэв туслалцаа үзүүлэх хүсэлтэд дурдагдсан гэмт хэргийн шинжтэй үйлдэл нь Оролцогч улсын аль алиных нь хуулиар эрүүгийн хэрэгт тооцогддог бол (уг гэмт хэргийг хүсэлт хүлээн авагч Оролцогч улсын хуулиар хүсэлт гаргагч Оролцогч улсын хуульд заасан гэмт хэргийн адил ангилалд багтаадаг эсэх эсхүл адил нэр томъёогоор нэрлэдэг эсэхээс үл хамааран) уг зарчмыг хангаж байна гэж үзнэ.

44 дүгээр зүйл. Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх

1. Гэмт этгээдийг шилжүүлэн авах хүсэлтэд дурдсан хүсэлт хүлээн авагч Оролцогч улсын нутаг дэвсгэрт байгаа гэмт этгээдэд хүсэлт гаргагч болон хүсэлт хүлээн авагч Оролцогч улсуудын аль алиных нь үндэсний хуулиар ял шийтгэл оногдуулахаар заасан тохиолдолд энэхүү конвенцын энэ зүйл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчилнэ.

2. Энэхүү конвенцод гэмт хэрэг гэж үзэхээр заасан боловч Оролцогч улсын үндэсний хууль тогтоомжид ял шийтгэл оногдуулахаар заагаагүй аливаа гэмт хэргийг үйлдсэн гэмт этгээдийг шилжүүлэн өгөхийг тухайн оролцогч улс хуулиараа зөвшөөрсөн бол тийнхүү шилжүүлэн өгөхөд энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан зохицуулалт саад болохгүй.

3. Хэрэв гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай хүсэлтэд хэд хэдэн тусдаа гэмт хэргийг дурдсан бөгөөд тэдгээрийн ядаж нэг нь энэхүү зүйлийн дагуу шилжүүлэн өгөх хэрэг, бусад нь хорих ял эдлүүлэх хугацаанаасаа хамааран шилжүүлэн өгөхгүй гэмт боловч энэхүү конвенцод заасан гэмт хэрэг мөн бол хүсэлт хүлээн авагч Оролцогч улс энэ зүйлийг баримтлан тэдгээр гэмт этгээдүүдийг бүгдийг нь шилжүүлж болно.

4. Энэ зүйл хэрэглэгдэх гэмт хэрэг бүрийг Оролцогч улсуудын хооронд байгуулсан гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай аливаа гэрээнд оруулсан гэж тооцно. Оролцогч улсууд хоорондоо байгуулах гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай гэрээ бүрдээ эдгээр гэмт хэргийг шилжүүлэн өгөх гэмт хэрэгт тооцож оруулах үүрэг хүлээнэ. Оролцогч улс нь хуулиараа тийнхүү зөвшөөрсөн бол энэхүү конвенцыг шилжүүлэн өгөх үндэс болгон ашиглаж байгаа тохиолдолд энэхүү конвенцод заасан аль нэг гэмт хэргийг улс төрийн гэмт хэрэг гэж үзэхгүй.

5. Хэрэв гэмт этгээдийг шилжүүлэн гэрээний үндсэн дээр өгөх нөхцөл тавьдаг Оролцогч улс түүнтэй гэрээ байгуулаагүй нөгөө Оролцогч улсаас шилжүүлэн өгөх тухай хүсэлт хүлээн авбал энэхүү конвенцыг энэ зүйл үйлчлэх аливаа гэмт хэрэгт буруутай этгээдийг шилжүүлэн өгөх эрх зүйн үндэслэл гэж үзэж болно.

6. Гэрээний үндсэн дээр шилжүүлэн өгөх нөхцөл тавьдаг Оролцогч улс:

(а) энэхүү конвенцыг эрх зүйн үндэслэл болгон энэхүү конвенцод оролцогч бусад улстай гэмт этгээдийг шилжүүлэн өгөх асуудлаар хамтран ажиллах эсэхээ энэхүү конвенцыг соёрхон баталсан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, баталсан эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахдаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ;

(b) хэрэв энэхүү конвенцыг гэмт этгээд шилжүүлэн өгөх асуудлаар хамтран ажиллах эрх зүйн үндэслэлд тооцохгүй бол энэ зүйлийг хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай байдлаар энэхүү конвенцод оролцогч бусад улстай гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай гэрээ байгуулахыг эрмэлзэнэ.

7. Гэмт этгээдийг гэрээний үндсэн дээр шилжүүлэн өгөх нөхцөл тавьдаггүй Оролцогч улсууд конвенцын энэ зүйлд хамаарах гэмт хэргийг шилжүүлэн өгөх гэмт хэрэг байхаар харилцан зөвшөөрнө.

8. Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх ажиллагааг хүсэлт хүлээн авагч Оролцогч улсын үндэсний хууль тогтоомж болон шилжүүлэн өгөх тухай холбогдох гэрээнд заасан нөхцөлүүд, түүний дотор шилжүүлэн өгөхөд хамгийн хөнгөн ял оногдуулах шаардлагатай холбоотой нөхцөл болон хүсэлт хүлээн авагч Оролцогч улс шилжүүлэн өгөхөөс татгалзаж болох үндэслэл зэргийн дагуу гүйцэтгэнэ.

9. Оролцогч улсууд үндэсний хуулиа мөрдөхийн сацуу конвенцын энэхүү зүйлд хамаарах аливаа гэмт хэрэгтэй холбогдуулан гэмт этгээдийг шилжүүлэн өгөх ажиллагааг аль болох шуурхай хэрэгжүүлж, нотлох баримтад тавих шаардлагыг хялбар болгох чиглэлээр хүчин чармайлт гаргана.

10. Зайлшгүй шаардлагатай бөгөөд хойшлуулшгүй гэж үзэх үндэслэлтэй бол хүсэлт гаргагч Оролцогч улсын шилжүүлэн өгөх хүсэлтэд үндэслэн нутаг дэвсгэрт нь байгаа гэмт этгээдийг түр саатуулах эсхүл түүнийг шилжүүлэн өгөхөд бэлэн байлгахад шаардлагатай бусад арга хэмжээг үндэсний хууль тогтоомж болон гэмт этгээдийг шилжүүлэн өгөх гэрээний дагуу авч хэрэгжүүлж болно.

11. Конвенцын энэ зүйлд заасан гэмт хэргийн сэжигтэн этгээд тухайн улсын нутаг дэвсгэрт байгааг тогтоосон боловч хүсэлт хүлээн авсан Оролцогч улс тухайн этгээдийг өөрийн улсын харьяат гэсэн ганц үндэслэлээр шилжүүлэн өгөхгүй байх нөхцөл үүссэн бол эрх бүхий байгууллагад үндэслэлгүйгээр саатуулахгүйгээр хүсэлт гаргасан Оролцогч улсад хэргийг яллуулахаар даруй шилжүүлнэ. Эдгээр эрх бүхий байгууллагууд нь тухайн хэргийн талаар үндэсний хууль тогтоомжид заасан бусад ноцтой гэмт хэргийг шийдвэрлэдэгтэй адил байдлаар шийдвэр гаргаж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулна. Холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд ялангуяа тодорхой ажиллагааг хэрэгжүүлэх болон нотлох баримтаар хангах асуудлаар Оролцогч улсууд хамтран ажиллана.

12. Оролцогч улс өөрийн харьяат иргэнийг шилжүүлэн өгөхдөө эсхүл бусад шаардлагатай байдлаар шилжүүлэхдээ ирүүлсэн хүсэлттэй холбогдуулан гэмт этгээдийн хэргийг шүүн таслах болон хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагааны үр дүнд оногдуулсан ялыг шийтгэлийг эдлүүлэхээр тухайн этгээдийг харьяалалтай улсад нь заавал буцаан шилжүүлэх нөхцөлтэй байхаар үндэсний хуулиар нь зохицуулсан бөгөөд хүсэлт гаргагч болон хүлээн авагч улсууд энэ нөхцөлийг шаардлагатай байж болох бусад нөхцөлийн хамт харилцан зөвшөөрсөн бол энэхүү зүйлийн 11 дэх хэсэгт заасан гэмт этгээдийг шилжүүлэн өгөх үүргээс чөлөөлөх хангалттай үндэслэл болно.

13. Аливаа Оролцогч улс нь гэмт этгээдийг ял эдлүүлэхээр улсдаа шилжүүлэн авах хүсэлтийг энэхүү конвенцод нэгдсэн аливаа улсад гаргасныг гэмт этгээд нь хүсэлт хүлээн авагч улсын харьяат иргэн гэсэн үндэслэлээр хүлээж авахаас татгалзах үндэслэлтэй тохиолдолд хүсэлт хүлээн авсан улс нь гэмт этгээдэд хүсэлт гаргагч улсын үндэсний эрх зүйн зохицуулалтын дагуу оногдуулсан ял болон ялын үлдсэн хэсгийг эдлүүлэх асуудлыг хүсэлт гаргагч улсын зүгээс тусгайлан хандсаны дагуу үндэсний эрх зүйн зохицуулалтын хүрээнд шийдвэрлэнэ.

14. Конвенцын энэ зүйл үйлчлэх аль нэг гэмт хэргээс ашиг, орлого олсон аливаа этгээдэд холбогдуулан шалгаж буй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд түүнд шударгаар хандах, ялангуяа гэмт этгээд нутаг дэвсгэрт нь байгаа Оролцогч улсын үндэсний хууль тогтоомжоор олгосон бүхий л эрх, баталгааг эдлэх боломжоор хангана.

15. Хүсэлт хүлээн авагч Оролцогч улс тэрхүү хүсэлтээр гэмт этгээдийг хүйс, арьс үндэс, шашин шүтлэг, иргэний харьяалал, үндэс угсаа эсхүл улс төрийн итгэл үнэмшлийнх нь үндсэн дээр яллах буюу шийтгэх зорилготой гэж эсхүл тухайн хүсэлтийг биелүүлснээр өмнө дурдсан аль нэг үндэслэлээр тухайн этгээдэд хохирол учирна гэж үзэх үндэслэл байгаа тохиолдолд энэхүү конвенцын аливаа зохицуулалтыг заавал шилжүүлэн өгөх үүрэг хүлээлгэж байгаа гэж тайлбарлахгүй.

16. Оролцогч улсууд тухайн гэмт хэргийг санхүүгийн асуудалтай холбоотой гэх ганц үндэслэлээр гэмт этгээдийг шилжүүлэн өгөх хүсэлтийг биелүүлэхээс татгалзаж болохгүй.

17. Хүсэлт хүлээн авсан Оролцогч улс гэмт этгээдийг шилжүүлэн өгөхөөс татгалзах шийдвэр гаргахаасаа өмнө хүсэлт гаргагч Оролцогч улсад гэм буруутай гэж үзэх үндэслэлээ тайлбарлах, холбогдох мэдээлэл өгөх хангалттай боломжийг олгохын тулд зохих байдлаар зөвлөлдөнө.

18. Оролцогч улсууд гэмт этгээдийг шилжүүлэн өгөх үйл ажиллагааны үр дүнг нь дээшлүүлэх зорилгоор хоёр болон олон талт гэрээ, хэлэлцээр, тохиролцоог байгуулахыг эрмэлзэнэ.

45 дугаар зүйл. Ялтан шилжүүлэх

Энэхүү конвенцод заасан гэмт хэргийг үйлдсэний улмаас хорих ял болон эрх чөлөөгөө бусад хэлбэрээр хасуулах ял шийтгүүлсэн ялтны ялыг нутаг дэвсгэртээ эдлүүлж дуусгахын тулд Оролцогч улсууд ялтныг эх оронд нь шилжүүлэх талаар хоёр болон олон талт гэрээ, хэлэлцээр, тохиролцоо байгуулж болно.

46 дугаар зүйл. Эрх зүйн харилцан туслалцаа

1. Оролцогч улсууд энэхүү конвенцод хамаарах гэмт хэрэгтэй холбогдуулан мөрдөн шалгах, яллах, шүүх ажиллагаа явуулахад чиглэсэн боломжит хамгийн өргөн хүрээний эрх зүйн харилцан туслалцааг үзүүлнэ.

2. Энэхүү конвенцын 26 дугаар зүйлийн дагуу хуулийн этгээд хариуцлага хүлээж болох гэмт хэрэгт мөрдөн шалгах, яллах, шүүн таслах ажиллагаа явуулахтай холбоотой эрх зүйн туслалцааг хүсэлт хүлээн авагч Оролцогч улс нь өөрийн холбогдох хууль тогтоомж, гэрээ, хэлэлцээр, тохиролцооны боломжит бүхий л хэмжээнд хүсэлт гаргагч Оролцогч улсад үзүүлнэ.

3. Энэхүү зүйлийн дагуу үзүүлэх эрх зүйн харилцан туслалцааг дор дурдсан аль ч зорилгоор хүсэж болно. Үүнд:

(a) тодорхой этгээдээс нотолгоо, мэдээлэл авах;

(b) шүүхийн баримт бичиг гардуулах;

(c) нэгжлэг хийх, хөрөнгө царцаах, битүүмжлэх;

(d) объект, газарт үзлэг хийх;

(e) мэдээлэл, эд мөрийн баримт, шинжээчийн дүгнэлт гаргуулах;

(f) холбогдох баримт бичиг, материал, түүний дотор засгийн газар, банк, санхүүгийн, компани, аж ахуйн нэгжийн баримт бичгийн эх хувь буюу баталгаат хуулбар гаргаж өгөх;

(g) гэмт хэрэг үйлдэж олсон ашиг, орлого, хөрөнгө, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан хэрэгсэл, бусад зүйлийг нотлох баримт бүрдүүлэх зорилгоор илрүүлэх, хөдөлгөөнийг мөрдөх;

(h) холбогдох этгээдийг хүсэлт гаргагч Оролцогч улсын байгууллагад сайн дураараа биечлэн очих боломж олгох;

(i) хүсэлт хүлээн авагч Оролцогч улсын үндэсний хууль тогтоомжид үл харшлах аливаа бусад туслалцаа үзүүлэх;

(j) энэхүү конвенцын V бүлэгт заасны дагуу гэмт хэрэг үйлдэж олсон ашиг, орлогыг илрүүлэх, битүүмжлэх, хөдөлгөөнийг мөрдөх;

(к) энэхүү конвенцын V бүлэгт заасны дагуу хөрөнгө буцаах.

4. Конвенцод оролцогч тодорхой улсын эрх бүхий байгууллагаас мөрдөн шалгах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад эсхүл амжилттай явуулж дуусгахад нь дэмжлэг болно гэж эсхүл тухайн Оролцогч улс энэхүү конвенцын дагуу хүсэлт гаргах үндэслэл болно гэж үзвэл аливаа Оролцогч улсын эрх бүхий байгууллага нь үндэсний хууль тогтоомжийнхоо хүрээнд эрүүгийн хэргийн тухай мэдээллийг Оролцогч бусад улсын эрх бүхий байгууллагад урьдчилсан хүсэлт авалгүйгээр дамжуулж болно.

5. Энэхүү зүйлийн 4 дэх хэсгийн дагуу мэдээллийг дамжуулахдаа мэдээлэл хүргүүлж буй эрх бүхий байгууллагаас өөрийн улсад явуулж байгаа мөрдөн шалгах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлөхгүй байдлаар дамжуулна. Мэдээллийг хүлээн авагч эрх бүхий байгууллага уг мэдээллийн нууцлалыг тодорхой хугацаанд хадгалах нөгөө талын хүсэлтийг биелүүлж эсхүл түүнийг ашиглах талаар тавьсан хязгаарлалтыг мөрдөнө. Гэхдээ энэ нь мэдээллийг хүлээн авагч Оролцогч улс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад яллагдагчийн гэм буруугүйг нотлох мэдээллийг задруулахад саад болохгүй. Ийм тохиолдолд мэдээлэл хүлээн авагч Оролцогч улс мэдээллийг задруулахаас өмнө мэдээлэл дамжуулагч Оролцогч улсад мэдэгдэж, мэдээлэл дамжуулагч Оролцогч улстай энэ талаар хүсэлт хүлээн авсан бол зөвлөлдөнө. Хэрэв онцгой тохиолдолд урьдчилан мэдэгдэх боломжгүй бол мэдээлэл хүлээн авагч Оролцогч улс мэдээлэл дамжуулагч Оролцогч улсад тийнхүү задруулсан талаар шуурхай мэдээлнэ.

6. Энэ конвенцын энэхүү зүйлийн зохицуулалт нь эрх зүйн харилцан туслалцааны асуудлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн зохицуулдаг эсхүл цаашид зохицуулах хоёр болон олон талт аливаа бусад гэрээгээр хүлээх үүрэгт нөлөөлөхгүй.

7. Тухайн Оролцогч улсууд хоорондоо эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээ байгуулаагүй тохиолдолд энэхүү зүйлийн дагуу гаргасан хүсэлтийн хувьд энэ зүйлийн 9-29 дэх хэсгийг хэрэглэнэ. Хэрэв тухайн Оролцогч улсууд хоорондоо ийм гэрээ байгуулсан бөгөөд тухайн гэрээний оронд энэ зүйлийн 9-29 дэх хэсгийг хэрэглэхээр тохиролцоогүй бол тухайн гэрээний холбогдох заалтыг хэрэглэнэ. Хамтын ажиллагаанд нь тус дөхөм болох бол энэ зүйлийн эдгээр заалтыг хэрэглэхийг Оролцогч улсуудад тууштай санал болгож байна.

8. Оролцогч улсууд банкны нууцлал гэсэн үндэслэлээр энэхүү зүйлийн дагуу эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхээс татгалзаж үл болно.

9. (a) Тухайн үйлдлийг хоёр улсын аль аль нь гэмт хэрэг гэж тооцдог байх зарчим үйлчлэхгүй тохиолдолд хүсэлт авагч Оролцогч улс энэ зүйлийн дагуу туслалцаа үзүүлэх хүсэлтэд хариу өгөхдөө энэхүү конвенцын 1 дүгээр зүйлд заасны дагуу энэхүү конвенцын зорилгыг харгалзан үзнэ.

(b) Оролцогч улсууд тухайн үйлдлийг хоёр улсын аль аль нь гэмт хэрэг гэж тооцдог байх зарчим үйлчлэхгүй гэсэн үндэслэлээр энэ зүйлийн дагуу туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно. Гэвч хүсэлт хүлээн авагч Оролцогч улс албадлагын арга хэмжээ агуулаагүй эрх зүйн туслалцааг эрх зүйн тогтолцооныхоо үндсэн зарчимд нийцүүлэн үзүүлнэ. Туслалцаа үзүүлэх хүсэлт нь ялимгүй бага үр дүнтэй бол эсхүл хүсэлтэд дурдагдсан хамтын ажиллагаа эсхүл туслалцааг энэхүү конвенцын өөр заалтын дагуу үзүүлж болох асуудалтай холбоотой тохиолдолд эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно.

(c) Оролцогч улс бүр гэмт үйлдлийг хоёр улсын аль аль нь гэмт хэрэг гэж тооцдог байх зарчим үйлчлэхгүй тохиолдолд ч энэхүү зүйлд заасны дагуу аль болох өргөн хэмжээгээр эрх зүйн туслалцаа үзүүлэх боломжтой байхад чиглэсэн эрх зүйн зохицуулалттай болоход анхаарал хандуулна.

10. Оролцогч улсын нутаг дэвсгэрт цагдан хоригдож эсхүл ял эдэлж байгаа этгээдийг энэхүү конвенцод хамаарах гэмт хэрэгтэй холбогдуулан мөрдөн шалгах, яллах болон шүүн таслах ажиллагаанд нотлох баримт бүрдүүлэхэд хэн болохыг тогтоох,

мэдүүлэг авах эсхүл өөрөөр туслах зорилгоор оролцогч нөгөө улсад байлгахыг хүссэн тохиолдолд дараах нөхцөлийг хангасан бол тухайн этгээдийг шилжүүлж болно. Үүнд:

(а) тухайн хүн сайн дураараа ухамсарлаж зөвшөөрлөө өгсөн;

(б) оролцогч аль аль улс нь зохистой гэж үзсэн нөхцөлийн дагуу тухайн оролцогч хоёр улсын эрх бүхий байгууллагууд тохиролцсон.

11. Энэхүү зүйлийн 10 дахь хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор:

(а) тухайн этгээдийг шилжүүлсэн Оролцогч улс өөр арга хэмжээ хэрэгжүүлэхийг шаардсан эсхүл өөр эрх олгосноос бусад тохиолдолд шилжүүлэн авсан Оролцогч улс тухайн этгээдийг цагдан хорионд байлгах бүрэн эрх, үүрэгтэй байна;

(б) оролцогч хоёр улсын эрх бүхий байгууллагууд урьдчилан эсхүл өөрөөр тохиролцсон бол тухайн этгээдийг шилжүүлэн авсан Оролцогч улс түүнийг шилжүүлсэн Оролцогч улсын мэдэлд буцаан өгөх үүргээ шуурхай хэрэгжүүлнэ;

(с) тухайн этгээдийг шилжүүлэн авсан Оролцогч улс түүнийг буцаан шилжүүлэн өгөх ажиллагаа эхлүүлэхийг шилжүүлэн өгсөн Оролцогч улсаас шаардахгүй;

(д) тухайн этгээдийн түүнийг шилжүүлэн авсан Оролцогч улсад цагдан хоригдож байсан хугацааг түүнийг шилжүүлсэн Оролцогч улсад эдэлж буй ялын хугацаанд оруулж тооцно.

12. Энэ зүйлийн 10 болон 11 дэх хэсгийн дагуу аливаа этгээдийг шилжүүлсэн Оролцогч улс зөвшөөрөөгүй бол тухайн этгээдийг аль улсын харьяат гэдгээс үл хамааран, шилжүүлсэн Оролцогч улсын нутаг дэвсгэрээс гарахаас өмнө хийсэн аливаа үйлдэл, эс үйлдэл эсхүл ял шийтгүүлсэнтэй нь холбогдуулан шилжүүлэн авсан Оролцогч улсын нутаг дэвсгэрт яллах, цагдан хорих, шийтгэх болон аливаа бусад хэлбэрээр хувийн эрх чөлөөг нь хязгаарлах арга хэмжээ авахгүй.

13. Оролцогч улс бүр эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг хүлээн авах, гүйцэтгэх эсхүл гүйцэтгүүлэхээр эрх бүхий байгууллагуудад дамжуулах асуудлыг хариуцсан эрх бүхий төв байгууллагыг томилно. Хэрэв аливаа Оролцогч улсад эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх өөр тогтолцоотой тусгай бүс, нутаг дэвсгэр байдаг бол Оролцогч улс нь тухайн бүс, нутаг дэвсгэрийн хувьд мөн адил чиг үүргийг гүйцэтгэх эрх бүхий төв байгууллагыг тусад нь томилж болно. Эрх бүхий эдгээр төв байгууллага нь хүлээж авсан хүсэлтийг шуурхай бөгөөд зохистойгоор гүйцэтгэх, дамжуулах явдлыг хангана. Хэрэв эрх бүхий төв байгууллага хүсэлтийг гүйцэтгүүлэхээр эрх бүхий байгууллагад дамжуулж байгаа бол тэрхүү эрх бүхий байгууллага уг хүсэлтийг шуурхай бөгөөд зохистойгоор гүйцэтгэхийг хөхиүлэн дэмжинэ. Оролцогч улс бүр энэхүү конвенцыг соёрхон баталсан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, баталсан, нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахдаа дээрх зорилгоор томилсон эрх бүхий төв байгууллагынхаа талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай хүсэлт болон түүнтэй холбогдсон аливаа мэдээ, мэдээллийг Оролцогч улсуудын томилсон эрх бүхий төв байгууллагуудад дамжуулж байна. Энэхүү шаардлага нь ийм хүсэлт, мэдээ, мэдээллийг дипломат шугамаар, түүнчлэн яаралтай нөхцөл байдалд Оролцогч улсууд харилцан тохиролцсон нөхцөлд, хэрэв боломжтой бол Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллагаар дамжуулан авч байхыг шаардах аливаа Оролцогч улсын эрхийг хөндөхгүй.

14. Хүсэлтийг бичгээр эсхүл бичгийн хэлбэрт оруулах боломжтой аливаа хэрэгслээр, хүсэлт хүлээн авагч Оролцогч улсын хүлээн авах хэлээр, тухайн хүсэлтийн жинхэнэ эсэхийг тогтоох боломжийг уг Оролцогч улсад олгох нөхцөлөөр гаргана. Оролцогч улс бүр энэхүү конвенцыг соёрхон баталсан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, баталсан, нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахдаа хүсэлт хүлээн авах хэлний талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ. Яаралтай нөхцөл байдал үүссэний улмаас Оролцогч улсууд харилцан тохиролцсоноор хүсэлтийг амаар гаргаж болох боловч бичгээр даруй баталгаажуулна.

15. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай хүсэлтэд дараах зүйлийг тусгана. Үүнд:

(a) хүсэлт гаргаж байгаа эрх бүхий байгууллагын нэр;

(b) тухайн хүсэлттэй холбоотой мөрдөн шалгах, яллах, шүүх ажиллагааны агуулга, шинж, түүнчлэн мөрдөн шалгах, яллах, шүүх ажиллагаа явуулж буй эрх бүхий байгууллагын нэр, чиг үүрэг;

(c) шүүхийн баримт бичиг гардуулах зорилготой хүсэлтээс бусад тохиолдолд холбогдох үйл баримтын товч танилцуулга;

(d) хүссэн туслалцааны талаарх тодорхойлолт болон мөрдвөл зохино гэж хүсэлт гаргагч Оролцогч улсын үзэж буй аливаа тодорхой журмын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

(e) бололцоотой бол холбогдох аливаа этгээдийг тодорхойлсон мэдээлэл, түүний байгаа газар болон иргэний харьяалал;

(f) нотлох баримт, мэдээлэл, арга хэмжээг хүссэн зорилго.

16. Хүсэлт хүлээн авагч Оролцогч улс тухайн хүсэлтийг үндэсний хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэхэд шаардлагатай эсхүл хүсэлтийг гүйцэтгэх ажиллагааг хөнгөвчлөн дэмжиж болох нэмэлт мэдээллийг хүсч болно.

17. Хүсэлтийг хүсэлт хүлээн авагч Оролцогч улсын үндэсний хууль тогтоомжийн дагуу, түүнчлэн хүсэлт хүлээн авагч Оролцогч улсын үндэсний хууль тогтоомжид харшлагагүй хэмжээнд бөгөөд боломжтой нөхцөлд тухайн хүсэлтэд заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

18. Аливаа хувь хүн аль нэг Оролцогч улсын нутаг дэвсгэрт байгаа бөгөөд оролцогч нөгөө улсын шүүхэд гэрч эсхүл шинжээчийн хувьд мэдүүлэг өгөх ёстой боловч хүсэлт гаргагч Оролцогч улсын нутаг дэвсгэрт биечлэн очих бололцоогүй эсхүл зохимжгүй байвал тухайн хувь хүн нутаг дэвсгэрт нь байгаа Оролцогч улс боломжтой бөгөөд үндэсний хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимтай нийцэж байвал видео уулзалтын хэлбэрээр мэдүүлэг авахыг нөгөө талын хүсэлтийн дагуу зөвшөөрч болно. Мэдүүлэг авах ажиллагааг хүсэлт гаргагч Оролцогч улсын шүүх явуулж, уг ажиллагаанд хүсэлт хүлээн авагч Оролцогч улсын шүүхийн төлөөллийг байлцуулахаар Оролцогч улсууд тохиролцож болно.

19. Хүсэлт гаргагч Оролцогч улс хүсэлт хүлээн авагч Оролцогч улсын урьдчилсан зөвшөөрөлгүйгээр түүний өгсөн мэдээлэл эсхүл нотлох баримтыг хүсэлтэд зааснаас өөр мөрдөн шалгах, яллах болон шүүх ажиллагааны зорилгоор дамжуулж, ашиглаж үл болно. Хүсэлт гаргагч Оролцогч улс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад яллагдагчийн гэм буруугүйг нотлох мэдээлэл, нотлох баримтыг задруулахад энэ зүйлийн аль ч зохицуулалт саад болохгүй. Ийм тохиолдолд хүсэлт гаргагч Оролцогч улс нь тийнхүү задруулахаас өмнө хүсэлт хүлээн авагч Оролцогч улсад мэдэгдэж, хүлээн авагч Оролцогч улстай түүний хүсэлтийн дагуу зөвлөлдөнө. Хэрэв онцгой тохиолдолд урьдчилан мэдэгдэх боломжгүй бол хүсэлт гаргагч Оролцогч улс хүсэлт хүлээн авагч Оролцогч улсад тийнхүү задруулсан талаар шуурхай мэдээлнэ.

20. Хүсэлт гаргагч Оролцогч улс нь хүсэлтийг гүйцэтгэхэд шаардлагатайгаас бусад тохиолдолд хүсэлт гаргасныг болон хүсэлтийн агуулгыг нууцлахыг хүсэлт хүлээн авагч Оролцогч улсаас шаардаж болно. Хэрэв хүсэлт хүлээн авагч Оролцогч улс нууцлах шаардлагыг биелүүлэх боломжгүй бол энэ тухайгаа хүсэлт гаргагч Оролцогч улсад даруй мэдээлнэ.

21. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхээс дараах тохиолдолд татгалзаж болно. Үүнд:

(a) хүсэлтийг энэ зүйлийн заалтуудтай нийцүүлж гаргаагүй бол;

(b) хүсэлт хүлээн авагч Оролцогч улс хүсэлтийг гүйцэтгэснээр түүний бүрэн эрхт байдал, аюулгүй байдал, олон нийтийн дэг журам, бусад зайлшгүй чухал ашиг сонирхлыг хөндөх магадлалтай гэж үзэж байгаа бол;

(c) хэрэв аль нэг гэмт хэрэгтэй холбогдуулан тодорхой арга хэмжээ авах хүсэлт гаргасан боловч түүнтэй адилтгах аливаа гэмт хэрэгтэй холбогдуулан хүсэлт хүлээн авагч

Оролцогч улсын эрх бүхий байгууллагуудад харьяаллын дагуу мөрдөн шалгах, яллах, шүүх ажиллагаа явуулах тохиолдолд ийм арга хэмжээ авахыг тухайн улсын үндэсний хууль тогтоомжоор хориглосон бол;

(d) хүсэлтийг биелүүлэх нь хүлээн авагч Оролцогч улсын эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхтэй холбогдсон эрх зүйн тогтолцоотой нь зөрчилдөхөөр бол.

22. Оролцогч улсууд тухайн гэмт хэргийг санхүүгийн асуудалтай мөн холбоотой гэж үздэг гэсэн ганц үндэслэлээр эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтийг биелүүлэхээс татгалзаж үл болно.

23. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхээс татгалзсан аливаа тохиолдолд шалтгаан, үндэслэлийг заана.

24. Хүсэлт хүлээн авагч Оролцогч улс эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг аль болох түргэн гүйцэтгэж, хүсэлт гаргагч Оролцогч улсаас санал болгосон аливаа эцсийн хугацааг аль болох баримтлах бөгөөд уг эцсийн хугацааны үндэслэлийг хүсэлтэд заасан байвал зохино. Хүсэлт гаргагч Оролцогч улс хүсэлтийг нь биелүүлэхээр хүсэлт хүлээн авагч Оролцогч улсын авч буй арга хэмжээний явц, байдлын талаар мэдээлэл өгөхийг үндэслэлтэйгээр хүсэж болно. Хүсэлт хүлээн авагч Оролцогч улс хүсэлт гаргагч Оролцогч улсаас үндэслэлтэйгээр хүссэний дагуу уг хүсэлтийг биелүүлж буй явц, байдлын талаар хариу өгнө. Туслалцаа цаашид хэрэггүй болсон үед хүсэлт гаргагч Оролцогч улс нь хүсэлт хүлээн авагч Оролцогч улсад даруй мэдээлнэ.

25. Явагдаж буй мөрдөн шалгах, яллах, шүүх ажиллагаанд саад учруулна гэсэн үндэслэлээр хүсэлт хүлээн авагч Оролцогч улс эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхийг хойшлуулж болно.

26. Энэхүү зүйлийн 21 дэх хэсгийн дагуу хүсэлтийг биелүүлэхээс татгалзах эсхүл энэхүү зүйлийн 25 дахь хэсгийн дагуу хүсэлтийг гүйцэтгэхийг хойшлуулахаасаа өмнө хүсэлт хүлээн авагч улс шаардлагатай нэмэлт болзол, нөхцөлөөр эрх зүйн туслалцаа үзүүлж болох асуудлыг дахин нягталж үзэх асуудлаар хүсэлт гаргагч улстай зөвлөлдөнө. Хэрэв хүсэлт гаргагч улс тэдгээр нөхцөлөөр туслалцаа авахыг зөвшөөрвөл тухайн нөхцөлийг эрх зүйн туслалцаанд ашиглана.

27. Оролцогч улсын хүсэлтээр тухайн улсын нутаг дэвсгэрт явагдаж буй мөрдөн шалгах ажиллагаанд мэдүүлэг өгөхийг болон мөрдөн шалгах, яллах, шүүх ажиллагаанд туслалцаа үзүүлэхийг зөвшөөрсөн гэрч, шинжээч эсхүл өөр этгээдийг хүсэлт хүлээн авагч Оролцогч улсын нутаг дэвсгэрээс гарахаас өмнө хийсэн аливаа үйлдэл, эс үйлдэл эсхүл гэмт хэрэгт холбогдсонтой нь холбогдуулан аливаа байдлаар яллах, цагдан хорих, шийтгэх, аливаа бусад хэлбэрээр хувийн эрх чөлөөг нь хязгаарлах арга хэмжээг хүсэлт гаргасан Оролцогч улсын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэхгүй боловч конвенцын энэхүү зүйлийн 12 дахь хэсэгт заасан зохицуулалтыг хэрэгжүүлэхэд энэ зохицуулалт хамаарахгүй. Гэрч, шинжээч эсхүл өөр этгээдийг хүсэлт гаргагч Оролцогч улсын нутаг дэвсгэрт цаашид байх шаардлагагүй гэж шүүхээс нь албан ёсоор мэдээлсэн өдрөөс хойш дараалсан арван таван өдрийн хугацаанд эсхүл Оролцогч улсуудын тохиролцсон аливаа хугацаанд тухайн Оролцогч улсын нутаг дэвсгэрээс гарах боломжтой байсан ч сайн дураараа үлдсэн эсхүл гарсныхаа дараа өөрийн хүслээр эргэж ирсэн тохиолдолд хувийн аюулгүй байдлыг хангах дээрх баталгаа үйлчлэхгүй.

28. Холбогдох Оролцогч улсууд өөрөөр тохиролцоогүй бол хүсэлт гүйцэтгэхтэй холбогдсон ердийн зардлыг хүсэлт хүлээн авагч Оролцогч улс хариуцна. Хэрэв хүсэлтийг биелүүлэхэд их хэмжээний эсхүл хэвийнээс илүү их зардал гарах нь тодорхой эсхүл гарч болохоор байвал Оролцогч улсууд зөвшилцөн хүсэлтийг гүйцэтгэх нөхцөл, болзол, түүнчлэн зардлыг аль улс хэрхэн хариуцахыг тодорхойлно.

29. Хүсэлт хүлээн авагч Оролцогч улс нь дараах байдлаар мэдээллийг гаргаж өгнө. Үүнд:

(а) үндэсний хууль тогтоомжид нь заасны дагуу нийтэд ил тод байж болох төрийн байгууллагын бүртгэл, материал, баримт бичиг болон мэдээллийн хуулбарыг хүсэлт гаргагч Оролцогч улсад гаргаж өгнө;

(б) үндэсний хууль тогтоомжид нь заасны дагуу нийтэд ил тод байхаар заагаагүй төрийн байгууллагын бүртгэл, материал, баримт бичиг болон мэдээллийн хуулбарыг бүтнээр нь, хэсэгчлэн эсхүл өөрийн зохистой гэж үзсэн нөхцөлийн дагуу хүсэлт гаргагч Оролцогч улсад өгөх асуудлыг өөрийн үзэмжээр шийдвэрлэнэ.

30. Оролцогч улсууд энэхүү зүйлд заасан зорилгод нийцсэн, энэ зүйлийн зохицуулалтын бодит хэрэгжилтийг хангасан, зохицуулалтуудыг нь илүү нарийвчлан сайжруулсан хоёр болон олон талт хэлэлцээр эсхүл тохиролцоог батлах боломжийг ашиглахыг эрмэлзэнэ.

47 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шилжүүлэх

Оролцогч улсууд энэхүү конвенцод заасан гэмт үйлдэлд ял оногдуулах зорилгоор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг харьяаллын дагуу нэгтгүүлэхээр бусад улсад шилжүүлэх боломжийг судлан үзэх бөгөөд ялангуяа хэд хэдэн улсын харьяалалд хамаарах тохиолдолд шүүн таслах ажиллагааг ийнхүү нэгтгэхээр шилжүүлэх нь зүйтэй.

48 дугаар зүйл. Хууль сахиулах талаар хамтран ажиллах

1. Оролцогч улсууд энэхүү конвенцод хамаарах гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд хууль сахиулах арга хэмжээний үр дүнг нэмэгдүүлэх үүднээс бие биетэйгээ тус тусын дотоодын эрх зүй ба захиргааны тогтолцоондоо нийцүүлэн нягт хамтран ажиллана. Тухайлбал, Оролцогч улсууд дараах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авна. Үүнд:

(а) энэхүү конвенцод хамаарах гэмт хэргийн бүх талын мэдээлэл, түүний дотор хэрэв холбогдох Оролцогч улсууд зохистой гэж үзсэн бол бусад гэмт үйлдэлтэй холбоотой мэдээллийг найдвартай, хурдан солилцох явдлыг хөнгөвчлөн дэмжихийн тулд эрх бүхий байгууллага, агентлаг, албадын хоорондын харилцаа холбоог бэхжүүлэх, шаардлагатай нөхцөлд харилцаа холбооны сувгийг бий болгох;

(б) энэхүү конвенцод хамаарах гэмт хэрэгтэй холбогдуулан дараах асуудлаар мөрдөн шалгах ажиллагаа явуулахад бусад Оролцогч улстай хамтран ажиллах:

(i) тухайн гэмт хэрэгт холбогдсон хэмээн сэжиглэгдэж байгаа этгээдийн хэн болох, хаана байгаа, түүний үйл ажиллагаа эсхүл холбогдох бусад этгээдийн байгаа газар;

(ii) гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого эсхүл тухайн гэмт хэргийг үйлдэх замаар олсон хөрөнгийн хөдөлгөөн;

(iii) тухайн гэмт хэргийг үйлдэхэд ашигласан эсхүл ашиглах зорилготой байсан хөрөнгө, тоног төхөөрөмж буюу бусад хэрэгслийн хөдөлгөөн;

(с) дүн шинжилгээ хийх эсхүл мөрдөн шалгах зорилгоор шаардлагатай зүйл эсхүл шаардлагатай хэмжээний бодисыг зохих тохиолдолд өгөх;

(d) энэхүү конвенцод хамаарах гэмт хэргийг үйлдэхэд ашигладаг тодорхой арга, хэрэгслийн талаарх мэдээлэл, түүний дотор хуурамч бичиг баримт, дуураймал, өөрчилсөн эсхүл хуурамч баримт бичиг, гэмт үйлдлийг нуун дарагдуулах зорилготой бусад хэрэгсэл ашиглах талаарх мэдээллийг бусад Оролцогч улстай зохих тохиолдолд солилцох;

(е) эрх бүхий байгууллага, агентлаг, албад хоорондын үр дүнтэй уялдаа холбоог хөнгөвчлөн дэмжих, ажилтнууд ба бусад шинжээчийн солилцоог хөхиүлэн дэмжих, түүний дотор холбогдох Оролцогч улсуудын хооронд байгуулсан хоёр талт хэлэлцээр, тохиролцооны дагуу харилцааны ажилтан томилох;

(f) энэхүү конвенцод хамаарах гэмт хэргийг эрт илрүүлэх зорилгоор мэдээлэл солилцож, зохих тохиолдолд авах захиргааны болон бусад арга хэмжээг уялдуулан зохицуулах.

2. Энэхүү конвенцыг хэрэгжүүлэх үүднээс оролцогч улсууд хууль сахиулах эрх бүхий байгууллагуудынхаа хооронд шууд хамтран ажиллах хоёр болон олон талт хэлэлцээр, тохиролцоо байгуулах, түүнчлэн тийм хэлэлцээр болон тохиролцоо байгаа бол нэмэлт, өөрчлөлт оруулах асуудалд анхаарал хандуулна. Холбогдох Оролцогч улсуудын хооронд тийм хэлэлцээр эсхүл тохиролцоо байхгүй тохиолдолд Оролцогч улсууд энэхүү конвенцод хамаарах гэмт хэрэгтэй холбогдуулан энэхүү конвенцыг хууль сахиулах байгууллага хоорондын хамтын ажиллагааны үндэс хэмээн үзэж болно. Аливаа зохих тохиолдолд Оролцогч улсууд хууль сахиулах байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор хэлэлцээр, тохиролцоо, түүний дотор олон улсын болон бүс нутгийн байгууллагуудын механизмыг бүрэн ашиглана.

3. Энэхүү конвенцод хамаарах гэмт хэргийг орчин үеийн технологи ашиглаж үйлдсэн тохиолдолд Оролцогч улсууд тэдгээр гэмт хэрэгтэй тэмцэх талаар бололцооныхоо хэрээр хамтран ажиллахыг чармайна.

49 дүгээр зүйл. Мөрдөн шалгах ажиллагааг хамтран явуулах

Оролцогч улсууд нэг эсхүл хэдэн улсад мөрдөн шалгах, яллах, шүүх ажиллагаа явагдаж байгаа асуудлаар Оролцогч улсуудын эрх бүхий холбогдох байгууллагууд хамтарсан мөрдөн шалгах байгууллага байгуулж болох хоёр болон олон талт хэлэлцээр эсхүл тохиролцоо байгуулахыг эрмэлзэнэ. Тийм хэлэлцээр эсхүл тохиролцоо байхгүй тохиолдолд хамтарсан мөрдөн шалгах ажиллагааг тухай бүр тохиролцон явуулж болно. Холбогдох Оролцогч улсууд нутаг дэвсгэрт нь тийм мөрдөн шалгах ажиллагаа явагдах гэж буй Оролцогч улсын бүрэн эрхт байдлыг бүрэн хүндэтгэнэ.

50 дугаар зүйл. Мөрдөн шалгах тусгай арга хэрэгсэл

1. Эрх бүхий байгууллагууд нь хяналтын дор хүргүүлэх аргыг, түүнчлэн зохистой гэж үзсэн тохиолдолд хянах, гүйцэтгэх ажиллагааны цахим болон бусад хэлбэр гэх мэт мөрдөн шалгах бусад тусгай арга хэрэгслийг нутаг дэвсгэртээ зохистойгоор ашиглахыг зөвшөөрөх, түүнчлэн авлигатай үр дүнтэй тэмцэх үүднээс ийм аргаар олж авсан нотлох баримтыг шүүхэд хүлээн зөвшөөрүүлэх талаар шаардлагатай байж болох арга хэмжээг Оролцогч улс бүр дотоодын эрх зүйн тогтолцооныхоо үндсэн зарчмаар зөвшөөрсөн хэмжээнд, үндэсний хууль тогтоомжийн зохицуулалтад нийцүүлэн бололцооныхоо хэрээр авч хэрэгжүүлнэ.

2. Энэхүү конвенцод хамаарах гэмт хэргийг мөрдөн шалгах зорилгоор мөрдөн шалгах дээрх тусгай арга хэрэгслийг олон улсын түвшний хамтын ажиллагаанд ашиглах талаар Оролцогч улсууд шаардлагатай тохиолдолд хоёр болон олон талт зохих хэлэлцээр эсхүл тохиролцоо байгуулах санаачилгыг дэмжинэ. Тийм хэлэлцээр, тохиролцоог улсуудын бүрэн эрхт тэгш байдлын зарчимд бүрэн нийцүүлэн байгуулж, хэрэгжүүлэх бөгөөд тэдгээр хэлэлцээр болон тохиролцооны нөхцөлийг чанд сахина.

3. Энэхүү зүйлийн 2 дахь хэсэгт заасан хэлэлцээр, тохиролцоо байхгүй тохиолдолд мөрдөн шалгах тийм тусгай арга хэрэгслийг олон улсын түвшинд ашиглах тухай шийдвэрийг хэрэг тус бүрд нь гаргах бөгөөд шийдвэр гаргахдаа шаардлагатай тохиолдолд холбогдох Оролцогч улсуудын харьяалан шийдвэрлэх асуудалд холбогдуулан санхүүгийн тохиролцоо, баталгааг ашиглаж болно.

4. Хяналтын дор хүргүүлэх аргыг олон улсын түвшинд хэрэглэх тухай шийдвэрт бараа буюу мөнгөн хөрөнгийг замд нь саатуулах, хэвээр нь цааш явуулах эсхүл бүхлээр нь эсхүл хэсэгчлэн хураах, солих зэрэг аргыг холбогдох Оролцогч улсуудын зөвшөөрснөөр тусгаж болно.

V БҮЛЭГ

Хөрөнгө буцаах

51 дүгээр зүйл. Ерөнхий зүйл

Энэхүү бүлгийн дагуу хөрөнгө буцаах нь энэхүү конвенцын тулгуур зарчим мөн бөгөөд энэ талаар Оролцогч улсууд бие биетэйгээ боломжит хамгийн өргөн хүрээнд хамтран ажиллаж, тусалцаа үзүүлнэ.

52 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, шилжүүлгийг илрүүлэх

1. Энэхүү конвенцын 14 дүгээр зүйлийг үл хөндөн, Оролцогч улс бүр өөрийн харьяалалдаа багтах санхүүгийн байгууллагуудаасаа харилцагчийнхаа бичиг баримтыг нягталж байх, өндөр дүнтэй дансанд хадгалуулсан мөнгөн хөрөнгийн жинхэнэ эзэмшигч нь хэн болохыг тодорхойлох талаар боломжит арга хэмжээ авах, нийтийн албаны чухал чиг үүрэг гүйцэтгэж байгаа буюу байсан хувь хүн, тэдний гэр бүлийн гишүүд болон ойр холбоотой хамаарал бүхий этгээдийн нээхийг хүссэн болон эзэмшиж буй данс эсхүл тэдний нэрийн өмнөөс нээхийг хүссэн болон эзэмшиж буй дансанд хатуу хяналт явуулахыг шаардахад шаардлагатай байж болох арга хэмжээг үндэсний хууль тогтоомждоо нийцүүлэн авна. Ийм хатуу хяналт нь сэжигтэй гүйлгээг эрх бүхий байгууллагад мэдээлэх зорилгоор илрүүлэхэд үндэслэлтэйгээр чиглэсэн байх бөгөөд үүнийг санхүүгийн байгууллагыг хууль ёсны харилцагчтайгаа бизнесийн үйл ажиллагаа явуулахад саад болох эсхүл хориглох утгаар тайлбарлаж болохгүй.

2. Энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлэх явдлыг хөнгөвчлөн дэмжихийн тулд Оролцогч улс бүр үндэсний хууль тогтоомждоо нийцүүлэн, мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бүс нутгийн, бүс нутаг хоорондын болон олон талт байгууллагуудын санаачилгыг удирдлага болгон:

(а) харьяалалд нь багтах санхүүгийн байгууллагаас дансанд нь хатуу хяналт явуулах ёстой хувь хүн, хуулийн этгээдийн төрөл, онцгой анхаарал хандуулах данс ба гүйлгээний төрөл, түүнчлэн тэдгээр данстай холбогдуулан данс нээх, эзэмших, бүртгэл хөтлөх талаарх зохих арга хэмжээний талаар сэрэмжлүүлэг заавар гаргаж;

(b) харьяалалд нь багтах санхүүгийн байгууллага өөр журмаар таньж тогтоох хувь хүн, хуулийн этгээдээс гадна эдгээр санхүүгийн байгууллагаас хатуу хяналт явуулах ёстой тодорхой хувь хүн, хуулийн этгээдийн талаар эдгээр байгууллагад оролцогч өөр улсын хүсэлтээр эсхүл өөрийн санаачлагчаар зохих тохиолдолд мэдэгдэнэ.

3. Энэхүү зүйлийн 2 дахь хэсгийн (а) дэд хэсгийн хүрээнд, энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүмүүст хамаарах данс, гүйлгээний зохистой бүртгэлийг санхүүгийн байгууллагууд нь зохих хугацаанд хөтөлж байх явдлыг хангах арга хэмжээг Оролцогч улс бүр авч хэрэгжүүлэх бөгөөд энэ бүртгэлд наад зах нь харилцагчийн, мөн боломжтой бол жинхэнэ эзэмшигч нь хэн болох тухай мэдээллийг агуулбал зүйтэй.

4. Энэхүү конвенцод заасан гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг цааш шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, ийм шилжүүлгийг илрүүлэх зорилгоор Оролцогч улс бүр бодитоор оршдоггүй банк болон тусгай зохицуулалттай санхүүгийн бүлэгт харьяалагддаггүй банк байгуулахаас зохицуулагч болон хяналтын байгууллагуудынхаа тусламжтайгаар урьдчилан сэргийлэх үр дүнтэй бөгөөд зохистой арга хэмжээ авна. Түүнчлэн, Оролцогч улсууд ийм байгууллагуудтай хүлээн авагчийн банкны харилцаа тогтоох, тийм харилцаагаа үргэлжлүүлэхээс татгалзахыг, түүнчлэн бодитоор оршдоггүй банк болон тусгай зохицуулалттай санхүүгийн бүлэгт харьяалагддаггүй банк дансыг нь хэрэглэхийг

зөвшөөрч буй гадаадын санхүүгийн байгууллагуудтай харилцаа тогтоохоос хамгаалах арга хэмжээ авахыг санхүүгийн байгууллагуудаасаа шаардаж болно.

5. Оролцогч улс бүр зохих нийтийн албан тушаалтны санхүүгийн байдалтай холбогдсон мэдээллийн ил тод байдлыг хангах үр дүнтэй тогтолцоог үндэсний хууль тогтоомждоо тусган бий болгоход анхаарах бөгөөд ил тод байх шаардлага биелүүлээгүй албан тушаалтанд оногдуулах хариуцлагыг нь тогтоож өгнө. Түүнчлэн энэхүү конвенцод заасан гэмт хэргийг үйлдэж олсон ашиг, орлогыг мөрдөн шалгах, нэхэмжлэх, буцаалгах шаардлагатай тохиолдолд дээрх мэдээллийг оролцогч бусад улсын эрх бүхий байгууллагуудтай солилцохыг зөвшөөрөхөд чиглэсэн шаардлагатай арга хэмжээг Оролцогч улс бүр авч хэрэгжүүлнэ.

6. Гадаад улсад санхүүгийн дансанд хувь эзэмшдэг болон гарын үсэг зурах эрх, өөр бусад эрх эдэлдэг зохих нийтийн албан тушаалтнаас уг харилцаагаа эрх бүхий зохих байгууллагад мэдээлэх ба уг данстай холбоотой зохих бүртгэл хөтөлж байхыг шаардах талаар үндэсний хууль тогтоомжийнх нь дагуу шаардлагатай байж болох арга хэмжээг авахад Оролцогч улс бүр анхаарал хандуулна. Үл биелүүлсэн тохиолдолд оногдуулбал зохих хариуцлагыг эдгээр арга хэмжээнд мөн заана.

53 дугаар зүйл. Хөрөнгийг шууд буцаах арга хэмжээ

Оролцогч улс бүр үндэсний хууль тогтоомждоо нийцүүлэн:

(a) энэхүү конвенцод заасан гэмт хэргийг үйлдэх замаар олж авсан хөрөнгийг өмчлөх эрх буюу өмчлөлийг тогтоох зорилгоор өөрийн шүүхэд иргэний хэрэг үүсгэхийг оролцогч өөр улсад зөвшөөрөхөд шаардлагатай байж болох арга хэмжээг авна;

(b) энэхүү конвенцод заасан гэмт хэргийг үйлдсэн этгээдээр уг гэмт хэргийн улмаас хохирсон оролцогч өөр улсад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх буюу арилгуулах шийдвэр гаргахыг өөрийн шүүхэд зөвшөөрөхөд шаардлагатай байж болох арга хэмжээг авна;

(c) энэхүү конвенцод заасан гэмт хэргийг үйлдэх замаар олж авсан хөрөнгийн хууль ёсны өмчлөгч болохоо тогтоолгох тухай оролцогч бусад улсын шаардлагыг өөрийн улсын шүүх болон эрх бүхий байгууллагаас хөрөнгө хураах шийдвэр гаргах үедээ хүлээн зөвшөөрөх зохицуулалтыг батлан хэрэгжүүлэхэд чиглэсэн шаардлагатай арга хэмжээг авна.

54 дүгээр зүйл. Хөрөнгө хураах асуудлаар олон улсын хэмжээнд хамтран ажиллах замаар хөрөнгийг буцаах механизм

1. Энэхүү конвенцод заасан гэмт хэргийг үйлдэх замаар олж авсан буюу ийм гэмт хэрэгтэй холбоотой бий болсон хөрөнгийн асуудлаар Оролцогч улсууд энэхүү конвенцын 55 дугаар зүйлийн дагуу эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхдээ үндэсний хууль тогтоомждоо нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

(a) хөрөнгө хураах талаар оролцогч бусад улсын шүүхээс гаргасан шийдвэрийг өөрийн улсын эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх;

(b) мөнгө угаах гэмт хэрэг болон бусад гэмт хэргийг хянан шийдвэрлэх, эсхүл үндэсний хууль тогтоомжид заасан бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ гадаад улсын эх үүсвэртэй хөрөнгийг хураан авах шийдвэр гаргахыг уг хэргийг харьяалан шийдвэрлэх эрх бүхий байгууллагад зөвшөөрөх;

(c) гэмт хэрэгтэн нас барсан, оргон зайлсан, түүний эрэн сурвалжлах шаардлагатай болсон шалтгаанаар гэмт хэрэгт ял оноох боломжгүй тохиолдолд эрүүгийн ял шийтгэл оногдуулахгүйгээр хөрөнгө хураах үйл ажиллагаа явуулах.

2. Энэхүү конвенцын 55 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу гаргасан хүсэлтээр эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхийн тулд Оролцогч улс бүр үндэсний хууль тогтоомждоо нийцүүлэн дараах арга хэмжээг авна. Үүнд:

(а) хүсэлт гаргагч Оролцогч улсын шүүх, бусад эрх бүхий байгууллагаас энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн (а)-д заасан журмын дагуу уг хөрөнгийг хураах хангалттай үндэслэлийг заасан хөрөнгө битүүмжлэх болон царцаах шийдвэрийг хүсэлт хүлээн авагч Оролцогч улсад хүргүүлснээр тус шийдвэрийн дагуу хүсэлт хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага хөрөнгө битүүмжлэх, царцаах үйл ажиллагаа явуулах;

(b) Оролцогч улсаас энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн (а)-д заасан журмын дагуу уг хөрөнгийг хураах хангалттай үндэслэлтэй болохыг тодорхойлсон хөрөнгө битүүмжлэх болон царцаах хүсэлтийг Оролцогч бусад улсад хүргүүлснээр тус хүсэлтийг дагуу хүсэлт хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага хөрөнгө битүүмжлэх, царцаах үйл ажиллагааг [хүсэлт гаргагч улсын шүүх, бусад эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр] явуулах;

(c) хураан авсан хөрөнгийг хууль бусаар олж авсан этгээдийг гадаад улсын нутаг дэвсгэр дээр баривчлах, эрүүгийн ял оногдуулах зэргээр хөрөнгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон нэмэлт ажиллагаа явуулахыг эрх бүхий байгууллагадаа зөвшөөрөх.

55 дугаар зүйл. Хөрөнгө хураах зорилго бүхий олон улсын хамтын ажиллагаа

1. Хэргийг харьяалан шийдвэрлэх эрхтэй өөр улсаас нутаг дэвсгэрт нь байгаа энэхүү конвенцын 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого, хөрөнгө, тоног төхөөрөмж буюу бусад хэрэгслийг хураах хүсэлтийг энэхүү конвенцод заасан гэмт хэрэгтэй холбогдуулан хүлээн авсан Оролцогч улс дотоодын эрх зүйн тогтолцооныхоо хүрээнд аль болох өргөн хэмжээнд:

(а) хөрөнгө хураах тухай шийдвэр гаргуулах зорилгоор уг хүсэлтийг өөрийн эрх бүхий байгууллагад өгөх бөгөөд хэрэв ийм шийдвэр гарсан бол түүнийг биелүүлнэ; эсхүл

(b) хүсэлт гаргагч Оролцогч улсын нутаг дэвсгэрт байгаа шүүхээс энэхүү конвенцын 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 54 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (а) дэд хэсгийн дагуу гаргасан хөрөнгө хураах тухай шийдвэрийг хүсэлт хүлээн авагч Оролцогч улсын нутаг дэвсгэрт байгаа 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого, хөрөнгө, тоног төхөөрөмж буюу бусад хэрэгсэлтэй холбоотой хэмжээнд, хүсэлтэд дурдсан хүрээнд хэрэгжүүлэх үүднээс тухайн шийдвэрийг өөрийн эрх бүхий байгууллагад өгнө.

2. Энэхүү конвенцод заасан гэмт хэрэгтэй холбогдуулан харьяалал бүхий өөр Оролцогч улс хүсэлт гаргасны дараа хүсэлт хүлээн авагч Оролцогч улс энэхүү конвенцын 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого, хөрөнгө, тоног төхөөрөмж буюу бусад хэрэгслийг илрүүлэх, мөрдөх, битүүмжлэх, царцаах арга хэмжээг хүсэлт гаргагч Оролцогч улс эсхүл энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хүсэлтийн дагуу хүсэлт хүлээн авагч Оролцогч улсаас гаргах шийдвэрийн дагуу эцэст нь хураах зорилгоор авна.

3. Энэхүү конвенцын 46 дугаар зүйлийн заалтыг энэ зүйлд хэрэглэх бөгөөд чингэхдээ шаардлагатай ялгааг харгалзан үзнэ. Энэ зүйлийн дагуу гаргасан хүсэлтэд 46 дугаар зүйлийн 15 дахь хэсэгт заасан мэдээллээс гадна дараах зүйлийг тусгана. Үүнд:

(а) энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн (а)-д заасан хүсэлтэд хураан авах хөрөнгийн тодорхойлолт, түүний дотор байршлын тухай мэдээлэл болон шаардлагатай тохиолдолд хөрөнгийн тооцоолсон үнэ өртөг ба хүсэлт хүлээн авагч Оролцогч улсаас үндэсний хууль тогтоомжийнхоо дагуу шийдвэр гаргахад хангалттай гэж хүсэлт гаргагч Оролцогч улс үзэж үндэслэсэн баримтын тухай мэдээллийг аль болох багтаасан байна;

(b) энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн (b) дэд хэсэгт хамаарах хүсэлтийн хувьд, тухайн хүсэлтийн үндэслэл болсон бөгөөд хүсэлт гаргагч Оролцогч улсаас гаргасан хөрөнгө хураах тухай шийдвэрийн хуулийн шаардлага хангахуйц хуулбар, шийдвэрийг

гүйцэтгэхийг хүсэлт болгосон хэмжээнд тохирох баримтын тухай мэдэгдэл ба мэдээлэл, хүсэлт гаргагч Оролцогч улсаас хөрөнгийг эрхээ шударгаар хэрэгжүүлэгч гуравдагч талд хангалттай мэдээлэл өгөх болон эрх зүйн зохих ёсны журмыг хангах талаар авсан арга хэмжээг тусгасан мэдэгдэл, түүнчлэн хураах шийдвэр нь эцсийн болох тухай мэдэгдэл;

(с) энэхүү зүйлийн 2 дахь хэсэгт хамаарах хүсэлтийн хувьд, хүсэлт гаргагч Оролцогч улсын үндэслэл болгосон баримтын тухай мэдэгдэл, хүсэлт болгосон арга хэмжээний тодорхойлолт, түүнчлэн хэрэв байгаа бол хүсэлтийн үндэслэл болсон шийдвэрийн хуулийн шаардлага хангахуйц хуулбар.

4. Хүсэлт хүлээн авагч Оролцогч улс энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан шийдвэрийг гаргах эсхүл арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ өөрийн улсын хууль тогтоомж, хянан шийдвэрлэх ажиллагааны журмаас гадна хүсэлт гаргагч Оролцогч улстай холбоотой заавал биелүүлэх хоёр болон олон талт аливаа хэлэлцээр, тохиролцооны заалтад нийцүүлнэ.

5. Оролцогч улс бүр энэ зүйлийг хэрэгжүүлэх өөрийн хууль тогтоомж, журам, тэдгээрт оруулсан цаашдын өөрчлөлтийн хуулбарыг эсхүл тэдгээрийн талаарх танилцуулгыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлнэ.

6. Хэрэв Оролцогч улс энэ зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт заасан арга хэмжээг холбогдох гэрээ байгаа тохиолдолд авч хэрэгжүүлэх нөхцөл тавихаар шийдвэрлэвэл тухайн Оролцогч улс энэхүү конвенцыг гэрээний шаардлагатай бөгөөд хангалттай үндэс гэж үзнэ.

7. Хэрэв хүсэлт хүлээн авагч Оролцогч улс хангалттай нотлох баримтыг цаг тухайд нь хүлээж аваагүй эсхүл хөрөнгийн үнэ өртөг нь ялимгүй бага бол энэ зүйлийн дагуу хамтран ажиллахаас татгалзаж эсхүл түр арга хэмжээг цуцалж болно.

8. Энэхүү зүйлийн дагуу авсан аливаа түр арга хэмжээг цуцлахаас өмнө хүсэлт хүлээн авагч Оролцогч улс нь боломжтой бүх тохиолдолд энэхүү арга хэмжээг үргэлжлүүлэх шаардлагатай гэх үндэслэлийг нотлох боломжийг хүсэлт гаргагч Оролцогч улсад олгоно.

9. Энэхүү зүйлийн зохицуулалтыг гуравдагч талын шударгаар хэрэгжүүлэх эрхийг хөндөх байдлаар тайлбарлаж болохгүй.

56 дугаар зүйл. Тусгай хамтын ажиллагаа

Конвенцод заасан гэмт хэрэг үйлдэж олсон орлогын талаарх мэдээллийг үндэсний хууль тогтоомждоо нийцүүлэн оролцогч бусад улсад өгснөөр мэдээллийг хүлээн авагч Оролцогч улсад мөрдөн шалгах, яллах болон шүүн таслах ажиллагааг эхлүүлэх буюу явуулахад нь тус нэмэр болж болох эсхүл конвенцын энэ бүлгийн дагуу хүсэлт гаргах үндэслэл болно гэж үзэж байгаа тохиолдолд Оролцогч улс бүр ийм мэдээллийг өөрийн мөрдөн шалгах, яллах болон шүүх ажиллагаанд хохирол учруулахгүйгээр оролцогч бусад улсад урьдчилсан хүсэлт авахгүйгээр илгээхийг зөвшөөрөх боломж бүрдүүлэхийг чармайна.

57 дугаар зүйл. Хөрөнгө буцаах ба захиран зарцуулах

1. Энэхүү конвенцын 31 эсхүл 55 дугаар зүйлд заасны дагуу аль нэг Оролцогч улсад хураан авсан хөрөнгийг тухайн улс өмнөх хууль ёсны өмчлөгчид нь энэ зүйлийн 3 дахь хэсгийн дагуу буцаах зэргээр энэхүү конвенц болон үндэсний хууль тогтоомжийнхоо зохицуулалтын дагуу захиран зарцуулна.

2. Оролцогч улс бүр Оролцогч өөр улсын гаргасан хүсэлтийн дагуу энэхүү конвенцод нийцүүлэн арга хэмжээ авах үедээ хураагдсан хөрөнгийг эрхээ шударгаар хэрэгжүүлэгч гуравдагч талын эрхийг харгалзан буцаах боломжийг өөрийн эрх бүхий байгууллагад олгоход шаардагдаж болох хууль тогтоомж батлах болон бусад арга хэмжээг үндэсний хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авна.

3. Хүсэлт хүлээн авагч Оролцогч улс энэхүү конвенцын 46 болон 55 дугаар зүйл болон энэ зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт нийцүүлэн:

(а) энэхүү конвенцын 17 болон 23 дугаар зүйлд заасны дагуу нийтийн мөнгөн хөрөнгийг завших болон нийтээс завшсан мөнгөн хөрөнгийг угаах тохиолдолд, хөрөнгийг 55 дугаар зүйлийн дагуу болон хүсэлт гаргагч Оролцогч улсын шүүхийн эцсийн шийдвэрийг үндэслэн хураасан бол (хүсэлт хүлээн авагч Оролцогч улс уг шаардлагаас татгалзаж болно) хураасан хөрөнгийг хүсэлт гаргагч Оролцогч улсад буцаана;

(b) энэхүү конвенцод хамаарах аливаа өөр гэмт хэрэг үйлдэж олсон орлогын хувьд, хөрөнгийг 55 дугаар зүйлийн дагуу болон хүсэлт гаргагч Оролцогч улсын шүүхийн эцсийн шийдвэрийг үндэслэн хураасан бол (хүсэлт хүлээн авагч Оролцогч улс уг шаардлагаас татгалзаж болно), хүсэлт гаргагч Оролцогч улс хүсэлт ийнхүү хураагдсан хөрөнгийг урьд нь өмчилж байснаа хүлээн авагч Оролцогч улсад үндэслэлтэйгээр нотолсон эсхүл хүсэлт хүлээн авагч Оролцогч улс хүсэлт гаргагч Оролцогч улсад учирсан хохирлыг хураасан хөрөнгийг эргүүлэн өгөх үндэслэл гэж хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хураасан хөрөнгийг хүсэлт гаргагч Оролцогч улсад буцаана;

(c) аливаа бусад тохиолдолд, хураасан хөрөнгийг хүсэлт гаргагч Оролцогч улсад буцаах, хууль ёсны өмчлөгчид нь буцаах болон гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр өгөх асуудалд нэн тэргүүний ач холбогдол өгч ажиллана.

4. Оролцогч улсууд өөрөөр шийдвэрлээгүй бол хүсэлт хүлээн авагч Оролцогч улс нь хураан авсан хөрөнгийг энэ зүйлийн дагуу буцаах зэргээр захиран зарцуулахдаа мөрдөн шалгах, яллах болон шүүх таслах ажиллагаанд гарсан үндэслэл бүхий зардлыг зохих байдлаар хасаж тооцож болно.

5. Хураасан хөрөнгийг эцсийн байдлаар захиран зарцуулахдаа шаардлагатай бол тухай бүр гэрээ байгуулах эсхүл харилцан тохиролцоо хийх асуудалд Оролцогч улсууд тусгайлан анхаарах нь зүйтэй.

58 дугаар зүйл. Санхүүгийн мэдээллийн нэгж

Оролцогч улсууд энэхүү конвенцод заасан гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, тийнхүү шилжүүлэхтэй тэмцэх, түүнчлэн тэдгээр орлогыг буцаах арга зам, хэрэгслийг дэмжих зорилгоор бие биетэйгээ хамтран ажиллах бөгөөд үүний тулд санхүүгийн сэжигтэй гүйлгээний талаарх мэдээлэл хүлээн авах, дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгууллагуудад түгээх асуудал хариуцсан санхүүгийн мэдээллийн нэгж байгуулахыг эрмэлзэнэ.

59 дүгээр зүйл. Хоёр ба олон талт хэлэлцээр ба тохиролцоо

Оролцогч улсууд энэхүү конвенцын энэ бүлгийн дагуу хэрэгжүүлэх олон улсын хамтын ажиллагааны үр дүнг сайжруулахаар хоёр болон олон талт хэлэлцээр, тохиролцоо байгуулах асуудалд анхаарал хандуулна.

VI БҮЛЭГ

Техникийн туслалцаа ба мэдээлэл солилцоо

60 дугаар зүйл. Сургалт, техникийн туслалцаа

1. Оролцогч улс бүр авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх асуудал хариуцсан ажилтнууддаа зориулан сургалтын тодорхой хөтөлбөрийг шаардлагатай хэмжээнд санаачилж, боловсруулж, сайжруулна. Сургалтын тэдгээр хөтөлбөр нь дараах хүрээний асуудлыг бусад асуудлын хамт хөндөж болно. Үүнд:

(a) авлигаас урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх, мөрдөн шалгах, шийтгэх болон хянах үр дүнтэй арга хэмжээ, түүний дотор нотлох баримт цуглуулах ба мөрдөн шалгах арга хэрэгслийг хэрэглэх;

(b) авлигын эсрэг стратегийн бодлого боловсруулах ба төлөвлөх чадавхыг бий болгох;

(c) энэхүү конвенцоор тавьсан шаардлагыг хангахуйц эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтийг боловсруулах чиглэлээр эрх бүхий байгууллагуудад сургалт явуулах;

(d) байгууллага, нийтийн албаны удирдлага болон нийтийн санхүүгийн удирдлага, түүний дотор нийтийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа, түүнчлэн хувийн хэвшлийн үнэлгээ хийх, тэдгээрийг бэхжүүлэх;

(e) энэхүү конвенцод заасан гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, тийнхүү шилжүүлэхтэй тэмцэх, түүнчлэн тэдгээр орлогыг буцаах;

(f) энэхүү конвенцод заасан гэмт хэрэг үйлдэж олсон орлогын шилжүүлэлтийг илрүүлэх, битүүмжлэх;

(g) энэхүү конвенцын дагуу тогтоосон гэмт хэрэг үйлдэж олсон орлогын хөдөлгөөн, тэдгээр орлогыг шилжүүлэх, нуун дарагдуулах буюу өөрчлөн хувиргахад ашигладаг арга хэрэгслийг ажиглан судлах;

(h) энэхүү конвенцод заасан гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг буцаах явдлыг хөнгөвчлөх эрх зүйн болон захиргааны зохистой бөгөөд үр ашигтай механизм ба арга хэрэгсэл;

(i) шүүх эрх бүхий байгууллагатай хамтран ажиллаж буй хохирогч ба гэрчийг хамгаалахад ашигладаг арга хэрэгсэл;

(j) үндэсний ба олон улсын дүрэм журмын болон хэлний сургалт явуулах.

2. Оролцогч улсуудын хооронд шилжүүлэн өгөх ба эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг хөнгөвчлөн дэмжих үүднээс Оролцогч улсууд авлигатай тэмцэх тус тусын төлөвлөгөө болон хөтөлбөртөө хамгийн өргөн хүрээний техникийн туслалцааг бие биедээ, ялангуяа хөгжиж буй орнуудын ашиг тусад, хүчин чадалдаа нийцүүлэн үзүүлэх, түүний дотор энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан чиглэлээр материаллаг дэмжлэг үзүүлэх ба сургалт явуулах, мөн холбогдох туршлага, нарийн мэдлэгийн сургалт явуулах, туслалцаа үзүүлэх, эдгээр туршлага, мэдлэгээ харилцан солилцох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3. Оролцогч улсууд олон улсын болон бүс нутгийн байгууллага, түүнчлэн холбогдох хоёр талт болон олон талт хэлэлцээр, тохиролцооны хүрээнд чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой болон сургалтын үйл ажиллагааг дээд хэмжээнд хүргэх хүчин чармайлтаа шаардлагатай хэмжээнд сайжруулна.

4. Оролцогч улсууд авлигатай тэмцэх стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөг эрх бүхий байгууллага болон нийгмийн оролцоотойгоор боловсруулах үүднээс өөрийн орон дахь авлигын төрөл, шалтгаан, үр нөлөө болон өртгийг хамарсан үнэлгээ, судалгаа болон шинжилгээ хийхэд бие биедээ холбогдох хүсэлтийн дагуу туслалцаа үзүүлнэ.

5. Энэхүү конвенцод заасан гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг буцаах явдлыг хөнгөвчлөн дэмжихийн тулд Оролцогч улсууд энэ зорилгод хүрэхэд тусалж чадах шинжээчдийн нэрсийг солилцох талаар хамтран ажиллаж болно.

6. Оролцогч улсууд хамтын ажиллагаа, техникийн туслалцааг хөхиүлэн дэмжих, түүнчлэн сонирхол татсан нийтлэг асуудлаар, түүний дотор хөгжиж буй орнууд болон шилжилтийн эдийн засагтай орнуудын онцгой асуудал, хэрэгцээний талаар хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор дэд бүсийн, бүс нутгийн болон олон улсын бага хурал, семинар зохион байгуулах, оролцохыг эрмэлзэнэ.

7. Оролцогч улсууд хөгжиж буй орнууд болон шилжилтийн эдийн засагтай орнуудын энэхүү конвенцыг хэрэглэх хүчин чармайлтад нь техникийн туслалцааны хөтөлбөр ба төсөл хэрэгжүүлэх замаар санхүүгийн дэмжлэг үзүүлэх үүднээс сайн дурын механизм бий болгоход анхаарал хандуулна.

8. Оролцогч улс бүр энэхүү конвенцыг хэрэгжүүлэх үүднээс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаар дамжуулан хөгжиж буй орнуудад хэрэгжүүлэх хөтөлбөр ба төслийг дэмжих зорилгоор уг албанд сайн дурын хандив өгөхийг эрмэлзэнэ.

61 дүгээр зүйл. Авлигын талаарх мэдээллийг цуглуулах, солилцох, дүн шинжилгээ хийх

1. Оролцогч улс бүр өөрийн нутаг дэвсгэр дэх авлигын чиг хандлага, түүнчлэн авлигын гэмт хэрэг үйлдэгдэж буй нөхцөл байдалд шинжээчидтэй зөвлөлдөн дүн шинжилгээ хийхийг эрмэлзэнэ.

2. Оролцогч улсууд нэгдсэн тодорхойлолт, стандарт, аргачлалыг боломжийн хэрээр боловсруулах үүднээс статистикийн тоо баримт, авлигын талаарх дүн шинжилгээ, мэдээлэл, мөн авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх шилдэг туршлагын талаарх мэдээллийг боловсруулах, хоорондоо болон олон улсын ба бүс нутгийн байгууллагаар дамжуулан солилцох асуудлыг хэлэлцэнэ.

3. Оролцогч улс бүр авлигатай тэмцэх өөрийн бодлого, бодит арга хэмжээг хянах, мөн тэдгээрийн үр дүн, үр ашгийг үнэлэх арга хэмжээ авна.

62 дугаар зүйл. Бусад арга хэмжээ: эдийн засгийн хөгжил болон техникийн туслалцааны замаар конвенцыг хэрэгжүүлэх

1. Оролцогч улсууд нийгэмд, ялангуяа тогтвортой хөгжилд үзүүлдэг авлигын сөрөг нөлөөг харгалзан үзэж олон улсын хамтын ажиллагааны замаар энэхүү конвенцын оновчтой хэрэгжилтэд түлхэц өгөх арга хэмжээг боломжийнхоо хэрээр авна.

2. Оролцогч улсууд хоорондоо, мөн олон улсын болон бүс нутгийн байгууллагатай уялдан зохицсоны үндсэн дээр дараах чиглэлээр тодорхой хүчин чармайлтыг боломжийн хэмжээнд гаргана. Үүнд:

(a) хөгжиж буй орнуудын авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх чадавхыг бэхжүүлэх үүднээс тэдгээртэй хэрэгжүүлэх хамтын ажиллагааг янз бүрийн түвшинд сайжруулах;

(b) хөгжиж буй орнуудын авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх хүчин чармайлтыг үр дүнтэйгээр дэмжих болон тэдэнд энэхүү конвенцыг амжилттай хэрэгжүүлэхэд нь туслахаар санхүүгийн ба материаллаг тусламжийг нэмэгдүүлэх;

(c) хөгжиж буй орнууд болон шилжилтийн эдийн засагтай орнуудад энэхүү конвенцыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хэрэгцээг хангахад нь техникийн туслалцаа үзүүлэх. Үүний тулд Оролцогч улсууд Нэгдсэн Үндэстний Байгууллагын санхүүжилтийн механизм дахь уг зорилгыг биелүүлэхэд зориулсан дансанд сайн дурын үндсэн дээр хангалттай бөгөөд тогтмол хандив оруулж байхыг чармайна. Мөн Оролцогч улсууд энэхүү конвенцод

зохицуулсны дагуу хураасан мөнгө эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого болон түүнтэй дүйцэх хэмжээний мөнгөн дүнгийн тодорхой хувийг тухайн дансанд шилжүүлж байх асуудлыг үндэсний хууль тогтоомжоороо болон энэхүү конвенцын зохицуулалтад нийцүүлэн тусгайлан зохицуулж болно;

(d) Оролцогч бусад улс болон санхүүгийн зохих байгууллагуудыг энэ зүйлийн дагуу тэдний хүчин чармайлттай нэгдэх, тухайлбал хөгжиж буй орнуудад энэхүү конвенцын зорилтод хүрэхэд нь туслахын тулд тэдэнд сургалтын илүү олон хөтөлбөр хэрэгжүүлж, орчин үеийн тоног төхөөрөмж илүү олгох замаар нэгдэхийг хөхиүлэн дэмжиж, итгүүлэх.

3. Эдгээр арга хэмжээ нь гадаадын тусламжийн талаарх одоо үйлчилж буй үүрэг амлалт эсхүл хоёр талын, бүс нутгийн болон олон улсын хэмжээнд хийсэн санхүүгийн хамтын ажиллагааны бусад тохиролцоог аль болох хөндөхгүй.

4. Оролцогч улсууд энэхүү конвенцод заасан олон улсын хамтын ажиллагааны арга замыг үр дүнтэй байлгахад болон авлигаас урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх ба хянахад шаардлагатай санхүүгийн тохиролцоог харгалзан үзэж эд материалын болон логиستيкийн туслалцаа үзүүлэх талаар хоёр талт болон олон талт хэлэлцээр, тохиролцоо байгуулж болно.

VII БҮЛЭГ

Хэрэгжүүлэх механизм

63 дугаар зүйл. Конвенцод Оролцогч улсуудын бага хурал

1. Энэхүү конвенцод тусгасан зорилтуудыг биелүүлэхэд чиглэгдсэн Оролцогч улсуудын чадавх, хамтын ажиллагааг сайжруулах, түүнчлэн конвенцын хэрэгжилтийг хөхиүлэн дэмжиж, хянан үзэж байх зорилгоор конвенцод Оролцогч улсуудын бага хурлыг үүгээр байгуулсан болно.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Оролцогч улсуудын бага хурлыг энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор хуралдуулна. Түүнээс хойш Оролцогч улсуудын бага хурлын ээлжит чуулганыг бага хурлаар баталсан дэгийн горимд нийцүүлэн явуулж байна.

3. Оролцогч улсуудын бага хурал нь дэгийн горим болон энэ зүйлд тусгасан үйл ажиллагааны хэрэгжилтийг зохицуулах дүрэм, түүний дотор ажиглагчдыг оруулах ба оролцуулах дүрэм, тэдгээр үйл ажиллагааг явуулах зардлыг төлөх журмыг батална.

4. Оролцогч улсуудын бага хурал нь энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт тусгасан зорилтод хүрэх зорилгоор тухайлбал дараах үйл ажиллагаа, журам болон ажлын арга барилын талаар тохиролцоно. Үүнд:

(a) Оролцогч улсуудын энэхүү конвенцын 60, 62 дугаар зүйл болон II-V бүлгийн дагуу явуулах үйл ажиллагааг хөнгөвчлөн дэмжих, түүний дотор сайн дурын хандив өгөх явдлыг урамшуулан дэмжих;

(b) энэхүү зүйлд заасан холбогдох мэдээллийг хэвлэх зэрэг замаар авлигын хэлбэр, чиг хандлага болон авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг буцаах амжилттай туршлагын талаарх мэдээллийг Оролцогч улсуудын хооронд солилцохыг хөнгөвчлөн дэмжих;

(c) олон улсын болон бүс нутгийн холбогдох байгууллага, механизм, түүнчлэн төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

(d) ажлыг шаардлагагүйгээр давхардуулахаас зайлсхийхийн тулд авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх олон улсын болон бүс нутгийн бусад механизмаас гаргасан холбогдох мэдээллийг зохистойгоор ашиглах;

(e) энэхүү конвенцыг Оролцогч улсууд хэрхэн хэрэгжүүлж байгааг тогтмол хянан үзэх;

(f) энэхүү конвенц болон түүний хэрэгжилтийг сайжруулах талаар зөвлөмж гаргах;

(g) энэхүү конвенцын хэрэгжилттэй холбоотой Оролцогч улсуудын техникийн туслалцааны хэрэгцээ шаардлагыг харгалзаж, энэ талаар шаардлагатай гэж үзсэн аливаа арга хэмжээг зөвлөмж болгох.

5. Энэхүү зүйлийн 4 дэх хэсэгт заасны хүрээнд Оролцогч улсуудын бага хурал Оролцогч улсуудын зүгээс энэхүү конвенцыг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, тулгарсан бэрхшээлийн талаарх шаардлагатай мэдээллийг Оролцогч улсуудаас ирүүлсэн мэдээлэл болон Оролцогч улсуудын бага хурлаас тогтоож болох хяналтын нэмэлт механизмаар дамжуулан олж авна.

6. Оролцогч улс бүр Оролцогч улсуудын бага хурлаас шаардсаны дагуу энэхүү конвенцыг хэрэгжүүлэх зорилгоор тодорхой хөтөлбөр, төлөвлөгөө, туршлага бий болгосон, мөн хууль баталсан болон захиргааны арга хэмжээ авсан тухай мэдээллээ тус бага хуралд ирүүлж байна. Оролцогч улсуудын бага хурал мэдээллийг хүлээн авч, холбогдох арга хэмжээ авах хамгийн үр дүнтэй арга замыг судалж үзэх бөгөөд уг мэдээлэлд Оролцогч улсууд болон эрх бүхий олон улсын байгууллагуудаас авсан мэдээлэл зэргийг багтаана. Оролцогч улсуудын бага хурлаас баталсан журмын дагуу зохих ёсоор итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагаас авсан мэдээллийг мөн хүлээн авч болно.

7. Оролцогч улсуудын бага хурал шаардлагатай гэж үзвэл энэ зүйлийн 4, 6 дахь хэсгийн дагуу конвенцыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд туслах аливаа зохистой механизм эсхүл байгууллагыг байгуулна.

64 дүгээр зүйл. Нарийн бичгийн дарга нарын газар

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Оролцогч улсуудын бага хуралд Нарийн бичгийн дарга нарын газрын шаардлагатай үйлчилгээг үзүүлнэ.

2. Нарийн бичгийн дарга нарын газар нь:

(a) Оролцогч улсуудын бага хуралд энэхүү конвенцын 63 дугаар зүйлд тусгасан үйл ажиллагааг явуулахад нь туслалцаа үзүүлж, Оролцогч улсуудын бага хурлын чуулганд зориулж зохион байгуулалтын болон шаардлагатай үйлчилгээг үзүүлнэ;

(b) энэхүү конвенцын 63 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасанчлан Оролцогч улсуудын бага хуралд мэдээлэл өгөхөд нь Оролцогч улсуудад хүсэлтийнх нь дагуу туслалцаа үзүүлнэ;

(c) олон улсын болон бүс нутгийн холбогдох байгууллагын нарийн бичгийн дарга нарын газартай шаардлагатай уялдаа холбоог хангаж ажиллана.

VIII БҮЛЭГ

Төгсгөлийн заалтууд

65 дугаар зүйл. Конвенцыг хэрэгжүүлэх

1. Оролцогч улс бүр энэхүү конвенцын дагуу хүлээсэн үүргийнхээ хэрэгжилтийг хангахын тулд шаардлагатай арга хэмжээг, түүний дотор хууль тогтоомж батлах болон захиргааны арга хэмжээг үндэсний хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авна.

2. Оролцогч улс бүр авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд энэхүү конвенцод тусгасан арга хэмжээнээс илүү хатуу буюу илүү чанга арга хэмжээ авч болно.

66 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх

1. Оролцогч улсууд энэхүү конвенцыг тайлбарлах болон хэрэглэхтэй холбогдох маргааныг яриа хэлэлцээ хийх замаар зохицуулахыг чармайна.

2. Энэхүү конвенцыг тайлбарлах болон хэрэглэх талаар хоёр болон түүнээс дээш Оролцогч улсын хооронд гарсан бөгөөд хэлэлцээний замаар боломжит хугацааны дотор зохицуулж чадаагүй аливаа маргааныг тэдгээр Оролцогч улсын аль нэгийг хүсэлтээр арбитрт шилжүүлнэ. Хэрэв арбитрт хүсэлт гаргасан өдрөөс хойш зургаан сарын дотор талууд арбитрыг зохион байгуулах талаар тохиролцож чадаагүй бол тэдгээр Оролцогч улсын аль нэгийг хүсэлтээр маргааныг Олон улсын шүүхэд уг шүүхийн дүрмийн дагуу шилжүүлж болно.

3. Оролцогч улс бүр энэхүү конвенцод гарын үсэг зурах, түүнийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох үедээ энэхүү зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг заавал биелүүлэх үүрэг хүлээхгүй гэж үзэж байгаа талаар мэдэгдэж болно. Ийм тайлбар хийсэн Оролцогч улсын хувьд бусад Оролцогч улс нь энэхүү зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг заавал биелүүлэх үүрэг хүлээхгүй.

4. Энэхүү зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу тайлбар хийсэн аливаа Оролцогч улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх замаар тайлбараасаа хэдийд ч татгалзаж болно.

67 дугаар зүйл. Гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох

1. Энэхүү конвенц 2003 оны 12 дугаар сарын 9-ний өдрөөс 11-ний өдөр Мексик Улсын Мерида хотод, түүнээс хойш 2005 оны 12 дугаар сарын 9-ний өдөр хүртэл Нью-Йорк хот дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Төв байранд бүх улс гарын үсэг зурахад нээлттэй байна.

2. Мөн энэхүү конвенц бүс нутгийн эдийн засгийн интеграцийн байгууллагын хувьд тухайн байгууллагын наад зах нь нэг гишүүн улс энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн дагуу энэхүү конвенцод гарын үсэг зурсан тохиолдолд гарын үсэг зурахад нээлттэй байна.

3. Энэхүү конвенцыг улс орнууд соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх эсхүл батлах бөгөөд соёрхон баталсан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн эсхүл баталсан тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна. Аливаа бүс нутгийн эдийн засгийн интеграцийн байгууллагын хувьд тухайн байгууллагын наад зах нь нэг гишүүн улс соёрхон баталсан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн эсхүл баталсан тухай баримт бичгээ хадгалуулсан бол мөн ийм баримт бичгээ хадгалуулж болно. Тухайн байгууллага соёрхон баталсан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн эсхүл баталсан тухай баримт бичигтээ энэхүү конвенцоор

зохицуулж буй асуудлын хувьд хэрэгжүүлэх эрх хэмжээгээ мэдэгдэнэ. Ийм байгууллага мөн өөрийн эрх хэмжээнд оруулсан аливаа холбогдох өөрчлөлтийн талаар хадгалагчид мэдэгдэнэ.

4. Энэхүү конвенц нь аливаа улсын хувьд эсхүл наад зах нь нэг гишүүн улс нь энэхүү конвенцод оролцогч тал болж орсон бүсийн эдийн засгийн интеграцийн байгууллагын хувьд нэгдэн ороход нээлттэй байна. Нэгдэн орсон тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна. Нэгдэн орох үедээ бүсийн эдийн засгийн интеграцийн байгууллага энэхүү конвенцоор зохицуулж буй асуудлын хувьд хэрэгжүүлэх эрх хэмжээгээ мэдэгдэнэ. Ийм байгууллага мөн өөрийн эрх хэмжээнд оруулсан аливаа холбогдох өөрчлөлтийн талаар хадгалагчид мэдэгдэнэ.

68 дугаар зүйл. Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү конвенц нь гуч дахь соёрхон баталсан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, баталсан эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулсан өдрөөс хойш ер дэх өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Энэ хэсэгт заасныг хэрэгжүүлэх зорилгоор бүсийн эдийн засгийн интеграцийн байгууллагын хадгалуулсан аливаа баримт бичгийг тухайн байгууллагын гишүүн улсуудын хадгалуулсан баримт бичгийн нэмэлт гэж тооцохгүй.

2. Энэхүү конвенцын гуч дахь соёрхон баталсан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, баталсан эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулсны дараа энэхүү конвенцыг соёрхон баталж, хүлээн зөвшөөрч, баталж, түүнд нэгдэн орж буй улс болон бүсийн эдийн засгийн интеграцийн байгууллага тус бүрийн хувьд энэхүү конвенц тухайн улс болон бүсийн эдийн засгийн интеграцийн байгууллага соёрхон баталсан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, баталсан эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ тийнхүү хадгалуулсан өдрөөс хойш гуч дахь өдөр ба энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн дагуу энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдрийн аль сүүлд болох өдрөөс хүчин төгөлдөр болно.

69 дүгээр зүйл. Нэмэлт, өөрчлөлт оруулах

1. Энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш таван жилийн дараа аль нэг Оролцогч улс аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлж болох бөгөөд Ерөнхий нарийн бичгийн дарга уг саналыг судлан шийдвэр гаргуулахаар Оролцогч улсууд болон Оролцогч улсуудын бага хуралд дамжуулна. Оролцогч улсуудын бага хурал нэмэлт, өөрчлөлт тус бүрийн хувьд зөвшилцөлд хүрэх бүхий л чармайлт гаргана. Хэрэв зөвшилцөлд хүрэх бүх чармайлт барагдаж ямарваа тохиролцоонд хүрээгүй бол уг нэмэлт, өөрчлөлтийг эцэст нь Оролцогч улсуудын бага хурлын чуулганд оролцож, санал өгч буй Оролцогч улсуудын гуравны хоёрын саналаар батална.

2. Бүсийн эдийн засгийн интеграцийн байгууллага эрх хэмжээнийхээ хүрээний асуудлаар энэхүү конвенцод Оролцогч улс болох гишүүн улсынхаа тоотой тэнцэх саналын тоогоор энэ зүйлийн дагуу санал өгөх эрхээ эдэлнэ. Ийм байгууллагууд гишүүн улсууд нь санал өгөх эрхээ эдэлж байгаа бол санал өгөх эрхгүй бөгөөд ийм журам мөн эсрэгээр үйлчилнэ.

3. Энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн дагуу баталсан нэмэлт, өөрчлөлтийг Оролцогч улсууд соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх эсхүл батлах байдлаар дагаж мөрдөж болно.

4. Энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн дагуу баталсан нэмэлт, өөрчлөлт нь аливаа Оролцогч улсын хувьд уг нэмэлт, өөрчлөлтийг соёрхон баталсан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн эсхүл баталсан тухай баримт бичгээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын

Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулсан өдрөөс хойш ер хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

5. Аливаа нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болоход түүнийг заавал биелүүлэх зөвшөөрлөө илэрхийлсэн Оролцогч улсууд түүнийг заавал биелүүлнэ. Бусад Оролцогч улс энэхүү конвенцын заалт болон өмнө нь соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн эсхүл баталсан нэмэлт, өөрчлөлтийг заавал биелүүлэх үүрэгтэй хэвээр байна.

70 дугаар зүйл. Конвенцоос татгалзан гарах

1. Аливаа Оролцогч улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэх замаар энэхүү конвенцыг хэрэгжүүлэхээс татгалзан гарч болно. Татгалзан гарах тухай мэдэгдлийг Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дараа татгалзан гарсан үйлдэл хүчин төгөлдөр болно.

2. Бүсийн эдийн засгийн интеграцийн байгууллагын бүх гишүүн улс нь энэхүү конвенцоос татгалзан гарсан тохиолдолд уг байгууллага энэхүү конвенцын оролцогч тал байхаа болино.

71 дүгээр зүйл. Хадгалагч ба хэл

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү конвенцын томилогдсон хадгалагч байна.

2. Англи, араб, испани, орос, франц, хятад хэлээр үйлдсэн адил хүчинтэй эх бичвэр бүхий энэхүү конвенцын жинхэнэ эхийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

ХЭМЭЭСНИЙГ НОТЛОН тус тусын улсыг төлөөлөн тухайн улсын засгийн газраас зохих ёсоор олгосон төлөөлөх эрхийн дагуу төлөөлөгч доорх этгээдүүд энэхүү конвенцод гарын үсэг зурж батлав.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Улаанбаатар хот

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь авлигатай тэмцэх үйл ажиллагаа, авлигатай тэмцэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хууль тогтоомж

2.1.Авлигын эсрэг хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд авлигын эсрэг хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2¹ дүгээр зүйл. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр

2¹.1.Улсын Их Хурал Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах бөгөөд түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт заасан хугацаагаар батална.

/Энэ зүйлийг 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн/

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."авлига" гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг;

3.1.2."ашиг хонжоо" гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосны төлөө өөрт нь болон бусдад буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;

3.1.3."албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах" гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг;

3.1.4."давуу байдал" гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;

3.1.5."олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа" гэж олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд тэднийг татан оролцуулах арга хэмжээний цогцолборыг;

3.1.6."авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа" гэж авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, тэдгээрийг арилгах, авлигыг таслан зогсооход чиглэгдсэн арга хэмжээний цогцолборыг;

3.1.7."хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажил" гэж Авлигатай тэмцэх байгууллагад хуулиар харьяалуулсан гэмт хэрэгт явуулж байгаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг;

/Энэ заалтад 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

3.1.8."гүйцэтгэх ажил" гэж Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан ажиллагааг;

3.1.9."сонгуульд нэр дэвшигч" гэж Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигчийг.

4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд

4.1.Доор дурдсан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна:

4.1.1.төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;

4.1.2.төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;

4.1.3.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;

4.1.4.олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;

4.1.5.улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;

4.1.6.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;

4.1.7.бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;

4.1.8.эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан;

4.1.9.Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн.

/Энэ заалтыг 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар нэмсэн/

/Энэ зүйлийг 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ОЛОН НИЙТИЙГ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ, АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

5 дугаар зүйл.Олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа

5.1.Энэ хуулийн 3.1.5-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

5.1.1.Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо, нөхцөлөөр хангах;

5.1.2.төрийн байгууллага авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах;

5.1.3.авлигын асуудлаар эрдэм шинжилгээний судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажилд сургалт, эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагуудыг оролцуулах;

~~5.1.4.сургалтын байгууллагууд эрх зүйн болон ёс зүйн хичээлийн хүрээнд суралцагчдад авлигын нийгмийн хор аюул, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлж, түүнийг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх; /Энэ заалтыг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./~~

5.1.5.албан бус боловсролын байгууллага болон сургуулиас гадуурх сургалт эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн өөрийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу авлигын нийгмийн хор аюулыг суралцагчдад тайлбарлан таниулах, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлэх;

5.1.6.хэвлэл мэдээллийн байгууллага авлигын аливаа хэлбэрийг үл тэвчих нийгмийн сэтгэл зүйн орчинг төлөвшүүлэхэд нийтлэл, нэвтрүүлгийнхээ бодлогыг чиглүүлэх, энэ талаар байнга мэдээлэл, сурталчилгаа явуулах.

6 дугаар зүйл.Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

6.1.Төрийн байгууллага энэ хуулийн 3.1.6-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

6.1.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 25-29 дүгээр зүйлд заасан нийтлэг үүрэг;

/Энэ хэсгийг 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

6.1.2.тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй болгох, сонирхогч нийгмийн бүлгүүдэд өөрийн бодлого, байр суурийг танилцуулах, хяналтын тодорхой аргыг дэвшүүлэн хэрэгжүүлэх бололцоо олгох зорилгоор харилцан зөвлөлдөж ажиллах боломжийг бүрдүүлэх;

6.1.3.төрийн хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах;

6.1.4.төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх;

6.1.5.тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол олон нийтэд ил тод байлгаж, түүнтэй танилцах боломжоор хангах;

6.1.6.төрийн албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, эрхэлж байгаа ажлын онцлогтой нь холбогдуулж түүнд хориглох зүйлийг Төрийн албаны тухай хууль болон энэ хуульд заасны дагуу тогтоон мөрдүүлэх;

6.1.7.төрийн байгууллага нээлттэй, иргэдийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд тавих хяналтад төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллах, мэдээллийг харилцан солилцох, олон нийтэд мэдээллийг тогтмол хүргэж байх;

6.1.8.авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө өгөх асуудлыг бүтцийн нэгждээ хариуцуулах;

6.1.9.төрийн байгууллага тухайн салбарын албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлан гаргахын өмнө Авлигатай тэмцэх газраас санал авах;

6.1.10.төрийн байгууллагаас гаргасан шийдвэр иргэд болон бусад сонирхогч талуудад ойлгомжтой, нээлттэй байх;

6.1.11.иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх энэ чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх;

/Энэ заалтад 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

6.1.12.бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаварыг нь арилгах арга хэмжээ авах;

6.1.13.авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих; /Энэ заалтад 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

6.1.14.энэ хуулийн 2'дүгээр зүйлд заасан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг төрийн байгууллага, албан тушаалтан биелүүлэх, биелэлтийг холбогдох байгууллагад тайлагнах. /Энэ заалтыг 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн/

6.2.Төрийн бүх шатны байгууллагын албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэж байх явцдаа олж мэдсэн авлигатай холбоотой асуудлыг шалгаж шийдвэрлэх нь өөрийнх нь бүрэн эрхэд хамаарахгүй байвал Авлигатай тэмцэх газарт мэдээлнэ.

6.3.Шүүх, прокурор, цагдаа, Авлигатай тэмцэх газар, хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны төв байгууллага болон Засгийн газрын агентлаг байрлаж байгаа байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглоно.

6.4.Энэ хуулийн 6.3-д заасан байгууллагын байранд улс төрийн болон шашны үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

6.5.Авлигаас урьдчилан сэргийлэх талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30, 31 дүгээр зүйлд заасан эрх, нийтлэг үүргээс гадна дараах үүрэг хүлээнэ:

6.5.1.төрийн бус байгууллага гишүүнийхээ ёс зүйн дүрмийг баталж, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа ил тод мэдээлж байх;

6.5.2.хувийн хэвшлийн байгууллага үйл ажиллагааныхаа ёс зүйн зарчмуудыг тогтоож, дагаж мөрдөх. /Энэ хэсгийг 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

6.6.Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан хууль ёсны шаардлага, шийдвэрийг хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан түүний дагуу холбогдох арга хэмжээг заавал авч, хариуг хугацаанд нь өгөх үүрэгтэй. /Энэ хэсэгт 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

6.7.Төрийн байгууллага, албан тушаалтан авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзсэн тушаал, шийдвэр, журам, дүрмийг Авлигатай тэмцэх газраас өгсөн саналын дагуу дахин хянаж хүчингүй болгох буюу өөрчилнө.

6.8.Авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд эрх бүхий албан тушаалтан сахилгын шийтгэл хүлээлгэнэ.

6.9.Энэ хуулийн 6.6-д заасныг зөрчсөн албан тушаалтныг шүүгч нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

/Энэ хэсэгт 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

7 дугаар зүйл. Хориглох зүйл

7.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бусад хууль тогтоомжид тусгайлан хориглосноос гадна авлигын дараах зөрчлийг хориглоно:

7.1.1.албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх;

7.1.2.бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах;

7.1.3.албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах;

7.1.4.төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;

7.1.5.албан үүргээ гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхтай холбогдуулан бусдаас шан харамж шаардах;

7.1.6.албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх;

7.1.7.албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх;

7.1.8.үндэслэлгүйгээр хөрөнгөжих.

Тайлбар:Албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэж үзнэ. /Энэ зүйлийг 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

8 дугаар зүйл. Авлигын тухай мэдэгдэх

8.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргийг хэрэгжүүлэхэд Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар тогтоосон хязгаарлалт хамаарахгүй.

/Энэ хэсэгт 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

/Энэ зүйлийг 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

9 дүгээр зүйл. Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх

9.1.Иргэн, хуулийн этгээд авлигын асуудлаар Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгч болно.

9.2.Авлигатай тэмцэх газар нь өргөдөл, гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ГАРГАХ

10 дугаар зүйл. Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах

10.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд /цаашид "мэдүүлэг гаргагч" гэх/ хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах бөгөөд шаардлагатай тохиолдолд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо Авлигатай тэмцэх газрын саналыг үндэслэн хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалын жагсаалтыг батална.

10.2.Мэдүүлэг гаргагч нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй. /Энэ хэсгийг 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

10.3.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн алба хааж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй.

10.4.Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд мэдүүлгээ мэдүүлсний дараа хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол түүнийг тухай бүр 30 хоногийн дотор мэдүүлнэ. /Энэ хэсгийг 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

10.5.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг энэ хуулийн 10.3, 10.4-т заасан хугацаанаас хожимдуулж гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаангүй бол гаргаж өгөөгүйд тооцно.

10.6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигч Авлигатай тэмцэх газарт, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн сонгуулийн хороонд сонгуулийн хуульд заасан хугацаанд тус тус хөрөнгө, орлогын мэдүүлгээ гаргана.

/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

/Энэ хэсэгт 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

10.7.Хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журмыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо батална. /Энэ зүйлийг 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

11 дүгээр зүйл. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах

11.1.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг дараах байгууллага, албан тушаалтан хуульд заасан хугацаанд бүртгэж, хадгална:

11.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, түүнчлэн Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас томилогддог албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар;

11.1.2.Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо;

11.1.3.Үндсэн хуулийн цэцийн гишүүн болон бүх шатны шүүхийн шүүгчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Шүүхийн ерөнхий зөвлөл;

11.1.4.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба;

/Энэ заалтад 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

11.1.5.бусад албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтан.

11.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар бүртгэж, хадгална. /Энэ хэсгийг 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

11.3.Энэ хуулийн 11.1.4, 11.1.5-д заасан хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд хөрөнгө, орлогын мэдүүлгийг авч дууссанаас хойш 14 хоногийн дотор хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах журмын биелэлтийн талаарх тайланг, хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргасан этгээдийн нэрсийн хамт Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.

11.4.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн нэгдсэн дүн гарсны дараа тухайн сонгуульд сонгогдогчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг санал хураалт дууссанаас хойш 14 хоногийн дотор Авлигатай тэмцэх газарт ирүүлж, хадгалуулна.

/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

/Энэ хэсэгт 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

11.5.Авлигатай тэмцэх газар хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах хууль тогтоомжийн биелэлтийн талаарх мэдээллийг жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны дотор Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд гаргаж өгнө. /Энэ зүйлийг 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

12 дугаар зүйл. Захидал харилцааны нууцлал

12.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдээс хөрөнгө, орлогын мэдүүлгийг хэрхэн бөглөх талаар Авлигатай тэмцэх газарт хандаж гаргасан захидал, хүсэлт, асуулт, тэдгээрт өгсөн хариулт, зөвлөгөө нь хүний хувийн мэдээлэлд хамаарах бөгөөд түүнтэй холбогдох асуудлыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар зохицуулна. /Энэ хэсэгт 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

12.2.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх үүрэг хүлээсэн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон тухайн албан тушаалаас чөлөөлөгдсөнөөс хойшхи хугацаанд мэдүүлэг гаргагчийн зөвшөөрөл болон хуульд зааснаас бусад тохиолдолд мэдүүлэг гаргагчийн болон энэ хуулийн 12.1-д заасан мэдээллийг задруулах, ямар нэгэн зорилгоор ашиглахыг хориглоно.

12.3.Энэ хуулийн 12.2-т заасныг зөрчсөн албан тушаалтанд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. /Энэ хэсэгт 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

12.4.Мэдүүлэг гаргагч тэтгэвэр тогтоолгох буюу албан тушаалаас огцрох, халагдах, чөлөөлөгдөх зэргээр бүрэн эрх нь дуусгавар болсон тохиолдолд хөрөнгө, орлогынх нь мэдүүлгийг 5 жилийн хугацаанд хадгалах бөгөөд уг хугацаа дуусмагц түүнийг өөрт нь, хэрэв нас барсан бол эхнэр буюу нөхөр, эсхүл хууль ёсны өв залгамжлагчид нь шилжүүлж өгнө.

13 дугаар зүйл. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үндэслэл

13.1.Авлигатай тэмцэх газар энэ хуулийн 11.1.2-т зааснаас бусад албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийнэ.

13.2.Улсын Их Хурлын гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн Авлигатай тэмцэх газар, энэ хуулийн 11.1.2-т заасан хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын

Хууль зүйн байнгын хороо тус тус өргөдөл, гомдолд үндэслэн шалгах бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зөрчил илэрвэл зохих байгууллагад шилжүүлнэ. /Энэ хэсэгт 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

13.3.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий албан тушаалтан мэдүүлэг засваргүй, бүрэн гүйцэд бөглөгдсөн, хугацаандаа өгсөн эсэхэд хяналт тавьж, мэдүүлгийг зохих журмын дагуу гаргаж өгөхийг шаардах, хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл байвал бүрэн эрхийнхээ хүрээнд хянан шалгах буюу Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах үүрэгтэй.

13.4.Монгол Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч байгаа бол тухайн гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар шалгана. /Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

13.5.Авлигатай тэмцэх газар өргөдөл, гомдол, мэдээллийн мөрөөр, эсхүл төлөвлөгөөт хяналтаар шалгалт явуулж болно.

13.6.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл эх үүсвэрийг нь заагаагүй буюу түүнийг хэрхэн олсон талаар тайлбар гаргаагүй бол Авлигатай тэмцэх газар тухайн мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгана.

13.7.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын эх үүсвэрээ бодитой, үнэн зөв тайлбарлах үүрэгтэй.

13.8.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан, эсхүл бүртгүүлээгүй буюу худал мэдүүлсэн бол дараах хариуцлага хүлээлгэнэ:

13.8.1.нэг сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн, хөрөнгө, орлогын мэдүүлгийг энэ хуулийн 10.4, 10.5-д заасан хугацаанаас хожимдуулсан нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол сануулах; /Энэ заалтад 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

13.8.2.зургаа хүртэл сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн, хөрөнгө, орлогын мэдүүлгээ удаа дараа хугацаа хожимдуулж гаргасан бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах; /Энэ заалтад 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

13.8.3.зургаан сараас дээш нэг жил хүртэлх хугацааны цалинтай тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн бол албан тушаал бууруулах, эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах; /Энэ заалтад 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

13.8.4.нэг жилийн цалинтай тэнцэх буюу түүнээс их хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй, худал мэдүүлсэн, эсхүл хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргаж өгөөгүй, гаргахаас татгалзсан бол албан тушаалаас нь огцруулах буюу ажлаас халах.

13.9.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих үүргээ биелүүлээгүй, эсхүл холбогдох материалыг энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд ирүүлээгүй албан тушаалтныг эрх бүхий байгууллага, албан тушаалтан албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, уг зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаал бууруулах сахилгын шийтгэл ногдуулна.

/Энэ зүйлийг 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

14 дүгээр зүйл. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг нийтэд мэдээлэх

14.1. Дараахь албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг тухайн оны 2 дугаар улиралд багтаан цахим мэдээллийн сүлжээнд байрлуулна: /Энэ хэсэгт 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/
15.1.Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэсний төлөө аливаа төлбөр авахыг хориглоно.

15.2.Хууль тогтоомжоор болон Засгийн газар, орон нутгийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлбөр авахаар тогтоосон бол нэмэлт төлбөр авахыг хориглоно.

16 дугаар зүйл.Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт

16.1.Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бусдаас бэлэг шууд буюу шууд бусаар авахыг хориглоно.

16.2.Энэ хуулийн 16.1-д заасан хориглолтод албан тушаалтанд албан үүрэгтэй нь холбогдолгүй өгсөн бэлэг болон албан үүрэгтэй нь холбогдуулан дипломат журмаар өгсөн бэлэг хамаарахгүй.

16.3.Албан тушаалтан дипломат журмаар бэлэг авах, тайлагнах, зарцуулах журмыг Засгийн газар батална.

16.4.Гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүнээс бусад этгээдээс авсан нэг удаагийн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны нэг сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн, эсхүл нэг эх сурвалжаас нэг жилийн туршид хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны гурван сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд уг албан тушаалтан энэ тухай эрх бүхий албан тушаалтанд 30 хоногийн дотор бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх үүрэгтэй./Энэ хэсэгт 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

16.5.Албан тушаалтны авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны зургаан сарын цалингийн хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд түүнийг төрийн өмчид шилжүүлнэ.

16.6.Албан тушаалтан зургаан сарын цалингийн хэмжээнээс илүү гарсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлсний зөрүүг өөрөө төлж тухайн бэлэг, үйлчилгээг хүлээн авч болно.

16.7.Албан тушаалтан бэлэг авахаас өмнөх хоёр жилийн хугацаанд бэлэг өгөгч этгээдтэй холбогдох захиргааны шийдвэр, удирдлага, хяналт, шалгалт, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг албан үүрэг хэрэгжүүлсэн бол түүнийг тухайн бэлэг өгөгч этгээдээс албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бэлэг авсанд тооцно. /Энэ хэсэгт 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

16.8.Энэ хуулийн 16.4-т заасан этгээдээс бэлэг авсан бол албан тушаалтан тухайн этгээдтэй холбогдох захиргааны шийдвэр гаргах, удирдах, хянах, шалгах, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг албан үүргийг хоёр жилийн хугацаанд гүйцэтгэхгүй. /Энэ хэсэгт 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

16.9.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төрд ногдох хувийг эзэмшигчийн төлөөлөгч албан тушаалтан нь тухайн хуулийн этгээдэд ажиллах хугацаандаа, түүнчлэн албан үүргээ гүйцэтгэж дууссанаас хойш хоёр жилийн хугацаанд тухайн хуулийн этгээд, түүний удирдлагын гишүүдээс бэлэг авахыг хориглоно.

16.10.Албан тушаалтны төрийн өмчлөлд шилжүүлсэн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлсийг үнэлэх, хадгалах, зарцуулах журмыг Засгийн газар батална.

16.11.Мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх шагналыг энэ хуулийн 16.1-16.10-т заасан журмаар зохицуулна.

17 дугаар зүйл.Хандив авахтай холбогдсон хязгаарлалт

17.1.Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно.

17.2.Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага албан үүрэгтэй нь холбогдолгүй гуравдагч этгээдээс үзүүлж байгаа нийтийн албаны хэрэгцээнд, ажилтны сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, техникийн дэмжлэг зэрэг албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчилд оруулахгүй хандив, бусад санхүүгийн туслалцааг энэ хуулийн 17.1-д заасан хязгаарлалтад хамаарахгүй бол авч болно.

17.3.Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна.

17.4.Энэ хуулийн 17.2-т заасан хандив, санхүүгийн туслалцаа авсан албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага хоёр жилийн хугацаанд хандивлагчтай холбоотой аливаа шийдвэр гаргахыг хориглоно.

17.5.Албан тушаалтан дараах тохиолдолд биечлэн, эсхүл бусад этгээдээр зуучлуулан хандив хүсэх, хандив цуглуулахад оролцох, хүлээн авахыг хориглоно:

17.5.1.хүнд өвчнийг эмчлэхэд шаардлагатайгаас бусад тохиолдолд өөртөө буюу өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хэрэгцээнд;

17.5.2.өөрөө болон өөртэй нь хамаарал бүхий этгээд нь ашиг хуваалцдаг иргэн болон хуулийн этгээдийн хэрэгцээнд;

17.5.3.өөртэй нь хамаарал бүхий этгээд нь удирдлага, хяналт, захиргааны албанд нь ажилладаг хуулийн этгээдийн хэрэгцээнд.

18 дугаар зүйл.Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт

18.1.Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно.

18.2.Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн дараах ажил, албан тушаалыг давхар эрхэлж болно:

18.2.1.хууль болон олон улсын гэрээгээр зөвшөөрсөн ажил;

18.2.2.нийтэд тустай үйл ажиллагаанд чиглэсэн ажил;

18.2.3.багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажил;

18.2.4.хуульд заасан бол өөр өөрийн чиг үүргийн дагуу Улсын Их Хурлын болон Засгийн газрын албан тушаал;

18.2.5.хууль тогтоомжоор зөвшөөрсөн олон улсын байгууллага дахь албан тушаал.

18.3.Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, мөрдөх албаны албан тушаалтан салбарын хуульд тусгайлан зааснаас бусад ажил, албан тушаал эрхлэхийг хориглоно.

18.4.Зэвсэгт хүчний албан тушаалтан өөрийн удирдах албан тушаалтны бичгээр, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэж, эрх эдэлж болно. /Энэ хэсэгт 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

18.5.Энэ хуулийн 18.2-18.4-т зааснаас бусад албан тушаалтан дараах ажлыг давхар эрхэлж болно.

18.5.1.хууль тогтоомж, олон улсын гэрээгээр болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн ажил;

18.5.2.багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажил;

18.5.3.ашиг сонирхлын зөрчил үүсэхээргүй бол өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагын бичгээр, эсхүл цахим хэлбэрээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр бусад алба, гэрээний ажил, үүрэг. /Энэ заалтад 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

18.6.Татварын албанд ажил, үйлчилгээ хувиараа эрхэлж байгаа гэж бүртгүүлсэн, жилийн орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 80 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс илүүгүй, эсхүл төмс, хүнсний ногооны тариалан болон ойн аж ахуй, зөгий, загас, амьтан үржүүлэг, сургалт-аялал, сургалтын бусад үйл ажиллагаанаас орлого олдог бол албан тушаалтан үүнийгээ давхар эрхэлж болно. /Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

18.7.Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч байгаа бол Улсын Их Хурлаас байгуулагдах хяналт шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орохыг, түүнчлэн хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулахаар санаачлах, санал оруулахыг хориглоно.

19 дүгээр зүйл. Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журам

19.1.Албан тушаалтан нийтийн албанд орох үед хуулиар зөвшөөрөөгүй өөр ажил, үүрэг, гэрээ гүйцэтгэж, эрх эдэлж байгаа бол энэ тухай дээд шатны албан тушаалтанд бичгээр танилцуулах үүрэгтэй.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан танилцуулга хүлээн авсан албан тушаалтан ажлын байрны шаардлагыг харгалзан 30 хоногийн дотор давхар эрхэлж болохгүй алба, ажил, үүргээс чөлөөлөгдөх, гэрээ болон эрхийг цуцлах эсэх тухай шийдвэр гаргаж холбогдох албан тушаалтанд бичгээр мэдэгдэнэ.

20 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон хориглолт

20.1.Хуульд өөрөөр заагаагүй бол албан тушаалтан энэ хуулийн 18.6-д зааснаас бусад аж ахуйн үйл ажиллагаа гардан эрхлэх болон аж ахуйн нэгжийн удирдах бүтцэд ажиллахыг хориглоно.

/Энэ хэсэгт 2014 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

20.2.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг, танилцуулдаг байгууллагын дарга, тэдгээрийн тэргүүн дэд, дэд дарга, орлогч дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, Улсын Их Хуралд суудал бүхий намын дарга, төрийн өмчит компани, олон улсын байгууллагын дарга, захирлын албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны нийлүүлэгч, гүйцэтгэгч, төрийн санхүүгийн нөөц бүрдүүлэгч, төрөөс баталгаа гаргасан зээл хүртэгч аж ахуйн нэгжийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч байж болохгүй.

/Энэ хэсэгт 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

/Энэ хэсэгт 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан./

/Энэ хэсгийг 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ хэсэгт 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

20.3.Энэ хуулийн 20.2-т заасан албан тушаалтан, түүнтэй хамаарал бүхий этгээд энэ зүйлд заасан үүргийг нийтийн албанаас чөлөөлөгдсөний дараа хоёр жилийн хугацаанд мөн биелүүлнэ.

20.4.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтан тухайн хуулийн этгээдэд нийлүүлэх төрийн болон орон нутгийн хэрэгцээний бараа, ажил, үйлчилгээ худалдан авах захиалгын нийлүүлэгчээс ашиг авахыг хориглоно.

20.5.Албан тушаалтан нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд албан үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа төрийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, улсын болон орон нутгийн нөөцийн хуваарилалт, удирдах, хянах, хариуцлага хүлээлгэх зэрэг асуудлаар шийдвэр гаргаж байсан аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч болох, тус аж ахуйн нэгжээс хөрөнгө шилжүүлж авахыг хориглоно.

20¹ дүгээр зүйл.Улс төрд нөлөө бүхий зарим этгээдэд тавих хориглолт, хязгаарлалт

/Энэ зүйлийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн./

20¹.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга, эсхүл түүний эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд төрөөс санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт, арилжааны шинжтэй төсөл, хөтөлбөр, төрөөс олгох хөнгөлөлт, баталгаа, хандив, зээл хүртэгч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч байж болохгүй. /Энэ хэсгийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн./

20¹.2.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг даргын эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд төрийн албаны удирдах албан тушаал эрхлэх, төрийн болон орон нутгийн өмчит компани, улсын үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлагад ажиллахыг хориглоно. /Энэ хэсгийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн./

20¹.3.Энэ хуулийн 20.2, 20¹.1, 20¹.2-т заасныг зөрчсөн нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор гэм буруутай нь тогтоогдсон бол тухайн албан тушаалтныг чөлөөлөх, огцруулах, эгүүлэн татах үндэслэл болно. /Энэ хэсгийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн./

Тайлбар: -Энэ хуулийн 20¹.1, 20¹.2-т заасан “хүүхэд” гэдэгт эхнэр, нөхөр, хамтран амьдрагчийн одоо хамт амьдарч байгаа төрсөн, үрчлэн авсан хүүхдийг ойлгоно. /Энэ тайлбарыг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн./

-Энэ хуулийн 20.2, 20¹.1-д заасан “нөлөө бүхий хувьцаа эзэмшигч” гэж тухайн компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцааны тав, түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа болон тэдгээрийн саналын эрхийг хууль болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг ойлгоно. /Энэ тайлбарыг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн./

-Энэ хуулийн 20¹.2-т заасан “төрийн албаны удирдах албан тушаал” гэдэгт Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасан томилогдох төрийн өндөр албан тушаалтан, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтан, мөн хуулийн 18.2-т заасан тэргүүн түшмэлийн

ангилалд хамаарах албан тушаалыг ойлгоно. /Энэ тайлбарыг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн./

21 дүгээр зүйл. Албан тушаалаас чөлөөлөгдсөний дараах хязгаарлалт

21.1. Албан тушаалтан нь албан үүргээс чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд ашиг сонирхлын зөрчил үүсч болох дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

21.1.1. урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбоотой байсан аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах;

21.1.2. урьд ажиллаж байсан байгууллагатай гэрээ, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, тухайн байгууллагаас олгодог зөвшөөрлийг хүсэх; /Энэ заалтад 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

21.1.3. урьд ажиллаж байсан байгууллагын өмнө аливаа хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөх.

21.2. Энэ хуулийн 21.1.2-т заасан хязгаарлалт нь тухайн этгээд албан тушаалд сонгогдож, томилогдохоос өмнө байгуулагдсан буюу сунгагдсан гэрээ, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, түүнчлэн нээлттэй тендер шалгаруулалтын дагуу байгуулагдсан, эсхүл жилийн орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс бага үнийн дүн бүхий гэрээ, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд хамаарахгүй.

/Энэ хэсэгт 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

/Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

21.3. Албан тушаалтан энэ хуулийн 21.1-д заасан хязгаарлалтад хамаарах этгээдтэй албаны чиг үүргийн дагуу харилцаа тогтоохыг хориглоно.

21.4. Албан тушаалтан энэ хуулийн 21.1-д заасан хязгаарлалт зөрчигдөж байгаа талаар эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

22 дугаар зүйл. Бусад орлогын хязгаарлалт

22.1. Албан тушаалтан өөрийн албан үүргийн дагуу авах цалин хөлснөөс гадна энэ хууль, бусад хуулиар хориглоогүй бусад ажил, алба, гэрээний урамшуулал, мөн хуулиар хориглоогүй аж ахуйн үйл ажиллагааны орлого олж болно.

22.2. Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа бол Засгийн газрын гишүүний цалин авна.

22.3. Албан тушаалтан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд өмчлөгчийн төлөөлөгчийн ажил, үүрэг гүйцэтгэж байхдаа болон ажил үүрэг гүйцэтгэхээ больсноос хойш хоёр жилийн хугацаанд дараах үйл ажиллагааг хориглоно:

22.3.1. шууд, эсхүл гуравдагч этгээдийн зуучлалаар ажил, үүрэгтэй нь холбоогүй санхүүгийн эх үүсвэр зэрэг аливаа үр ашиг хүлээн авах;

22.3.2. холбогдох төрийн өмчит хуулийн этгээд болон түүний удирдлага, захиргааны гишүүнээс бэлэг авах;

22.3.3. холбогдох төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцаа, үнэт цаас, хөрөнгө олж авах;

22.3.4. холбогдох төрийн өмчит хуулийн этгээдэд өөр албан тушаал эрхлэх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ

23 дугаар зүйл. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах

23.1.Энэ хуулийн 4.1-д заасан нийтийн алба хашиж байгаа болон тэдгээр албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд /цаашид “мэдүүлэг гаргагч” гэх/ хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах бөгөөд шаардлагатай тохиолдолд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо Авлигатай тэмцэх газрын саналыг үндэслэн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах албан тушаалын жагсаалтыг батална.

23.2.Мэдүүлэг гаргагч хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ өөрөө үнэн зөв гаргах үүрэгтэй.

23.3.Албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ тухайн албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн албан тушаалыг хашиж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж, энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй.

23.4.Албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр энэ хуулийн 23.3-т заасан хугацаанаас хожимдуулж гаргасан бол уг мэдүүлгийг гаргаж өгөөгүйд тооцно.

23.5.Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ.

23.6.Авлигатай тэмцэх газар нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг ажлын 10 өдөрт багтаан хянан үзээд тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэх талаар томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэнэ.

23.7.Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд тухайн албан үүргийг гүйцэтгэхэд илт ашиг сонирхлын зөрчил үүсч болох нь тогтоогдсон бол Авлигатай тэмцэх газар илт ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөл байдлын талаар энэ хуулийн 23.6-д заасан мэдэгдэлд тодорхой дурдана. /Энэ хэсгийг 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

23.8.Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийн маягт, түүнийг бүртгэх, хянан шалгах, хадгалах журмыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо батална.

23.9.Энэ хуулийн 23.7-д заасан тохиолдолд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд мөн хуулийн 8 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллах талаар баталгаа гаргах бөгөөд түүнийг тухайн албан тушаалд томилох эсэхийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийдвэрлэнэ. /Энэ хэсгийг 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн./

23.10.Энэ хуулийн 23.9-д заасан баталгааны маягтыг Авлигатай тэмцэх газар батална. /Энэ хэсгийг 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн./

23.11.Авлигатай тэмцэх газар энэ хуулийн 23.6 дахь хэсэгт зааснаас бусад асуудлаар дүгнэлт, мэдэгдэл гаргахыг хориглоно. /Энэ хэсгийг 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./

24 дүгээр зүйл.Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх, хадгалах

24.1.Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг дараах байгууллага, албан тушаалтан хуульд заасан хугацаанд бүртгэж, хадгална:

24.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, түүнчлэн Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас томилогддог албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар;

24.1.2.Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо;

24.1.3.Үндсэн хуулийн цэцийн гишүүн болон бүх шатны шүүхийн шүүгчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Шүүхийн ерөнхий зөвлөл;

24.1.4.аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба; /Энэ заалтад 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

24.1.5.энэ хуулийн 24.1.2-24.1.4-т зааснаас бусад албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтан.

24.2.Энэ хуулийн 24.1.4–24.1.5-д заасан хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг авч дууссанаас хойш 14 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах журмын биелэлтийн талаарх тайланг, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргасан этгээдийн нэрсийн хамт Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.

24.3.Авлигатай тэмцэх газар хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах хууль тогтоомжийн биелэлтийн талаарх мэдээллийг жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны дотор Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд гаргаж өгнө.

25 дугаар зүйл.Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг нээлттэй байлгах

25.1.Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг нээлттэй байна.

25.2.Энэ хуулийн 24.1-д заасан байгууллага, албан тушаалтан иргэдийг албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтэй саадгүй танилцах боломжоор хангах үүрэгтэй.

25.3.Албан тушаалтнаас хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хэрхэн бөглөх талаар байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан захидал, хүсэлт, асуулт, тэдгээрт өгсөн хариулт, зөвлөгөө нь хүний эмзэг мэдээлэлд хамаарах бөгөөд түүнтэй холбогдох асуудлыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар зохицуулна. /Энэ хэсэгт 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

26 дугаар зүйл.Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хянан шалгах

26.1.Авлигатай тэмцэх газар энэ хуулийн 24.1.2-т зааснаас бусад хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийнэ.

26.2.Улсын Их Хурлын гишүүний хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг иргэний өргөдөл, гомдолд үндэслэн Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн Авлигатай тэмцэх газар шалгана. /Энэ хэсэгт 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

26.3.Монгол Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч байгаа бол тухайн гишүүний хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар шалгана. /Энэ хэсгийг 2012 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

26.4.Авлигатай тэмцэх газар өргөдөл, мэдээллийн мөрөөр, эсхүл төлөвлөгөөт хяналтаар шалгалт явуулж болно.

26.5.Улсын Их Хурлын гишүүнээс бусад албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл бүрэн гүйцэд гаргаагүй бол Авлигатай тэмцэх газар тухайн мэдүүлэг гаргагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг шалгана.

26.6.Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн мэдүүлэг засваргүй, бүрэн гүйцэд бөглөгдсөн, хугацаандаа өгсөн эсэхэд хяналт тавьж, мэдүүлгийг зохих журмын дагуу гаргаж өгөхийг шаардах, хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл байвал бүрэн эрхийнхээ хүрээнд хянан шалгах буюу авлигын шинжтэй зөрчил илэрвэл Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах үүрэгтэй.

26.7.Энэ хуулийн 24.1.2-т заасан албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо шалгана.

26.8.Мэдүүлэг гаргагч хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ бодитой, үнэн зөв тайлбарлах үүрэгтэй.

ТАВДУГААР БҮЛЭГ

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАХ

27 дугаар зүйл.Нийтийн албаны ёс зүйн дүрэм

27.1.Албан тушаалтан өөрийн мэргэжил, салбар, байгууллагад даган мөрдөж байгаа ёс зүйн дүрэмд үйл ажиллагаагаа нийцүүлэн ажиллана.

27.2.Албан тушаалтан өөрийн үйл ажиллагааны шударга, төвийг сахисан байдалдаа ёс зүйн шалтгаанаар эргэлзээ төрвөл албан үүргээ гүйцэтгэхээс, эсхүл давхар ажил, албан тушаал эрхлэхээс татгалзах үүрэгтэй.

28 дугаар зүйл.Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих этгээд

28.1.Энэ хуулийг холбогдох байгууллага, албан тушаалтан хэрхэн дагаж мөрдөж байгаад дараах байгууллага хяналт тавина:

28.1.1.нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаарх Авлигатай тэмцэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо;

28.1.2.энэ хуулийн 28.1.1-д зааснаас бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газар.

29 дүгээр зүйл.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

29.1.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасныг баримтлан дараах захиргааны хариуцлага хүлээлгэнэ: /Энэ хэсэгт 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

29.1.1.энэ хуулийн 7.3, 8.3, 19.2, 25.2, 26.6-д заасан үүргээ биелүүлээгүй байгууллагын эрх бүхий албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

29.1.2.энэ хуулийн 16 дугаар зүйл, 22.3-т заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн этгээдээр хууль бусаар хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ хөлсийг төлүүлж,

нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хууль бусаар орсон албан тушаалаас чөлөөлөх;

29.1.3.энэ хуулийн 20.2, 20¹.1-д заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, байгуулсан гэрээ, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, авсан зөвшөөрлийг хүчингүй болгох;

/Энэ заалтад 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

/Энэ заалтад 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

/Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

29.1.4.хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих үүргээ биелүүлээгүй, эсхүл холбогдох баримт бичгийг энэ хуулийн 24.2-т заасан хугацаанд ирүүлээгүй эрх бүхий албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

29.2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий албан тушаалтан дараах сахилгын шийтгэл хүлээлгэнэ:

29.2.1.хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг энэ хуулийн 23.3-т заасан хугацаанаас хожимдуулж гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол сануулах;

29.2.2.энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан хязгаарлалтыг зөрчсөн, энэ хуулийн 8.1, 8.2, 8.3, 9.1, 19.1, 21.3, 21.4, 23.5-д заасан үүргээ биелүүлээгүй, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг энэ хуулийн 23.3-т заасан хугацаанаас удаа дараа хожимдуулж гаргасан бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах;

/Энэ заалтад 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

/Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

29.2.3.энэ хуулийн 10, 14, 17, 18 дугаар зүйл, 20.1, 20.4, 20¹.2-т заасныг зөрчсөн, энэ хуулийн 9.2-т заасан арга хэмжээг аваагүй, энэ хуулийн 21.1-д заасан хязгаарлалтад хамаарах этгээдтэй гэрээ, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулсан, зөвшөөрөл олгосон, энэ хуулийн 23.7-д заасныг зөрчиж илтэд ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг албан тушаалд томилсон, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг худал мэдүүлсэн, энэ хуулийн 29.2.2-т заасан хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаалыг нь бууруулах;

/Энэ заалтад 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

/Энэ заалтад 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

29.2.4.энэ хуулийн 10¹.1, 10¹.2, 10¹.4, 10¹.5 дахь хэсэг, 11, 12, 15, 16 дугаар зүйлд заасныг зөрчсөн, энэ хуулийн 23 дугаар зүйлд заасан хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг гаргаж өгөөгүй, энэ хуулийн 29.2.3-т заасан хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан бол нийтийн албанаас халах./Энэ заалтад 2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

29.3.Шүүгчээс захиргааны хариуцлага хүлээлгэсэн нь тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

29.4.Энэ хуулийн 29.2-т заасан сахилгын шийтгэл хүлээсэн албан тушаалтан өөрт ногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэнэ.

29.5.Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журмыг Авлигатай тэмцэх газар батална.

29.6.Энэ хуулийн 20.2, 20¹.1, 20¹.2-т заасныг зөрчсөний улмаас нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж Авлигатай тэмцэх газар үзвэл энэ талаарх мэдээллийг прокурорт хүргүүлнэ./Энэ хэсгийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн./

30 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

30.1.Энэ хуулийг 2012 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. /Энэ хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгч 2012 оны 2 дугаар сарын 17-ны өдөр хориг тавьсан, 2012 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, Авлигын эсрэг хуулийн 10.1, 10.7, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23.1, 23.8 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос **ТОГТООХ** нь:

1. “Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах журам”-ыг Нэгдүгээр, “Мэдүүлэг гаргагчийн ... оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт”-ыг Хоёрдугаар, “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн маягт”-ыг Гуравдугаар, “Ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарын маягт”-ыг Дөрөвдүгээр, “Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт”-ыг Тавдугаар, “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргасан тухай баталгааны маягт”-ыг Зургадугаар, “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргасан тухай баталгааны маягт”-ыг Долдугаар, “Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргасан тухай баталгааны маягт”-ыг Наймдугаар, “Мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны баталгааны маягт”-ыг Есдүгээр, “Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-ыг Аравдугаар хавсралтаар тус тус баталсугай. *(Энэ тогтоолын 2 дугаар хавсралтын 1.1 дэх хэсэг болон 10 дугаар хавсралтын 1.10 дахь заалт, 1.4.7, 1.4.10, 1.4.13 дахь дэд заалтад Улсын Их Хурлын Хууль зүйн Байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон.)*

2. Журмыг үйл ажиллагаанд нэг мөр ойлгож хэрэглэх талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө, удирдлагаар ханган ажиллах, журмын биелэлтийн талаарх мэдээллийг жил бүрийн 04 дүгээр сарын 15-ны дотор Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд гаргаж байхыг Авлигатай тэмцэх газар (Тэргүүн комиссар З.Дашдаваа)-т даалгасугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” 05 дугаар тогтоол, 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн “Монгол Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах болон хавсралтыг шинэчлэн батлах тухай” 20 дугаар тогтоол, 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн “Албан тушаалтын

хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай 2012 оны 05 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай” 01 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолын аравдугаар хавсралтаар баталсан “Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-ыг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

5. Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

(Энэ тогтоолын 2 дугаар хавсралтын 1.1 дэх хэсэг болон 10 дугаар хавсралтын 1.10 дахь заалт, 1.4.7, 1.4.10, 1.4.13 дахь дэд заалтад Улсын Их Хурлын Хууль зүйн Байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон.)



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн “Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтаар баталсан “Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-ын 1.10 дахь заалтын “алба” гэсний дараа “төлөөлөгчийн газар” гэж, “банкны эрх хүлээн авагч,” гэсний дараа “бүрэн эрхт төлөөлөгч, тусгай төлөөлөгч, мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн, Монголбанкны хяналтын зөвлөлийн дарга, гишүүн,” гэж тус тус нэмсүгэй.

2.Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн “Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтаар баталсан “Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-ын 1.10 дахь заалтын “өр барагдуулах” гэснийг “авлага барагдуулах” гэж, 1.4 дэх заалтын 1.4.7 дахь дэд заалтын ““ТТ-1”-“ТТ-7”-д” гэснийг ““ТТ-1”-“ТТ-8”-д” гэж, 1.4.10 дахь дэд заалтын ““ТТ”-1”-“ТТ-7”-д” гэснийг ““ТТ”-1”-“ТТ-6”-д” гэж, 1.4.13 дахь дэд заалтын ““ТТ-11”-“ТТ-19”-д” гэснийг ““ТТТ-1”-“ТТТ-8”-д хамаарах албан тушаалтан болон тусгай техникийн үзлэгийн ажилтан, нягтлан бодогч” гэж, мөн 2 дугаар хавсралтын “Иргэншил” гэснийг “Иргэний харьяалал” гэж тус тус өөрчилсүгэй.

3.Албан тушаалтны хуулиар хүлээсэн чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолт хэвээр байгаа боловч ангилал, зэрэглэл нь өөрчлөгдсөн бол Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн “Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах” 05 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтын 1 дэх хэсэгт заасныг баримтлан ажиллана.

4.Жагсаалтад орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох байгууллагад хүргүүлж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, удирдлагаар ханган, биелэлтийг жил бүрийн 04 дүгээр сарын 15-ны дотор Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд гаргаж танилцуулахыг Авлигатай тэмцэх газар /Тэргүүн комиссар З.Дашдаваа/-т даалгасугай.

5.Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу нийтийн албан тушаалтнаас өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээл, хувийн ашиг сонирхлын байдлыг болон нийтийн албанд томилогдоход хувийн ашиг сонирхол үүсэх эсэхийг хянуулахаар гаргасан, сонгуульд нэр дэвшиж байгаа этгээдээс гаргасан хөрөнгө орлого, зээлийн талаарх мэдээллийг бүртгэх, хянан шалгах, хадгалахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү журамд заасан нэр томъёог дараах утгаар ойлгоно.

1.2.1. “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг” (цаашид “ХАСХОМ” гэх) гэж мэдүүлэг гаргагчаас хуульд заасны дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хувийн ашиг сонирхол, өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийн талаар гаргасан мэдээллийг.

1.2.2. “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг” (цаашид “ХАСУМ” гэх) гэж нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдээс томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар дамжуулан Авлигатай тэмцэх газарт мэдүүлж байгаа тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэхийг хянуулахаар гаргасан мэдээллийг.

1.2.3. “Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлэг” (цаашид “Сонгуульд нэр дэвшигчийн ХОМ” гэх) гэж Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, Монгол Улсын Их Хурлын сонгууль, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшиж байгаа иргэнээс эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өөрийн болон гэр бүлийн гишүүний хөрөнгө, орлого, зээлийн талаар гаргасан мэдээллийг.

1.2.4. “Баталгааны маягт” гэж энэ зүйлийн 1.2.1, 1.2.2, 1.2.3-т заасан ХАСХОМ, ХАСУМ, Сонгуульд нэр дэвшигчийн ХОМ-ийг цахим хэлбэрээр гаргасан тухай баталгааг.

1.2.5. “Мэдэгдэл” гэж нийтийн албан тушаалтнаас албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргасан мэдээллийг.

1.2.6. “Тайлбар” гэж нийтийн албан тушаалтнаас албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалд энэ тухай батлагдсан маягтын дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргасан мэдээллийг.

1.2.7. “Мэдүүлэг” гэдэгт энэ зүйлийн 1.2.1, 1.2.2, 1.2.3-т заасан ХАСХОМ, ХАСУМ, Сонгуульд нэр дэвшигчийн ХОМ-ийг.

1.2.8. “Мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтан” (цаашид “ЭБАТ” гэх) гэж тухайн байгууллагын захиргаа, хуулийн асуудал эрхэлсэн албан тушаалыг эрхлэхийн зэрэгцээ байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг хүлээн авч, бүртгэх, хадгалах болон хуульд заасан бусад чиг үүргийг хавсран гүйцэтгэхээр томилогдсон албан хаагч, ажилтныг.

1.3. Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг Авлигатай тэмцэх газраас хөтлөх Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим систем (<https://meduuleg.iaac.mn/>)-ээр гаргах бөгөөд мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргасан тухай баталгааны маягтыг хэвлэмэл байдлаар тухайн байгууллагын ЭБАТ-д хүлээлгэн өгнө.

1.4. Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжоор зохион байгуулалтын бүтэц, орон тоо, хүний нөөцийн мэдээллийг нь төрийн нууцад хамааруулсан байгууллагын албан тушаалтан мэдүүлэг, мэдэгдэл, тайлбараа хэвлэмэл байдлаар гаргаж болно.

1.5. Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар гаргасан хугацааг Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд баталгаажуулсан (хэвлэмэл байдлаар гаргасан бол ЭБАТ-д бүртгүүлсэн) он, сар, өдрөөр тооцно.

1.6. Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын талаар мэдээлэл өгөх журам, мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг хүлээн авч бүртгэх бүртгэлийн болон мэдээ, тайлангийн маягт, мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар гаргах зааварчилгааг Авлигатай тэмцэх газрын дарга батална.

1.7. Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчийн ХОМ гаргавал зохих этгээдийн бүртгэл, лавлагааны маягтыг Авлигатай тэмцэх газрын дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга хамтран батална.

1.8. Авлигатай тэмцэх газар Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчийн ХОМ-ийг бүртгэж, хүлээн авсан тухай лавлагаа / тодорхойлолт/-г холбогдох хуульд заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ.

Хоёр. Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар гаргах харьяалал

2.1. Мэдүүлэг гаргагч дараах байгууллага, албан тушаалтанд мэдүүлгээ гаргаж бүртгүүлнэ.

2.1.1. Төрийн өндөр, түүнтэй зэрэг зиндаа адилтгах албан тушаалтан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигч Авлигатай тэмцэх газарт.

2.1.2. Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас томилогддог зөвлөл, хорооны орон тооны гишүүн болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх, Улсын Их Хурлын даргын зөвлөх, Ерөнхий сайдын зөвлөх тухайн байгууллагын Ажлын албанд.

2.1.3. Энэхүү журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Улсын Их Хурлаас томилдог албан тушаалтан Улсын Их Хурлын Тамгын газарт, Ерөнхийлөгчийн томилдог албан

тушаалтан Ерөнхийлөгчийн Тамгын газарт, Засгийн газраас томилдог албан тушаалтан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт.

2.1.4.Бүх шатны шүүхийн шүүгч Шүүхийн ерөнхий зөвлөлд.

2.1.5.Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд.

2.1.6.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Ажлын албаны ажилтан, бүх шатны Засаг дарга, Засаг даргын орлогч тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд.

2.1.7.Бүх шатны Засаг даргаас томилогддог албан тушаалтан тухайн шатны Засаг даргын Тамгын газарт.

2.1.8.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газар (аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар)-ын удирдах болон эрх бүхий албан тушаалтан түүнийг томилох албан тушаалтанд.

2.1.9.Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын удирдах болон эрх бүхий албан тушаалтан нь түүнийг томилох эрх бүхий албан тушаалтанд.

2.1.10.Төрийн тодорхой чиг үүрэг, ажил үйлчилгээг холбогдох хууль, гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг Засгийн газрын бус байгууллага (төрийн бус байгууллага), нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан тухайн төсвийн ерөнхийлөн захирагчид.

2.1.11.Төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсаас гадаад улстай байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр, Засгийн газрын тусгай сангийн болон Засгийн газар хоорондын гэрээ, зээл, тусламж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн зохицуулагч, удирдах албан тушаалтан тухайн төсвийн захирагчид.

2.1.12.Энэхүү журмын 2.1.1-2.1.11-д зааснаас бусад албан тушаалтан түүнийг томилох эрх бүхий албан тушаалтанд.

2.2.Мэдэгдэл, тайлбарыг тухайн чиг үүргийг гүйцэтгүүлэхээр томилсон, эсхүл шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана.

2.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч тухайн шатны сонгуулийн хороонд гаргана.

2.4. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүлнэ.

Гурав.Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг хүлээн авах, бүртгэх байгууллагын удирдлага, ЭБАТ-ын эрх, үүрэг

3.1.Байгууллагын удирдлага мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг хүлээн авч, бүртгэх, тайлагнах, хадгалах хүрээнд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1.Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах.

3.1.2.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, гүйцэтгэлийг хяналт тавих, тайлагнах.

3.1.3.Байгууллага, салбарын хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх хууль тогтоомжийг сурталчлах, сургалт зохион байгуулах, нийтийн албан тушаалтны мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг хүлээн авч, бүртгэх, мэдэгдэл, тайлбарыг хянан шийдвэрлэх, энэ талаар арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгөх.

3.1.4.Хүний хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, энэ талаар тогтоосон журам, дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөх.

3.1.5.Хүний хувийн мэдээллийг бусдад задруулах, задрах эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх.

3.1.6.Нийтийн албан тушаалтнаас гаргасан мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын тайланг тогтоосон хугацаанд тайлагнах, тайлангийн үнэн зөвийг хариуцах.

3.1.7.Авлигатай тэмцэх газрын хууль ёсны шийдвэр, шаардлагыг биелүүлэх, шаардлагатай баримт, мэдээ, мэдээллийг саадгүй гаргаж өгөх.

3.1.8.ЭБАТ-ыг тогтвор суурьшилтай ажиллуулах, томилох, чөлөөлөх тухай бүрд Авлигатай тэмцэх газарт албан ёсоор мэдэгдэх.

3.1.9.Тухайн байгууллагын ЭБАТ-ыг томилж, албан тушаалынх нь цалингийн 40 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл урамшуулал олгох бөгөөд шаардлагатай тохиолдолд уг асуудлыг эрхлэх орон тооны ажилтантай байж болно.

3.1.10.ЭБАТ-аас чиг үүргээ хэрэгжүүлэхэд аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхгүй байх.

3.1.11.Холбогдох бусад.

3.2.ЭБАТ дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.2.1.Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд өөрийн эрхээр нэвтрэх, харьяа салбар, нэгжийн ЭБАТ-ын цахим системд эрхийг зохицуулах, цахим системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах.

3.2.2.Хүний хувийн мэдээллийг задрах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аливаа хэлбэрээр задруулахгүй байх, мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй байх.

3.2.3.Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд нийтийн албан тушаалтны мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар гаргах нөхцөлийг бүрдүүлж, эрхийг үүсгэх, хяналт тавих.

3.2.4.Харьяа салбар, нэгжийн ЭБАТ-ын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн тусалцаа үзүүлэх, зөвлөн туслах, үйл ажиллагаанд нь хяналт тавих.

3.2.5.Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар, баталгааны маягтад холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд, бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгөхийг шаардах.

3.2.6.Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар, мэдэгдэл, тайлбарын шийдвэрлэлт, байгууллагын удирдлагын зөвшөөрлөөр мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын талаар мэдээлэл өгөх журмын дагуу мэдээлэл өгсөн тухай болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан нийтийн албан тушаалтан бэлэг авах, давхар ажил эрхлэхтэй холбоотой бүртгэл хөтлөх, энэ тухай тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх.

3.2.7.Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын тайлан, мэдээний үнэн бодит байдлыг хариуцах.

3.2.8.Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд мэдүүлэг гаргагчийн шилжилт, хөдөлгөөнийг хөтлөх.

3.2.9.Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар, тайлан мэдээ, холбогдох бусад баримтыг зориулалтын байр, тавиур, шүүгээнд холбогдох журам, стандартын дагуу хадгалж, тухайн онд үүсэж хөтлөгдсөн баримтуудаар архивын нэгж үүсгэж, хуульд заасан хугацаанд архивд шилжүүлэх.

3.2.10.Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг хүлээн авах, бүртгэх. Энэ чиглэлээр шаардлагатай мэдээ, мэдээллээр хангагдах, сургалтад хамрагдах.

3.2.11.Тухайн жилийн мэдүүлгээ шинэчлэн гаргасан хугацаанаас хойш байгууллагын бүтцийн нэгж дотроо томилогдсон, сонгогдсон мэдүүлэг гаргагчийн шилжилт, хөдөлгөөнийг Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд хийх.

3.2.12.ЭБАТ тайлан, мэдээг дараах тогтоосон хугацаанд зохих журмын дагуу гаргана.

3.2.12.1.ХАСХОМ-ийг шинэчлэн гаргуулах хугацаанаас өмнө мэдүүлэг гаргах албан тушаалтны нэрсийн жагсаалтыг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх.

3.2.12.2.Салбар, нэгжийн ЭБАТ мэдүүлгийг хуульд заасан хугацаанд хүлээн авч дууссанаас хойш тайлан, мэдээг 7 хоногийн дотор дээд шатны байгууллагад хүргүүлэх.

3.2.12.3.Дээд шатны байгууллагын ЭБАТ ХАСХОМ-ийг шинэчлэн гаргуулснаас хойш 14 хоногийн дотор холбогдох хууль, журмын биелэлтийн талаарх тайланг,

мэдүүлэг гаргасан этгээдийн нэрсийн хамт харьяа салбар, нэгжийн түвшинд нэгтгэн Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх.

3.3.Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар, баталгааны маягтыг хүлээн авах, илгээх, бүртгэхэд төрийн албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж, цахим гарын үсгийн тухай хууль тогтоомжийг баримтална.

Дөрөв. Мэдүүлэг гаргах, хянах, бүртгэх

4.1.ХАСХОМ, ХАСУМ, Сонгуульд нэр дэвшигчийн ХОМ-ийг тухайн этгээд Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системээр дамжуулан гаргаж, баталгааны маягтад гарын үсэг зурж энэ журмын 2.1, 2.3 дахь хэсэгт заасан байгууллага, ЭБАТ-д хүлээлгэн өгч бүртгүүлнэ.

4.2.ХАСХОМ, Сонгуульд нэр дэвшигчийн ХОМ-ийг өмнөх оны 12 дугаар сарын 31-ний байдлаар, ХАСУМ-ийг тухайн мэдүүлгийг гаргах үеийн нөхцөл байдлаар, хөрөнгө, орлого нь 1 (нэг) сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь (250) дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол өөрчлөлт орсон үеийн байдлаар тус тус мэдүүлнэ.

4.3.ХАСУМ гаргах, хянах.

4.3.1.Мэдүүлэг гаргах нийтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн этгээд /шинээр болон туршилтын хугацаанд, сэлгэн, шилжин, хавсран, хослон, түр орлон гүйцэтгэх тухай бүр/ нь ийнхүү нэр дэвших бүрд ХАСУМ гаргана.

Албан тушаалаас чөлөөлөгдсөн (мөр 7) Тайлант онд “Төрийн албаны тухай” хуульд заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдсөн, түр чөлөөлөгдсөн, “Хөдөлмөрийн тухай” хуульд зааснаар хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон, аж ахуйн нэгж, байгууллага болон түүний салбар, нэгж татан буугдсан, орон тоо хасагдсан, эсхүл ажилтны тоог цөөрүүлсэн, сонгууль, томилолтоор өөр орон тооны ажил, албан тушаалд ажиллах болсон, ажилтан тэтгэврийн насанд хүрч өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн үндэслэлээр ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцалсан албан тушаалтныг хамруулна.

Албан тушаалаас халагдсан (мөр 8) Тайлант онд “Төрийн албаны тухай” хуульд заасан албан үүргээ удаа дараа /2 ба түүнээс дээш/ хангалтгүй биелүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон, Монгол Улсын харьяатаас гарсан үндэслэлээр төрийн албанаас халагдсан, “Хөдөлмөрийн тухай” хуульд зааснаар ажилтан хөдөлмөрийн сахилгын зөрчлийг давтан гаргасан, эсхүл хөдөлмөрийн харилцааг шууд зогсоохоор хөдөлмөрийн гэрээнд тухайлан заасан нөцтой зөрчил гаргасан, мөнгө болон эд хөрөнгө хариуцсан ажилтан ажил олгогчийн итгэлийг алдсан буруутай үйлдэл, эс үйлдэхүй гаргасан нь тогтоогдсон үндэслэлээр болон бусад хуульд заасан үндэслэлээр ажил албанаас халагдсан албан тушаалтныг хамруулна.

Бусад (мөр 9) мөр 7, 8-д зааснаас бусад үндэслэлээр ажил албанаас халагдсан, чөлөөлөгдсөн албан тушаалтныг хамруулна.

Тухайн жилд мэдүүлэг гаргавал зохих хүний тоо-бүгд (мөр 10) Тайлант оны эхэнд мэдүүлэг гаргасан хүний тоон дээр тайлант онд шинээр мэдүүлэг гаргасан хүний тоог нэмж, хасагдсан хүний тоог хасаж тооцно / $\text{мөр}(10)=\text{мөр}(1+2-6)/$, $\text{мөр}(10)=\text{мөр}(11+12+13)/$.

Хугацаандаа мэдүүлсэн (мөр 11) МУ-ын Авлигын эсрэг хуулийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 23.3-д заасан хугацаанд /жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор/ мэдүүлгээ шинэчлэн гаргаж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн мэдүүлэг гаргагчдын тооны нийлбэр байна.

Хугацаа хожимдуулж мэдүүлсэн (мөр 12) Хуульд заасан хугацааг хожимдуулж хөрөнгө орлогын мэдүүлгээ эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн мэдүүлэг гаргагчийг хамруулна.

Мэдүүлэг гаргаж өгөөгүй, мэдүүлэг гаргахаас татгалзсан (мөр 13) Авлигын эсрэг хуулийн 10.3, 10.4-д заасан хугацаанд мэдүүлгээ гаргаж өгөөгүй мэдүүлэг гаргагчийн тоог хамруулна.

Мэдүүлэг гаргасан хүний тоо, тайлант оны эцэст (мөр 14) Тухайн жилд хөрөнгө орлогын мэдүүлэг гаргавал зохих этгээдээс хөрөнгө орлогын мэдүүлгээ хугацаанд нь мэдүүлсэн болон хугацаа хожимдуулж мэдүүлсэн мэдүүлэг гаргагчийн тооны нийлбэр байна / $\text{мөр}(14)=\text{мөр}(11+12)$, $\text{мөр}(14)/=\text{мөр}(10-13)$.

Мэдүүлэг гаргагчийн баталгааны хуудсыг хүлээн авсан хэлбэр (мөр 15-17) Мэдүүлэг гаргагчийн баталгааны хуудсыг гараас гарт, баталгаат шуудан, цахим шуудангийн аль хэлбэрээр ирүүлснээр нь ангилан хамруулна / $\text{мөр}(10) = \text{мөр}(15+16+17)/$.

Гараас гарт (мөр 15) Мэдүүлэг гаргагч нь мэдүүлэг хүлээн авах эрх бүхий этгээдэд биечлэн хүргэсэн баталгааны маягтын тоог хамруулна.

Баталгаат шуудангаар (мөр 16) МУ-ын Их хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тушаалын 07 дугаар хавсралтаар баталсан “Албан тушаалтны хувийн

ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 2.5-д заасны дагуу шуудангаар илгээсэн баталгааны маягтын тоог бичнэ.

Цахим шуудангаар (мөр 17) Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 2.7-д зааснаар мэдүүлэг хүлээн авах эрх бүхий этгээдийн албан ёсны цахим шуудангийн хаягаар илгээсэн баталгааны маягтын тоог бичнэ.

Их хэмжээний өөрчлөлттэй мэдүүлгийн тоо (мөр 18) Тайлант онд “Авлигын эсрэг хууль”-ийн 10.4-д заасны дагуу “Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд мэдүүлгээ мэдүүлсний дараа хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөнийг мэдэгдэж бүртгүүлсэн” мэдүүлэгийн тоог бичнэ.

Ашиг сонирхлын мэдэгдлийн тоо-бүгд (мөр 19) Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн болон ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдлийн тооны нийлбэртэй тэнцүү байна /мөр(19)=мөр(20+21)/.

Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийн тоо (мөр 20) Тайлант онд нийтийн албан тушаалтнаас МУ-ын “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 8.1-д зааснаар ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн нийт мэдэгдлийн тооны нийлбэр байна.

Ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдлийн тоо (мөр 21) Тайлант онд нийтийн албан тушаалтнаас МУ-ын “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 8.2-т заасны дагуу “ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдал”-ын талаар мэдэгдсэн мэдэгдлийн тооны нийлбэр байна.

Ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд бичгээр өгсөн тайлбар (мөр 22) Тайлант онд нийтийн албан тушаалтнаас “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 8.6-д заасны дагуу тайлбарыг бичгээр гаргаж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн тоог хамруулна.

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг гаргасан хүний тоо (мөр 23) Тайлант онд тухайн байгууллага “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 23.5-д зааснаар нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн хүний хувийн ашиг сонирхлын зөрчлийн урьдчилсан мэдүүлгийг хүлээн авч, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн тоог хамруулна.

Өмнөх он (багана 1) Тайланд туссан бүх үзүүлэлтийн улсын дүнг өмнөх оны байдлаар харуулна.

Тайлант он (багана 2) Тайлангийн мөрийн дагуу гарах үзүүлэлтүүдийг улсын дүнгээр тайлант оны байдлаар илэрхийлнэ.

В. Баталгааны хэсэг

Баталгаажуулсан: Байгууллагын дарга –байгууллагын даргын гарын үсэг, гарын үсгийн тайлал байна.

Хянасан: Тамгын газрын дарга- байгууллагын тамгын газрын даргын гарын үсэг, гарын үсгийн тайлал байна.

Мэдээ гаргасан ажилтан – Тухайн байгууллагын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, гарын үсгийн тайлал байна. Мэдээ гаргасан ажилтанд албан тушаал харгалзахгүй тухайн байгууллагын хөрөнгө орлогын мэдүүлгийн мэдээг гаргах эрх бүхий этгээдийг хамруулна.

Тамга тэмдэг – Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэж, АТГ-д мэдээг ирүүлж буй эрх бүхий байгууллагын тамга тэмдэг байна.

Огноо – Мэдээ гаргасан он, сар, өдөр байна.



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр

Дугаар А/122

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 59, 60 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар иргэдэд мэдээлэл өгөх журам” /шинэчилсэн найруулга/-ыг нэгдүгээр, “Мэдээлэл авах хүсэлт гаргах маягт”-ыг хоёрдугаар, “Албан тушаалтны ... оны хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт /хураангуй”-ыг гуравдугаар, “Албан тушаалтны ... оны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн маягт /хураангуй”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай. *(Энэ тушаалын 3 болон 4 дүгээр хавсралтыг Авлигатай тэмцэх газрын даргын 2025 оны А/18 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.)*

2. Энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нийтийн албаны удирдлагуудад, журмыг хэрэгжүүлэх чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс /Эрхэлсэн комиссар Х.Хашбаатар/-т үүрэг болгосугай.

3. Журмыг баталснаас хойш ажлын 5 өдрийн дотор Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Тамгын хэлтэс /Эрхэлсэн комиссар З.Баасанням/-т даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан тус газрын даргын 2012 оны “Журам батлах тухай” 196 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар мэдээлэх, мэдээлэл өгөх журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Журмыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР

Х.ЭНХЖАРГАЛ

(Энэ тушаалын 3 болон 4 дүгээр хавсралтыг Авлигатай тэмцэх газрын даргын 2025 оны А/18 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.)

**АЛБАН ТУШААЛТНЫ ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН БОЛОН ХӨРӨНГӨ,
ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН ТАЛААР ИРГЭДЭД МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ ЖУРАМ**
/шинэчилсэн найруулга/

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /цаашид “Мэдүүлэг” гэх/, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл /цаашид “мэдэгдэл” гэх/, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн нөхцөлд бичгээр гаргасан тайлбар /цаашид “тайлбар” гэх/-ын талаар хүсэлт гаргасан иргэн, албан тушаалтан, байгууллагад мэдээлэл өгөх, Авлигатай тэмцэх газраас нийтийн албан тушаалтны хөрөнгө орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хураангуй хэлбэрээр мэдээлэхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Энэ зүйлийн 1.1 дэх хэсэгт заасан мэдээлэл өгөхөд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, хувийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, энэ журмыг баримтална.

1.3 Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбартай холбоотой мэдээлэл нь хувь хүний нууцад, хүсэлтийн агуулга, мэдээлэл авсан иргэн, албан тушаалтан, байгууллагын талаарх мэдээлэл нь албаны нууцад хамаарна.

1.4 Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбартай холбоотой мэдээллийг түүнийг хадгалж байгаа байгууллагын удирдах албан тушаалтны бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн олгоно.

Хоёр. Мэдээлэх хэлбэр, хугацаа

2.1 Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хураангуй хэлбэрээр, батлагдсан маягтын дагуу жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан Авлигатай тэмцэх газрын цахим мэдээллийн сүлжээнд байршуулж, иргэд, олон нийтийг энэ тухай мэдээлэл авах боломжоор хангана.

2.2 Иргэн, албан тушаалтан, байгууллага хүсэлт гаргавал мэдүүлгийг зөвхөн батлагдсан маягтын дагуу хураангуй хэлбэрээр, мэдэгдэл, тайлбарыг эх хувиар нь тус тус танилцуулна.

2.3 Энэ журмын 4.1 дэх хэсэгт заасан байгууллага мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэж, хадгалж буй байгууллагад хандан албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаарх мэдээллийг ирүүлэх хүсэлт албан ёсоор ирүүлсэн тохиолдолд нэн даруй шийдвэрлэж, баталгаажуулан хариу өгнө. Шаардлагатай гэж үзвэл Авлигатай тэмцэх газар мэдүүлгийг цахим системээс эх хувиар нь хэвлэж, баталгаажуулж хүргүүлнэ.

Гурав. Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын талаар мэдээлэл өгөх

3.1 Иргэн нийтийн албан тушаалтны мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын талаар мэдээлэл авах хүсэлтийг тухайн албан тушаалтны мэдүүлгийг хадгалж буй байгууллагын

удирдлагад энэ журмын хоёрдугаар хавсралтад заасан маягтын дагуу биечлэн эсхүл цахимаар гаргана.

3.2 Хүсэлтийг хүлээн авснаас хойш тухайн байгууллагын удирдлага ажлын 3 өдөрт хянан үзэж, энэхүү журмаар тогтоосон хүрээнд мэдээлэл өгөх зөвшөөрлийг зөвхөн бичгээр олгоно.

3.3 Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын талаар мэдээлэл өгөх боломжгүй нөхцөл байдал тогтоогдвол энэ тухай үндэслэлээ хүсэлт гаргагчид тайлбарлах ба шаардлагатай гэж үзвэл албан ёсоор хариу өгнө.

3.4 Тухайн байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан /цаашид “ЭБАТ” гэх/ энэ журмын 3.2 дахь хэсэгт заасан зөвшөөрлийг үндэслэн мэдээлэл авахыг хүссэн иргэний овог, нэр, оршин суугаа хаягийг иргэний үнэмлэхтэй тулган, холбогдох утасны дугаар, холбогдох бусад мэдээллийг хянаж үзнэ.

3.5 Энэ журмын 3.4 дэх хэсэгт зааснаар мэдээллийг хянах явцад ямар нэг зөрчил илрээгүй бол Хувь хүний нууцын тухай хууль, энэ журмыг урьдчилан танилцуулсны дараа энэхүү журмын гурав, дөрөвдүгээр хавсралтад заасан маягтын дагуу мэдээллийг хэвлэмэл хэлбэрээр саадгүй гаргаж өгнө.

3.6 ЭБАТ мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын талаар мэдээлэл авах хүсэлт, мэдээлэл өгсөн тухай бүртгэлийг хөтөлж энэ тухай тайланг жил бүр Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ. Иргэний хүсэлтийг тухайн байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж болгон архивт шилжүүлнэ.

3.7 Энэ журмын 3.3 дахь хэсэгт заасан үндэслэлийг хүлээн зөвшөөрөхгүй тухайн иргэн Авлигатай тэмцэх газарт хандан мэдээлэл авах хүсэлт гаргаж болно.

3.8 Авлигатай тэмцэх газар хүсэлтийг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хянан шийдвэрлэнэ.

Дөрөв. Бусад

4.1 Хуулиар тусгайлан эрх олгогдсон шүүх, прокурор, цагдаа, тагнуулын болон бусад эрх бүхий төрийн байгууллага зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу мэдүүлэгтэй танилцаж, мэдээлэл авч болно.

4.2 Энэ журмын 4.1 дэх хэсэгт заасан байгууллагаас Авлигатай тэмцэх газарт гаргасан албан ёсны хүсэлтийг үндэслэн мэдүүлгийн хуулбарыг өгч болох ба энэ тухай бүртгэл хөтөлнө.

4.3 Энэ журамд зааснаас бусад тохиолдолд мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын талаар мэдээлэх, мэдээлэл өгөх, зөвшөөрөл олгохыг хориглоно.

4.4 Энэ журмын 4.3-д заасныг зөрчсөн нь тогтоогдсон буруутай албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---000---

МЭДЭЭЛЭЛ АВАХ ХҮСЭЛТ ГАРГАХ МАЯГТ

/Цахим хаягаар дамжуулан авах бол иргэний үнэмлэхний хуулбарыг хавсаргана./

НЭГ: ХҮСЭЛТ ГАРГАХ ИРГЭН ДАРААХ МЭДЭЭЛЛИЙГ БИЧНЭ.

.... нийслэл /Аймаг, сум, дүүрэг/-ийн /байгууллагын нэр/-ийн дарга танаа		
1. Хүсэлт гаргаж байгаа иргэний мэдээлэл		
1. Ургийн овог:	2. Эцгийн нэр:	3. Өөрийн нэр:
4. Төрсөн огноо:	5. Регистрийн дугаар:	
6. Хүйс: эрэгтэй/эмэгтэй		
7. Оршин суугаа хаяг:		
8. Холбоо барих утасны дугаар:		
9. Шуудангийн хайрцаг:	10. Цахим шуудангийн хаяг:	
2. Мэдээлэл авах зорилго, хэрэгцээ, шаардлага:		
..... /тодорхой бичих/		
3. Мэдээллийн төрөл: /аль нь болох √ гэж тэмдэглэх/		
☐ Хөрөнгө орлогын мэдүүлэг ☐ Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг ☐ Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл ☐ Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн нөхцөлд бичгээр гаргасан тайлбар		

ХОЁР: ЗӨВХӨН ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЛБАН ТУШААЛТАН БИЧНЭ.

1. Зөвшөөрөл олгосон:	
Албан тушаалтны овог, нэр:	
Албан тушаал:	
Гарын үсэг:	
Огноо:	
2. Зөвшөөрөл олгохоос татгалзсан үндэслэл	
☐ Хүсэлт тодорхой бус ☐ Бусад: /дэлгэрэнгүй бичих/	

ГУРАВ: ЗӨВХӨН МЭДЭЭЛЭЛ ӨГСӨН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН /ЭБАТ/ БИЧНЭ.

1. Мэдээлэл өгсөн хэлбэр	
Мэдээлэл хүлээн авсан иргэний овог, нэр	
Гарын үсэг:	
Огноо:	
Цахимаар илгээсэн бол	иргэний цахим хаяг
	илгээсэн огноо
2. Мэдээлэл өгсөн эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/	
Албан тушаалтны овог, нэр:	
Албан тушаал:	
Гарын үсэг:	
Огноо:	

---000---



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

ТУШААЛЫН ХАВСРАЛТЫГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1.6 дахь заалт, Монгол Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн “Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Журам батлах тухай” 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/122 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан “Албан тушаалтны ... оны хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт /хураангуй/-ыг нэгдүгээр, дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалтны ... оны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн маягт /хураангуй/-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Шинэчлэн баталсан тушаалын хавсралтыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, үйл ажиллагаанд нэг мөр ойлгож хэрэглэх талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Т.Энхболдод үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалыг Захиргааны ерөнхий хуульд зааснаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар З.Баасаннямд даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/122 дугаар тушаалын гуравдугаар, дөрөвдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР

З.ДАШДАВАА

Авлигатай тэмцэх газрын даргын
2025 оны 02 дугаар сарын 05-ны
өдрийн А/18 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

(Авлигатай тэмцэх газрын даргын
2018 оны 11 дүгээр сарын 14-ний
өдрийн А/122 дугаар тушаалын
дөрөвдүгээр хавсралт)

МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧИЙН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛГИЙН ХУРААНГУЙ МЭДЭЭНИЙ МАЯГТ

№	Эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр	Эрхэлж байгаа албан тушаал, байгууллага	Томилгогдсон /сонгогдсон огноо	Хамаарал бүхий этгээдийн нэр	Нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр	Гишүүнчлэлд байгаа хуулийн этгээд, ТББ-ын нэр	Давхар эрхэлж байгаа ажил, үүрэг, гэрээний ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл		Бэлэг, үйлчилгээ, өв залгамжлал, хандив, туслалцаа, хөнгөлөлт
							байгууллага, албан тушаалын нэр	үйл ажиллагааны чиглэл	
1	2	3	4	5	6	7	9	10	нийт дүн (мян. төг)

(Энэ маягыг Авлигатай тэмцэх газрын даргын 2025 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн А/18 дугаар тушаалаар шинэчилсэн.)



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр

Дугаар А/123

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5, Захиргааны ерөнхий хуулийн 59, 60 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ НЬ:

1."Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам" / шинэчилсэн найруулга/-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг нийтийн албаны удирдлагуудад, журмыг нийтийн албаны удирдлагуудаас мөрдлөг болгон хэвшүүлэхэд арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлж, сахилгын шийтгэл ногдуулсан талаарх шийдвэр, мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд хүргэсэн талаарх нэгдсэн сан бүрдүүлэн, жил бүр дүнг нэгтгэн танилцуулж байхыг Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс /Эрхэлсэн комиссар Т.Баярхүү/-т даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тухайн мэдээллийг холбогдох этгээдэд хүргүүлсэн, нийтэд мэдээлсэн нийтийн албаны удирдлагад үүрэг болгосугай.

4.Журмыг баталснаас хойш ажлын 5 өдрийн дотор Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Тамгын хэлтэс /Эрхэлсэн комиссар З.Баасанням/-т даалгасугай.

5.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 74 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

6.Журмыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

ДАРГА, ТЭРГҮҮН КОМИССАР

Х.ЭНХЖАРГАЛ

**АЛБАН ТУШААЛТАН ӨӨРТ НОГДУУЛСАН САХИЛГЫН ШИЙТГЭЛИЙН ТАЛААРХ
МЭДЭЭЛЛИЙГ ХОЛБОГДОХ ЭТГЭЭД БОЛОН НИЙТЭД ӨӨРИЙН ЗАРДЛААР ХҮРГЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖУРАМ**

/Шинэчилсэн найруулга/

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар нийтийн албан тушаалтан (цаашид “албан тушаалтан” гэх) Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль(цаашид “Хууль” гэх)-ийг зөрчсөн тохиолдолд мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасан эрх бүхий албан тушаалтан нийтийн албан тушаалтанд хүлээлгэсэн сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг сахилгын зөрчлийн талаар мэдээлэгч, гомдол гаргагч, нийтийн албан тушаалтны хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн бусад этгээд (цаашид “холбогдох этгээд”)-д болон нийтэд өөрийн зардлаар хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү журмыг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1дэх хэсэгт заасан албан тушаалтан, эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасан сахилгын шийтгэл хүлээлгэх эрх бүхий албан тушаалтан дагаж мөрдөнө.

1.3. Албан тушаалтанд ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд хүргэхтэй холбогдон гарах шуудан холбооны зардал, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх үйлчилгээний үнэ, хөлсийг сахилгын шийтгэл хүлээсэн албан тушаалтан хариуцна.

1.4. Сахилгын шийтгэл хүлээлгэсэн тухай мэдээллийг бэлтгэх, холбогдох этгээдэд хүргэх, нийтэд мэдээлэх үүргийг сахилгын шийтгэл ногдуулах шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтан өөрийн байгууллагын Захиргааны асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид хариуцуулна.

1.5. Албан тушаалтанд ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээдэд хүргэх болон нийтэд мэдээлэхтэй холбогдон гарах зардлыг сахилгын шийтгэл хүлээсэн албан тушаалтнаас гаргуулан авах үүргийг энэ журмын 1.4-т дурдсан нэгжийн дарга хариуцан гүйцэтгэнэ.

1.6. Албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэсэн шийдвэрийн талаарх мэдээллийг уг шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор холбогдох этгээдэд хүргэж, нийтэд мэдээлнэ. Мэдээллийг холбогдох этгээдэд хүргэх, нийтэд мэдээлэхэд тухайн албан тушаалтнаас зөвшөөрөл авсан байхыг шаардахгүй.

1.7. Албан тушаалтанд ногдуулсан сахилгын шийтгэл нь шүүхийн шийдвэрээр үндэслэлгүй болох нь тогтоогдсон тохиолдолд мэдээллийг нэн даруй холбогдох этгээдэд хүргэж, нийтэд мэдээлнэ.

Хоёр. Холбогдох этгээдэд хүргэх

2.1. Албан тушаалтан сахилгын зөрчил гаргасан нь тогтоогдож, хууль тогтоомжид заасан шийтгэл хүлээлгэсэн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон тухайн албан тушаалтны харьяалах дээд шатны байгууллагын удирдлагад албан бичгээр хүргүүлнэ.

2.2. Харьяалах дээд шатны байгууллагын удирдлагад хүргүүлэх албан бичигт сахилгын шийтгэл хүлээлгэсэн шийдвэрийн хуулбарыг хавсаргана.

2.3. Хуульд заасан албан тушаалтанд хязгаарласан болон хориглосон хэм хэмжээг зөрчихгүй байх, ашиг сонирхлын зөрчил дахин гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэсэн тухай шийдвэрийг байгууллагын албан хаагчдад танилцуулна.

Гурав. Нийтэд мэдээлэх

3.1. Албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэсэн талаарх мэдээллийг дараахь хэлбэрийн аль нэгээр нийтэд мэдээлнэ.

3.1.1. Орон нутгийн болон үндэсний шинжтэй хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх;

3.1.2. Харьяалах байгууллагын цахим хуудсанд байршуулах;

3.1.3. Мэдээллийн самбарт байршуулах.

3.2. Журмын 3.1.2, 3.1.3-т заасан мэдээллийг Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 48 дугаар зүйлийн 48.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4 дэх хэсэгт заасан сахилгын шийтгэлгүйд тооцох хугацааг дуустал байршуулна.

3.3. Нийтэд хүргэх мэдээлэлд сахилгын шийтгэл хүлээсэн этгээдийн овог, нэр, байгууллагын нэр, албан тушаал, сахилгын шийтгэл хүлээлгэсэн үндэслэл, сахилгын шийтгэлийн төрлийг тусгана.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан талаарх мэдээллийг холбогдох этгээдэд хүргэсэн болон нийтэд мэдээлсэн өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор журмын 2.1, 3.1-т заасан мэдээллийг тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэр (хуулбар)-ын хамт эсхүл холбогдох мэдээллийг цахим хэлбэрээр Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.

4.2. Авлигатай тэмцэх газар хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2-т заасан хяналтыг хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зорилгоор эрх бүхий албан тушаалтнуудаас ирүүлсэн мэдээлэл, шийдвэрийг хүлээн авч, нэгдсэн сан үүсгэнэ. Сангийн мэдээлэл олон нийтэд нээлттэй байна.

4.3. Албан тушаалтанд ногдуулсан сахилгын шийтгэл нь шүүхийн шийдвэрээр үндэслэлгүй, эсхүл илт хууль бус акт болох нь тогтоогдсон, эсхүл Захиргааны ерөнхий хуульд зааснаар захиргааны байгууллага өөрөө хүчингүй болгосон, нэмэлт өөрчлөлт оруулсан бол энэ тухай баримтыг, санд өөрчлөлт оруулах саналын хамт ажлын 5 өдрийн дотор Авлигатай тэмцэх газартхүргүүлнэ.

4.4. Албан тушаалтанд ногдуулсан сахилгын шийтгэл нь шүүхийн шийдвэрээр үндэслэлгүй болох нь тогтоогдсон тохиолдолд энэ тухай журмын 1.4-т дурдсан нэгжээс холбогдох этгээдэд мэдэгдэх ба журмын 1.3-т заасан зардал, үйлчилгээний үнэ, хөлсийг буцаан олгохтой холбоотой асуудлыг Захиргааны ерөнхий хуулийн 101, 103 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

4.5. Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаар холбогдох этгээдэд хүргэх, нийтэд мэдээлэхтэй холбоотой зардлыг гаргаагүй нь мэдээлэл хүргэх, нийтэд мэдээлэхээс татгалзах үндэслэл болохгүй.

...o0o...



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар А/31

Улаанбаатар хот

МАЯГТ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Авлигын эсрэг хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.6-д заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.1-14.5, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2, 26.1-д заасныг баримтлан “Мэдүүлэг гаргагчийн ... оны хөрөнгө орлогын мэдүүлгийн хураангуй мэдээний маягт”-ыг нэгдүгээр, “Мэдүүлэг гаргагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн хураангуй мэдээний маягт”-ыг хоёрдугаар, “Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуй мэдээний маягт”-ыг гуравдугаар, “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн бүртгэлийн маягт”-ыг дөрөвдүгээр, “Оффшор бүсэд эзэмшиж байгаа банкны данс, өмчилж байгаа хөдлөх, үл хөдлөх хөрөнгө, байгуулсан хуулийн этгээдийн бүртгэлийн маягт”-ыг тавдугаар, “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг мэдүүлсэн тухай бүртгэлийн маягт”-ыг зургадугаар, “Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд гаргасан мэдэгдэл, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалд гаргасан тайлбар, шийдвэрлэлтийн бүртгэлийн маягт”-ыг долдугаар, “Мэдүүлэг гаргаж өгөөгүй, гаргахаас татгалзсан, хугацаа хожимдуулсан албан тушаалтны бүртгэлийн маягт”-ыг наймдугаар, “Давхар ажил эрхлэлтийн бүртгэлийн маягт”-ыг есдүгээр, “Гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүнээс бусад этгээдээс авсан бэлэг, үйлчилгээ, түүнийг авсныг мэдэгдсэн тухай бүртгэлийн маягт”-ыг аравдугаар хавсралтаар тус тус баталсугай. *(Энэ тушаалын 1 болон 2 дугаар хавсралтыг Авлигатай тэмцэх газрын даргын 2025 оны А/17 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.)*

2. Нийтийн албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлэг, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, тайлбар мэдэгдлийн болон холбогдох бусад бүртгэлийг шинэчилсэн маягтын дагуу бүртгэх, тушаалын хавсралтаар баталсан маягт, зааврыг эрх бүхий байгууллагуудад хүргүүлэх талаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч, улсын хэмжээний нэгдсэн тайлан, мэдээ гаргах ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс (эрхэлсэн комиссар Т.Энхболд)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан 2012 оны “Маягт батлах тухай” 91 дүгээр тушаал, 2017 оны “Тушаалд нэмэлт оруулах тухай” А/129 дүгээр тушаал, 2018 оны “Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/148 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалыг 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

ДАРГА, ТЭРГҮҮН КОМИССАР

З.ДАШДАВАА

(Энэ тушаалын 1 болон 2 дугаар хавсралтыг Авлигатай тэмцэх газрын даргын 2025 оны А/17 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.)



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

ТУШААЛЫН ХАВСРАЛТЫГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Авлигын эсрэг хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.6-д заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн “Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоол 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн “Маягт шинэчлэн батлах тухай” А/31 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Мэдүүлэг гаргагчийн ... оны хөрөнгө орлогын мэдүүлгийн хураангуй мэдээний маягт” болон хоёрдугаар хавсралтаар баталсан “Мэдүүлэг гаргагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн хураангуй мэдээний маягт”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Нийтийн албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлэг, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг шинэчилсэн маягтын дагуу бүртгэх талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, удирдлагаар хангаж ажиллахыг Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс (эрхэлсэн комиссар Т.Энхболд)-т үүрэг болгосугай.

3. Тушаалыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР

З.ДАШДАВАА

МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧИЙН ... ОНЫ ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН ХУРААНГУЙ МЭДЭЭНИЙ МАЯГТ

Мэдүүлэг гаргагч	Мэдүүлэг гаргагчийн өөрийн болон гэр бүлийн гишүүний	орлого (мян. төг)	Хуулийн этгээдэд өртүүлсэн хөрөнгө оруулалт, хувьцаа, бонд, бусад үнэт цаас	Хадгаламж, харилцах данс, картын үлдэгдэл, бэлэн мөнгө (мян. төг)	Виртуал хөрөнгө	Бусдаас авах авалрын үлдэгдэл нийт дүн (мян.төг)	Зээлийн үлдэгдэл нийт дүн (мян.төг)	Хуулийн этгээдийн нэр, хэлбэр	хөрөнгө оруулалтын төрөл, тоо	нийлүүлсэн, оруулсан хөрөнгийн хэмжээ (мян.төг) ноёдол хува	Эрх, патентын төрөл, тоо	Бэлэг, хандив, өв залгамжлал	47	46	45	44	43	42	41	40	39	38	37	36	35	34	33	32	31	30	29	28	27	26	25	24	23	22	21	20	19	18	17	16	15	14	13	12	11	10	9	8	7	6	5	4	3	2	1															
													нийт дүн (мян.төг)	төрөл																																																												
Мэдүүлэг гаргагч	Мэдүүлэг гаргасан үндэслэл	нийт дүн	мэдүүлэг гаргачийн орлого	гэр бүлийн гишүүний орлого	үүээс: хөрөнгө борлуулсны орлого	орон сууч, барилга, байгууламжийн үнийн нийт дүн (мян.төг)	төрөл, марк, тоо	нийт дүн (мян.төг)	тоног төхөөрмжийн нийт дүн (мян.төг)	төрөл, тоо	нийт дүн (мян.төг)	Мал, амьтан	Газар	Үнэт злэл, урлаг, түүх, соёлын үнэт зүйлийн нийт дүн (мян.төг)	Дотоодын банк, санхүүгийн байгууллага дахь хадгаламж, харилцах данс дахь үлдэгдэл	Гадаад улсын банк, санхүүгийн байгууллага дахь хадгаламж, харилцах данс дахь үлдэгдэл	Бэлэн мөнгө	Нийт дүн	төрөл, тоо	нийт дүн (мян.төг)	Бусдаас авах авалрын үлдэгдэл нийт дүн (мян.төг)	Зээлийн үлдэгдэл нийт дүн (мян.төг)	Хуулийн этгээдийн нэр, хэлбэр	хөрөнгө оруулалтын төрөл, тоо	нийлүүлсэн, оруулсан хөрөнгийн хэмжээ (мян.төг) ноёдол хува	Эрх, патентын төрөл, тоо	Бэлэг, хандив, өв залгамжлал	47	46	45	44	43	42	41	40	39	38	37	36	35	34	33	32	31	30	29	28	27	26	25	24	23	22	21	20	19	18	17	16	15	14	13	12	11	10	9	8	7	6	5	4	3	2	1

Энэ маягтыг Авлигатай тэмцэх газрын даргын 2025 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн А/17 дугаар тушаалаар шинэчилсэн.

Авлигатай тэмцэх газрын даргын
2025 оны 02 дугаар сарын 05-ны
өдрийн А/17 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧИЙН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛГИЙН ХУРААНГУЙ МЭДЭЭНИЙ МАЯГТ

№	Эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр	Эрхэлж байгаа албан тушаал, байгууллага	Томилогдсон /сонгогдсон огноо	Хамаарал бүхий этгээдийн нэр	Нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр	Гишүүнчлэлд байгаа хуулийн этгээд, ТББ-ын нэр	Давхар эрхэлж байгаа ажил, үүрэг, гэрээний ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл			Бэлэг, хандив, өв залгамжлал	
							байгууллага, албан тушаалын нэр	үйл ажиллагааны чиглэл	төрөл	нийт дүн (мян. төг)	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	

Энэ маягыг Авлигатай тэмцэх газрын даргын 2025 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн А/17 дугаар тушаалаар шинэчилсэн.

НИЙТИЙН АЛБАНД ТОМИЛОГДОХООР НЭР ДЭВШСЭН ЭТГЭЭДИЙН
ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН УРЬДЧИЛСАН МЭДҮҮЛГИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГТ

№	Нэр дэвшигч		Нэр дэвшсэн			Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг				АТГ-аас шийдвэрлэсэн байдал			
	Эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр	Одоо эрхэлж байгаа ажил, албан тушаал	Байгууллага, харьяа нэгж	Албан тушаал	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Мэдүүлэг гаргасан үндэслэл	Нэр дэвшигчээс баталгаажуулсан (мэдүүлсэн) огноо	АТГ-т хянуулахаар хүргүүлсэн албан бичгийн дугаар, огноо	АТГ-аас хянаж хариу мэдэгдсэн албан бичгийн дугаар, огноо	зөрчилгүй	зөрчил үүссэн	зөрчил үүсч болзошгүй (анхааруулсан)	буцаасан
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14

ОФФШОР БҮСЭД ЭЗЭМШИЖ БАЙГАА БАНКНЫ ДАНС, ӨМЧИЛЖ БАЙГАА ХӨДЛӨХ, ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ, БАЙГУУЛСАН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГТ

№	Мэдүүлэг гаргагчийн хамаарал бүхий этгээд		Оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэр	Оффшор бүсэд								Өмчийн байдалд орсон өөрчлөлт						Мэдэгдэл хүлээлгэн өгсөн				Тайлбар							
	Мэдүүлэг гаргагчийн хамаарал бүхий этгээд	Мөнгөн хөрөнгө байршуулсан, данс нээлттэсэн, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн		хувь нийлүүлэх замаар хуулийн этгээдүүдэд байгуулсан	Мөнгөн хөрөнгө байршуулсан, данс нээлттэсэн, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн зорилго			Нээлттэсэн Банкны данс хаалгасан	Банканд байршуулсан мөнгөн хөрөнгө татсан	Хөдөлөх, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг			Хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд байгуулсан бол	өгнөө (он, сар, өдөр)	хэлбэр														
					сүрэнцах	хөдөлмөр эхлэх	эмгэгчдийн тусламж үйлчилгээ авах			хуудалдсан	шижжүүлсэн	татсан			хуудалдсан	шижжүүлсэн	дүүрсгавар	хуудалдсан	шижжүүлсэн	дүүрсгавар									
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30

ХУВИЙН АШИГ СӨНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН ХӨРӨНГӨ,
ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙГ МЭДҮҮЛСЭН ТУХАЙ БҮРТГЭЛИЙН МАЯГТ

№	Мэдүүлэг гаргагч				Мэдүүлэг гаргасан үндэслэл			Мэдүүлгийн хугацаа			Мэдүүлэг хүлээлгэж өгсөн хэлбэр			
	Эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр	эрхэлж байгаа албан тушаал, байгууллага	албан тушаалын ангилал, зэрэглэл	Томилогдсон /сонгогдсон огноо	нийтийн албан тушаалд томилогдсон/сонгогдсон	мэдүүлгээ мэдүүлсний дараа хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн	тухайн албан тушаалыг хашиж байгаа хугацаандаа шинэчлэн гаргасан	Мэдүүлэх эрхийг үүсгэсэн (нээсэн) огноо	Мэдүүлэг гаргагчаас баталгаажуулсан (мэдүүлсэн) огноо	Мэдүүлгийг ЭБАТ-аас баталгаажуулсан огноо	Өөрийн биеэр	Баталгаат шуудангаар	Цахим шуудангаар	Бусад (итгэмжлэгдсэн төлөөлөгч, туслах г.м)
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15

АШИГ СӨНИРХЛЫН ЗӨРЧИЛ ҮҮССЭН, ҮҮСЧ БОЛЗОШГҮЙ НӨХЦӨЛД ГАРГАСАН МЭДЭГДЭЛ, АШИГ СӨНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ
ГЭЖ ОЙЛГОГДОХУЙЦ НӨХЦӨЛД ГАРГАСАН ТАЙЛБАР, ШИЙДВЭРЛЭЛТИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГТ

№	Нийтийн албан тушаалтны			Мэдэгдэл, тайлбар гаргасан огноо, үндэслэл				Мэдэгдэл, тайлбарын шийдвэрлэлт					
	Эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр	Эрхэлж байгаа албан тушаал, байгууллага	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Огноо				Тайлбар	Тухайн албан үүргийг өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсөн				
				Мэдэгдэл		зөрчилгүй үүссэн	зөрчил үүсч болов		зөрчил үүсч болохгүй гэж үзсэн				
				зөрчилгүй	зөрчил үүссэн								
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14

ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ГАРГАЖ ӨГӨӨГҮЙ, ГАРГАХААС
ТАТГАЛЗСАН, ХУГАЦАА ХОЖИМДУУЛСАН АЛБАН ТУШААЛТНЫ БҮРТГЭЛИЙН МАЯГТ

№	Мэдүүлэг гаргагч				Мэдүүлэг гаргах үндэслэл			Мэдүүлэг гаргаж өгөөгүй, гаргахаас татгалзсан, хугацаа хожимдуулсан шалтгаан	Мэдүүлэх эрхийг үүсгэсэн (нээсэн) огноо	Хариуцлага хүлээлгэсэн байдал	Тайлбар
	Эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр	Эрхэлж байгаа албан тушаал, байгууллага	Албан тушаалын ангилаг, зэрэглэл	Томилогдсон/ сонгогдсон огноо	нийтийн албан тушаалд томилогдсон/ сонгогдсон	мэдүүлээ мэдүүлсний дараа хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн	тухайн албан тушаалыг хашиж байгаа хугацаандаа шинэчлэн гаргасан				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

ДАВХАР АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГТ

Нийтийн албан тушаалтан					Давхар ажил эрхлэлт									
№	Эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр	Байгууллага, албан тушаал	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Томилогдсон/сонгогдсон огноо	Нийтийн албанд анх орох үед эрхэлж байгаа				Нийтийн албанд ажиллах хугацаанд					
					Хуулиар зөвшөөрөөгүй ажил үүрэг, гэрээний ажил гүйцэтгэж байгаа тухай дээд шатны албан тушаалтанд бичгээр танилцуулсан огноо	Шийдвэрлэлт			Цуцалсан, чөлөөлөгдсөн ийг эрх бүхий албан тушаалтанд мэдэгдсэн огноо	Давхар эрхэлж байгаа ажил үүрэг, гэрээний ажил	Удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрлийн огноо	Давхар ажил, үүрэг, гэрээний ажил гүйцэтгэж эхэлсэн огноо		
						Хуулиар зөвшөөрөөгүй ажил үүрэг, гэрээний ажил	Огноо	эрхэлж байгаа алба, ажил үүргээс чөлөөлөгдсөн					Гэрээ болон бусад явдлыг цуцалсан	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	

ГЭР БҮЛИЙН ГИШҮҮН БОЛОН ТӨРӨЛ, САДАНГИЙН ХҮНЭЭС БУСАД ЭТГЭЭДЭЭС АВСАН БЭЛЭГ, ҮЙЛЧИЛГЭЭ,
ТҮҮНИЙГ АВСНЫГ МЭДЭГДСЭН ТУХАЙ БҮРТГЭЛИЙН МАЯГТ

№	Нийтийн албан тушаалтан				Гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүнээс бусад этгээдээс авсан бэлэг, үйлчилгээ				Бэлэг, үйлчилгээг хүлээн авсан албан тушаалтны шийдвэр						
	Эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр	Байгууллага, албан тушаал	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Томилогдсон/сонгогдсон огноо	Хүлээн авсан огноо	Мөнгөн дүн /төгрөг/		Эх үүсвэрийн тайлбар	Бэлэг, үйлчилгээ авсан тухай бичгээр мэдэгдсэн огноо	Төрийн өмчид шилжүүлсэн	Шийдвэрлэсэн огноо /шилжилт/	Бэлэг, үйлчилгээний үнэ, хөлсний зөрүү өөрөө төлж тухайн бэлэг, үйлчилгээг хүлээн авсан	Шийдвэрлэсэн огноо /хүлээн авсан/	Тайлбар	
						нэг удаагийн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны нэг сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн	нэг эхсурвалжаас нэг жилийн туршид хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны гурван сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн								
1	2	3	4	5	6	7	8	9	11	12	13	14	15	16	

АГУУЛГА

Нэг. ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ КОНВЕНЦ	3
Авлигын эсрэг НҮБ-ын конвенц	3
 Хоёр. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ	42
Авлигын эсрэг хууль	42
Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль	62
 Гурав. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ	78
- Улсын Их Хурлын Хууль Зүйн Байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн “Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоол	78
- Улсын Их Хурлын Хууль Зүйн Байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн “Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 01 дүгээр тогтоол	80
1 дүгээр хавсралт: “Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хадгалах журам”	81
2 дугаар хавсралт: “Мэдүүлэг гаргагчийн ... оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт”	89
3 дугаар хавсралт: “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн маягт”	96
4 дүгээр хавсралт: “Ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарын маягт”	100
5 дугаар хавсралт: “Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт”	102
6 дугаар хавсралт: “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргасан тухай баталгааны маягт”	107
7 дугаар хавсралт: “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргасан тухай баталгааны маягт”	108
8 дугаар хавсралт: “Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахим хэлбэрээр гаргасан тухай баталгааны маягт”	109
9 дүгээр хавсралт: “Мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны баталгааны маягт”	110
10 дугаар хавсралт: “Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”	111
 Дөрөв. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ	114
Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 326 дугаар тогтоол “Жагсаалт шинэчлэн батлах тухай”	114
Хавсралт: “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан гадаад улс, түүний нутаг дэвсгэрийн жагсаалт”	115

Тав. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ	116
1. Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн А/45 дугаар тушаал “Маягт, заавар батлах тухай”	116
Хавсралт: “Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн 20.... оны тайлан”-гийн маягт	117
2. Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/122 дугаар тушаал “Журам батлах тухай”	122
1 дүгээр хавсралт: “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар иргэдэд мэдээлэл өгөх журам”	123
2 дугаар хавсралт: “Мэдээлэл авах хүсэлт гаргах маягт”	125
- Авлигатай тэмцэх газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/18 дугаар тушаал “Тушаалын хавсралтыг шинэчлэн батлах тухай”	127
3 дугаар хавсралт: “Албан тушаалтны оны хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуй мэдээлэл”	128
4 дүгээр хавсралт: “Албан тушаалтны оны ашиг сонирхлын мэдүүлгийн хураангуй мэдээлэл”	129
3. Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаал “Журам батлах тухай”	130
Хавсралт: “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”	131
4. Авлигатай тэмцэх газрын даргын 2023 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн А/31 дүгээр тушаал “Маягт шинэчлэн батлах тухай”	133
- Авлигатай тэмцэх газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/17 дугаар тушаал “Тушаалын хавсралтыг шинэчлэн батлах тухай”	134
1 дүгээр хавсралт: “Мэдүүлэг гаргагчийн ... оны хөрөнгө орлогын мэдүүлгийн хураангуй мэдээний маягт”	135
2 дугаар хавсралт: “Мэдүүлэг гаргагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн хураангуй мэдээний маягт”	136
3 дугаар хавсралт: “Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуй мэдээний маягт”	137
4 дүгээр хавсралт: “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн бүртгэлийн маягт”	138
5 дугаар хавсралт: “Оффшор бүсэд эзэмшиж байгаа банкны данс, өмчилж байгаа хөдлөх, үл хөдлөх хөрөнгө, байгуулсан хуулийн этгээдийн бүртгэлийн маягт”	139
6 дугаар хавсралт: “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг мэдүүлсэн тухай бүртгэлийн маягт”	140
7 дугаар хавсралт: “Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд гаргасан мэдэгдэл, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөлд гаргасан тайлбар, шийдвэрлэлтийн бүртгэлийн маягт”	141
8 дугаар хавсралт: “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргаж өгөөгүй, гаргахаас татгалзсан, хугацаа хожимдуулсан албан тушаалтны бүртгэлийн маягт”	142
9 дүгээр хавсралт: “Давхар ажил эрхлэлтийн бүртгэлийн маягт”	143
10 дугаар хавсралт: “Гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүнээс бусад этгээдээс авсан бэлэг, үйлчилгээ, түүнийг авсныг мэдэгдсэн тухай бүртгэлийн маягт”	144

*Мударга ёс,
хөгжил дэвшилд*



МОНГОЛ УЛС, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

5-р хороолол, Сөүлийн гудамж 41, Улаанбаатар хот 14250



www.iaac.mn



АТГ–Олон нийтийн төв

ISBN 999738322-2



9 789997 383228